

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
12 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	2 – 20
	21 – 162
<i>1. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашиунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	22 – 77
<i>2. Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/</i>	77 – 79
<i>3. Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	79 – 126
<i>4. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашиунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	126 – 138
<i>5. Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно</i>	138 – 160
<i>6. Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно</i>	160 – 162

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 27-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны
ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Б.Бат-Эрдэнэ, Ш.Бямбасүрэн;

Чөлөөтэй: Д.Ганмаа, Ч.Номин, О.Номинчимэг, Б.Тулга;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Батцэцэг, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, С.Лүндэг, Д.Пүрэвдаваа, Д.Рэгдэл, Л.Энхнасан;

Тасалсан: Н.Алтанхуяг, О.Амгаланбаатар, Х.Баттулга, Да.Цогтбаатар;

Хоцорсон: Н.Алтаншагай – 1 цаг 24 минут, С.Амарсайхан – 21 минут, Ц.Баатархүү – 15 минут, Б.Батбаатар- 02 минут, Д.Батбаяр – 03 минут, Х.Болормаа – 01 минут, Ж.Галбадрах – 19 минут, Г.Ганбаатар – 40 минут, С.Ганбаатар – 15 минут, Д.Ганбат – 21 минут, Л.Гантөмөр – 10 минут, Б.Жавхлан – 01 минут, Б.Жаргалан – 04 минут, Д.Жаргалсайхан – 11 минут, Б.Заяабал – 1 цаг 58 минут, Ж.Золжаргал – 08 минут, Т.Мөнхсайхан – 19 минут, П.Мөнхтулга – 1 цаг 58 минут, З.Мэндсайхан – 19 минут, П.Наранбаяр – 38 минут, Н.Номтойбаяр – 02 минут, Э.Одбаяр – 1 цаг 19 минут, С.Одонтуяа – 20 минут, Б.Пунсалмаа – 10 минут, П.Сайнзориг – 02, Н.Учрал – 1 цаг 19 минут, Д.Цогтбаатар – 1 цаг 06 минут, Ж.Чинбүрэн – 1 цаг 19 минут, Б.Чойжилсүрэн – 10 минут, Ж.Энхбаяр – 2 цаг 03 минут, Д.Энхтуяа – 08 минут, С.Эрдэнэбат – 06 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 5 гишүүнээс 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Хуулийн төсөл татан авах тухай албан бичиг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо. /10:09/

Нэг.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын дэд захирал Б.Батмагнай, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий, Гадаад харилцааны яамны Хилийн хэлтсийн дарга Т.Баяржаргал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга О.Цэрэндондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Байнгын хороодын ажлын албаны референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан танилцуулна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Энхтүвшин, Ц.Мөнхбат, Ж.Ганбаатар, Ж.Алдаржавхлан, Ж.Баярмаа, Г.Очирбат, П.Сайнзориг, Н.Номтойбаяр, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “төмөр замын бүтээн байгуулалтын” гэснийг “төмөр замын тээврийн хүчин чадлын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 31

Бүгд: 102

69.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын “бууруулахгүй” гэсний дараа “, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн олборлолтын төлөвлөгөөтэй нийцүүлэн коксжих, сул коксжих, эрчим хүчний нүүрсийг зохимжит хувь харьцаагаар нийлүүлэх буюу зөвхөн нэг төрлийн нүүрсийг сорчлохгүй байх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 43

Бүгд: 102

57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Батбаяр, Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Р.Эрдэнэбүрэн, Р.Батболд, М.Сарнай, М.Нарантуяа-Нара, О.Саранчулуун, М.Энхцэцэг, Б.Хэрлэн, Х.Булгантуяа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 10 дахь дэд заалтын “үе шаттайгаар” гэснийг “зэрэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан үг хэлж, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дээрх саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Д.Амарбаясгалан: 4.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “харилцан ашигтай” гэсний дараа “хувилбарт шийдэл бүхий гэрээний хүрээнд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, О.Батнайрамдал үг хэлж, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дээрх саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Д.Амарбаясгалан: 5.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “дэд бүтцийн бүтээн байгуулалт,” гэсний дараа “орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутагт ажлын байр шинээр бий болгох,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 35

Бүгд: 102

65.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 6.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Байтаг-Улиастайн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, Булган-Такашикен боомтод улсын хилийн 126, 127 дугаар тэмдгийн хооронд авто замаар улсын хилийн шугамыг дайран өнгөрөх цэгийг тохирч, хилийн гарц дээр шинээр нэмэх, нүүрс ачиж буулгах талбай, ачаа тээврийн терминал болон улсын хил дамнасан авто замын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэх талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохиролцох.” гэсэн 11 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дээрх саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Д.Амарбаясгалан: 7.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд “Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай” хэлэлцээр байгуулах ажлыг анхаарах.” гэсэн дэд заалт шинээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлж, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дээрх саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Д.Амарбаясгалан: 8.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Бүтээн байгуулалтын болон олборлолтын бүх үе шатад Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.” гэсэн дэд заалт шинээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дээрх саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Д.Амарбаясгалан: 9.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Төмөр замын ачаа тээвэрт хоёр тал тэгш эрхтэй байх, Монгол Улсын бусад аж ахуйн нэгж, байгууллагын ачааг тээвэрлэх боломжтой байх.” гэсэн дэд заалт шинээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан үг хэлж, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дээрх саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Д.Амарбаясгалан: 10.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дахь заалтын “Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Г.Тэмүүлэн/-нд” гэснийг “Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 40

Бүгд: 103

61.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төсөл дэх нэр томъёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд “тээврийн багтаамж” гэснийг “тээврийн хүчин чадал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин үг хэлж, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 62
Бүгд: 103
39.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

12.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Дээрх саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 43
Бүгд: 103
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 58 минут үргэлжилж, 12 цаг 01 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 12 цаг 44 минутад эхлэв.

Хоёр.Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төсөл дэх нэр томъёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд “Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн” гэснийг “Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, С.Замира нар үг хэлж, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 57
Бүгд: 103
44.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 51
Бүгд: 104
51.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Тогтоолын төсөл дэх нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд “Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн” гэснийг “Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 48
Бүгд: 104
53.8 хувийн саналаар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төсөл дэх нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд “эдийн засгийн үр ашиг” гэснийг “эдийн засгийн өгөөж” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин үг хэлж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дээрх саналын томьёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын “16-г хүртэл жилээр тогтоох” гэсний дараа “нүүрсийг “Ганцмод боомт” нөхцөлөөр нийлүүлэх, тээврийг Монголын тал хариуцан гүйцэтгэх агуулгаар тохиролцох” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлж, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 47
Бүгд: 104
54.8 хувийн саналаар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын “жишиг болгож” гэснийг “зах зээлийн өнөөгийн нөхцөлд нийцүүлэн өөрчилж, суурь үнийг шинэчилж, үнийн индексийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын болон олон улсын зах зээл дээрх үнийн мэдээлэл, Монголын хөрөнгийн биржээр худалдаалсан нүүрсний үнийн мэдээллийг

ашиглан тооцоолох,” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 44
Бүгд: 105

58.1 хувийн саналаар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 5 дахь дэд заалтыг “Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн /үүнээс 7 сая тонн нь баяжуулсан нүүрс/, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонн /үүнээс 5 сая тонн нь баяжуулсан нүүрс/-оос бууруулахгүй байх гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 48
Бүгд: 105

54.3 хувийн саналаар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын “бууруулахгүй байх” гэсний өмнө “Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад нийлүүлэх нүүрсний нийт хэмжээг жилд 120 сая тонноос багагүй хэмжээнд хүргэх тохиролцоог хийх” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 43
Бүгд: 105

59.0 хувийн саналаар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад Монгол Улсын тэргүүлэх чиглэлийн 14 мега төслийн “Хэрлэн-

Тооно” ус дамжуулах шугам хоолой татах бүтээн байгуулалтын ажлыг хамтран гүйцэтгэх гэрээ, хэлцлийг 2025 оноос эхлэхээр зохион байгуулалтын арга хэмжээ авах” гэсэн дэд заалт шинээр нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат үг хэлэв.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 52

Бүгд: 105

50.5 хувийн саналаар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтын “хамтын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх” гэснийг “ажлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцан зохион байгуулах хүрээнд оператор аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулах” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 54

Бүгд: 105

48.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 46

Бүгд: 105

56.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтын “хамтын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх” гэснийг “ажлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцан зохион байгуулах хүрээнд оператор аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулах” гэж өөрчлөх гэсэн

Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 40
Бүгд: 105

61.9 хувийн саналаар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

9. Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 9 дэх дэд заалтыг бүхэлд нь хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 50
Бүгд: 105

52.4 хувийн саналаар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасны дагуу зарчмын зөрүүтэй 10, 11, 12 дахь саналыг татаж байгаагаа мэдэгдэв.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, мөн газрын Олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Г.Болормаа нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны

ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан хуулийн төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 13 цаг 17 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах санал хураалтыг түр хойшлуулав.

Уг асуудлыг 13 цаг 20 минутад хэлэлцэв.

Гурав.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн бодлого хариуцсан зөвлөх Г.Ганболд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны зөвлөх Б.Энхсайхан, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарсанаа, “Шинэ Хархорум” бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны хуулийн мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын хуулийн мэргэжилтэн С.Энхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, хуулийн төслийн талаар Төрийн

байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах, Ж.Алдаржавхлан, А.Ганбаатар, Ж.Баярмаа, С.Эрдэнэболд, Б.Батбаатар, Г.Хосбаяр, П.Ганзориг, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 15 цаг 03 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, С.Эрдэнэболд нар үг хэлэв.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн санал хураалтыг түр хойшлуулав.

Уг асуудлыг 15 цаг 21 минутад хэлэлцэв.

Дөрөв. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнанасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын дэд захирал Б.Батмагнай, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий, Гадаад харилцааны яамны Хилийн хэлтсийн дарга Т.Баяржаргал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга О.Цэрэндондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Байнгын хороодын ажлын албаны референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан, Ж.Алдаржавхлан, Д.Энхтүвшин, Д.Ганбат нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Тогтоолын төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “харилцан ашигтай” гэсний дараа “хувилбарт шийдэл бүхий нөхцөлөөр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 49
Бүгд: 104
52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Байтаг-Улиастайн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, Булган-Такашикен боомтод улсын хилийн 126, 127 дугаар дугаар тэмдгийн хооронд автозамаар улсын хилийн шугамыг дайран өнгөрөх цэгийг тохирч, хилийн гарц шинээр нэмэх, нүүрс ачиж буулгах талбай, ачаа тээврийн терминал болон улсын хил дамнасан авто замын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэх талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохиролцох.” гэсэн 11 дэх дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 45
Бүгд: 104

56.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Тогтоолын төсөл дэх нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “эдийн засгийн үр ашгийг” гэснийг “эдийн засгийн өгөөжийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 35

Бүгд: 104

66.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 36

Бүгд: 104

65.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн бодлого хариуцсан зөвлөх Г.Ганболд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны зөвлөх Б.Энхсайхан, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарсанаа, “Шинэ Хархорум” бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны хуулийн мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын хуулийн мэргэжилтэн С.Энхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 32
Бүгд: 104
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 34
Бүгд: 104
67.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, Б.Бейсен, Г.Ганбаатар, Б.Жаргалан, Б.Пунсалмаа, Ц.Туваан, Э.Болормаа, Д.Энхтүвшин, Б.Заяабал нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 76.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78
Татгалзсан: 26
Бүгд: 104
75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар “Хархорум хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75

Татгалзсан: 29

Бүгд: 104

72.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар “Хархорум хотын эдэлбэр газрын хил заагийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 31

Бүгд: 104

70.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хархорум хотын бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх, хэлэлцүүлэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, мөн газрын Олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Г.Болормаа нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны саналаар Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80

Татгалзсан: 26

Бүгд: 105

76.2 хувийн саналаар хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно

Хэлэлцэж бус асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх М.Тулгат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Бат-Өлзий, мөн газрын Салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч Г.Энхтулга, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, “И-Монгол Академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хяналт шалгалтын газрын дарга Т.Нармандах, ахлах зөвлөх Ч.Онончимэг, ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаарх мэдээллийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан, Улсын Их Хурлын гишүүн, ХҮН намын төлөөлөл П.Ганзориг, Улсын Их Хурлын гишүүн, Үндэсний эвслийн

төлөөлөл А.Ундраа, Улсын Их Хурлын гишүүн, Иргэний Зориг ногоон намын төлөөлөл Б.Батбаатар нар төв индэр дээрээс үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, О.Цогтгэрэл, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаарх мэдээллийг Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Улаанбаатар хотын Дулааны III цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./16:54/

2.Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./16:54/

3.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал санал хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:55/

Уг асуудлыг 16 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 10 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 103 гишүүн ирж, 81.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 03 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Гишүүдийн ирц хүрсэн байна 71 гишүүн буюу 56.3 хувь хүрсэн учраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар дараах 6 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрдугаарт, Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвдүгээрт, “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Үдээс хойших хуралдаанаар Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Зургадугаарт, Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатад санаачилсан хуулийн

төслөө татан авч болно гэж, 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн хуулийн төсөл нь хэлэлцүүлгийн аль ч шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын 5 гишүүнээс 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Хуулийн төсөл татан авах тухай Улсын Их Хурал 03/80/24 дугаартай албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Хуулийн төсөл татан авах тухай.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг миний бие болон Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, Н.Батсүмбэрэл нарын гишүүдээс 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийг татан авах саналыг хүргүүлж байна гэсэн.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 5 гишүүнээс 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг татан авсанд тооцлоо. /алх цохив/

Хэлэлцэх асуудалд оръё.

Нэг. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан танилцуулна.

Индэрт урьж байна.

Ж.Алдаржавхлан: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэлийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2024 оны 12 сарын 26-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо руу шилжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам бүтээн байгуулалтын хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэлийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж төслийн 1 дэх заалтад “Байтаг-Улиастайн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, Булган-Такашикен боомтод улсын хилийн 126, 127 дугаар тэмдгийн хооронд авто замаар улсын хилийн шугамыг дайран өнгөрөх цэгийг тохирон хилийн гарц гарч шинээр нэмэх, нүүрс ачиж буулгах талбай, ачаа тээврийн терминал болон улсын хил дамнасан авто замын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэх талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохиролцох” гэсэн агуулга бүхий 11 дугаартай дэд заалтыг шинээр нэмэх, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг төслийн 1 дэх заалтад “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд “Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай” хэлэлцээрийг байгуулах ажлыг анхаарах” гэсэн агуулга бүхий дэд заалт шинээр нэмэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан төслийн 1 дэх заалтад “Төмөр замын ачаа тээвэрт хоёр тал тэгш эрхтэй байх, Монгол Улсын бусад аж ахуйн нэгж, байгууллагын ачаа тээвэрлэх боломжтой байх.” гэсэн агуулга бүхий дэд заалт шинээр нэмэх зарчмын зөрүүтэй санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүд дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ж.Золжаргал, О.Батнайрамдал, Р.Сэддорж, Б.Жаргалан, Г.Очирбат нар тогтоолын төслийг нэр томьёо жигдлэх, найруулга, дэс дугаарлалтыг өөрчлөх, төслийн холбогдох дэд заалтад орон нутгийн хөгжлийг дэмжих, нүүрсний үнэ, төмөр замын ачаа тээвэрлэлт, бүтээн байгуулалтын талаар зохицуулалтыг тодорхой тусгах чиглэлээр зарчмын зөрүүтэй 24 саналын томьёолол гаргасныг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр бүлэглэн томьёолж зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Сэрээтэрийн Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Гончигсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Баярын Хулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга, Бямбаа-Юугийн Артур Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Хүчитбаатарын Итгэлт Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Батзаяагийн Батмагнай Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын дэд захирал, Даваадоржийн Бат-Өлзий Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал, Түргэнбаярын Баяржаргал Гадаад харилцааны яамны Хилийн хэлтсийн дарга, Хүүгийн Мөнхжаргал “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эрдэнийн Түвшинжаргал “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал, Осоржамаагийн Цэрэндондог “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга.

Уул уурхайн яамны албан тушаалтнууд, Зам, тээврийн яамны албан тушаалтнууд хаана байна? Гадаад яамны албан тушаалтнууд хаана байна?

Өнөөдөр Улсын Их Хурал Эрдэнэс Тавантолгойн гэрээ хэлэлцээгүй шүү.

Засгийн газар хоорондын хэлэлцээр хэлэлцэж байгаа. Энэ яамдын холбогдох албан тушаалтан нэрээ энэ ажлын хэсгийн жагсаалтад оруулчхаад ирээгүй байна.

Энэ чинь хариуцлагатай асуудал шүү дээ. Улсын Их Хуралд нэрээ ирүүлчихсэн. Өөрсдөө ирээгүй сууж байна гэдэг хариуцлагын асуудал шүү.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нийт 13 гишүүн нэрсээ ирүүлсэн байна.

Отгоншарын Батнайрамдал. Алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Товчхон нэг асуулт байна. Энэ өгч байгаа үндсэн чиглэл дээр болоод дагалдаж байгаа гэрээний төсөл дээр уул уурхайн бүтээгдэхүүнийг урт хугацаагаар гэрээлэх тухай харилцаа энд орж ирсэн байгаа. 27 сая тонн. Дахиад жил бүрийн 20 сая тонн гээд.

Тэгэхээр энэ өөрөө уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр зарах ёстой тэр хуулийн зүйл, заалттай урт хугацаанд гэрээ хийхдээ заавал биржийн арилжааны дундаж үнийг баримтална энэ тэр гэсэн нөгөө биржийн зүйл, заалттай хэрхэн зохицож байгаа вэ?

Магадгүй шаардлагатай бол энэ Биржээр арилжаалах тухай хуулийн зүйл, заалтыг энд оруулж ирэх ёстой байсан уу, үгүй юу? Энэ дээр яг хуулийн гарц гаргалгаа нь ямарваа нэгэн тийм зөрчил саадгүй байгаа юу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Үндсэндээ бирж биржээр биш арилжааг энэ хөрөнгө оруулалтын хамтарсан гэрээн дээр шууд тусгаад хийчих боломж бололцоонууд нь байгаа юу гэж Улсын Их Хурлын тогтоолыг дагалдуулаад.

Д.Амарбаясгалан: Р.Сэддорж дарга. Хэн хариулт өгөх вэ? Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбоотой асуудал явж байгаа. Биржийн хуультай зөрчилдөж байгаа эсэхтэй холбоотой асуудал.

Ц.Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: О.Цогтгэрэл бүлгийн даргын асуултад хариулъя.

Энэ Монгол Улсад Уул уурхайн биржийн тухай хууль хэрэгжээд явж байгаа. Энэ хуулийн дагуу уул уурхайн биржийн үйл ажиллагаа хэвийн цаашдаа хэрэгжээд явна. Үүнийгээ бид мөрдөж ажиллана.

Бас үүний хажуугаар Эрдэнэс Тавантолгой компани Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн болон хувийн өмчит 4 компанид нүүрсийг урт хугацааны гэрээгээр борлуулж байгаа.

Мөн бидний энэ хэлэлцээрт орж байгаа нөгөө тал буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Чайна Энержи” компани бол бид нарт энэ хоёр дахь гэрээ буюу нүүрс худалдах, худалдан авах гэрээн дээрээ бид хэд хоёр талаасаа ажлын хэсэг эхний төмөр зам ашиглалтад орох хугацаанд буюу эхний 2025-2029 онд 27 сая тонн, цаашдаа жил болгон 20 сая тонн нүүрсийг борлуулах гэрээний асуудал яригдаж байгаа.

Тэгээд энэ дээр өнөөдрийн Эрдэнэс Тавантолгой компанийн борлуулж байгаа үнийг баримталъя гэдэг ийм зүйлийг ярьж байгаа.

Тэгэхээр Монгол Улсад Үндсэн хууль, тэгээд дээрээс нь олон улсын гэрээ хэлэлцээр, тэгээд бусад хууль гэсэн ийм эрэмбийн дарааллаар бас хэрэгжээд явдаг.

Тэгэхээр бид Засгийн газар хоорондын хоёр талын хэлэлцээрийг баталсан тохиолдолд энэ хэлэлцээрт орсон байдлаар асуудал шийдэгдээд явна гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Ямар ч байсан энэ хавьд нэг тийм хуулийн зөрчил харагдаад байгаа шүү.

Тэгээд үүнийгээ хөрш оронтойгоо эдийн засгийн хамтын ажиллагааг дараа хуулийн маргаангүй хийхийн тулд тэр хууль, эрх зүйн хувьд сайн үзэж харж хийх шаардлагатай байх аа.

“Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр зарна”, “урт хугацааныхыг дундаж үнийг баримталж ажиллана” гээд тов тодорхой заачихсан зүйл, заалт цаана чинь байж байгаа шүү.

Тэгэхээр үүнийг дараа дараагийн хэлэлцээрийн явцад болоод дараагийн хэлэлцээрийн явцад хуулийн төслийг шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн маргаангүй л юм хийхгүй бол тэгээд дахиад хойноо баахан асуудал чирсэн зүйл. Нэгэнт ингэж нийтээрээ зөвшилцөөд гаргаж байгаа, намын бүлгүүд бүгдээрээ дэмжиж байгаа энэ цаг үе дээрээ хуулийн маргаангүй зүйл гаргаж авахад хичээж ажиллах нь зүйтэй байх шүү гэдэг санал хэлье.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Тогтоолын төслийн энэ 11 дээр байгаа “эрчим хүчний нүүрс” экспортлох гэдэгтэй холбоотой асуулт байгаа. Тэгээд энэ 11 дээр “эрчим хүчний нүүрс экспортлох” гэдгийг тусад нь тавьчихсан байгаа.

Тэгэхээр яах вэ, ер нь Тавантолгойн ордын хувьд бараг тал нь эрчим хүчний нүүрс байгаа. Тэгээд сүүлийн жилүүдэд, өнгөрсөн хугацаанд илүү бид дандаа коксжих нүүрсүүдээ экспортолсон. Өөрөөр хэлбэл олборлолтын нөхцөл байдлуудын хувьд ч гэсэн эрчим хүчний нүүрсний овоолгын хэмжээ нэмэгдчихсэн, олборлолтын нөхцөл байдал бас нэлээн хүндэрчихсэн байгаа.

Тэгэхээр бид эрчим хүчний нүүрсийг одоо яг энэ, ялангуяа “Чайна Энержи” бол эрчим хүчний нүүрсний давуу талтай. Гангийн болон кокс, химийн гэхээсээ илүү цахилгаан станцууд, эрчим хүчний нүүрс дээр ийм давуу талтай. Эд нартай ингэж ажилладаг, түгээдэг, хэрэглэдэг ийм давуу талтай төрийн өмчит компани байгаа.

Тэгэхээр энэ давуу талыг нь ашиглах үүднээс “эрчим хүчний нүүрс” гэдгийгээ тусад нь 11 дээр ингээд салгаад оруулчихаар нөгөө өмнөх байгаа, энэ 4 дээр байгаа, 5 дээр байгаа нүүрс худалдаж, худалдан авах гэрээ энэ 2 дээр бас байгаа.

Гэдэг дотор “эрчим хүчний нүүрс” орохгүй юм шиг ойлголт төрөхөөр яваад байгаа. Үүнийг зүгээр боломж байдаг болбол хэлэлцээрийн явцад бас эрчим хүчний нүүрсийгээ тусад нь 11 дээр салгаж биш бусад үндсэн заалтад тэр “нүүрс” гэдэг дотроо оруулж явах тийм яриа хэлэлцээр явж байгаа юу гэдэг талаар тодруулж асуух хэрэгтэй байна.

Тэгэхгүй бол ер нь цаашдаа их хэмжээний эрчим хүчний нүүрс олборлочихоор энэ нь өөрөө шатдаг, хийсдэг, байгаль орчинд хортой нөлөө үзүүлнэ.

Тэгэхээр энэ талаасаа эрчим хүчний нүүрсийг төмөр зам орсон дээрээ хамгийн эхэнд борлуулах ёстой нүүрс байгаа. Өөрөөр хэлбэл зардал тээвэр дааж чадахгүй, тээврийн зардал дааж чадахгүй байсан болбол энэ төмөр зам орсноор тээврийн зардлын шингээлт сайтай болоод илүү зарж борлуулах ийм бололцоо гарна.

Тэгээд энэ талаар яриа хэлэлцээр дээр ямар байдалтай байгаа гэдэг талаар тодруулмаар байна.

Дараагийнх нь, өчигдөр Б.Дэлгэрсайхан сайдаас Эдийн засгийн байнгын хороон дээр асуусан. Энэ дээр нүүрс худалдаж, худалдан авах гэрээн дээр хоёр үндэслэл байгаа.

Нэг нь, “тээврийн хүчин чадалтай холбоотой”. Нөгөөдөх нь, “эдийн засгийн үр ашгийг хангахтай холбоотой” байгаа.

Тээврийн хүчин чадлын талаар асуултыг өчигдөр Б.Дэлгэрсайхан сайд хариулчихсан.

Зүгээр энэ эдийн засгийн үр өгөөжийн талаар Гашуунсухайт-Ганцмодны боомтын эдийн засгийн үр өгөөж нь яг миний ойлгосноор үүнийг хоёр талаасаа Монголын тал Монголынхоо мөнгийг Эрдэнэс Тавантолгой гаргана, Хятадын тал нь өөрсдийнхөө мөнгөө гаргана.

Тэгэхээр яг энэ богинохон төмөр замын хөрөнгө оруулалт нь хэд болоод, тэгээд энэ нь ямар хугацааны дараа энэ эдийн засгийн өгөөж буюу хөрөнгө оруулалтын өгөөжөө төлөх юм? Ямар үнээр энэ богино хил холболтын төмөр замын үнэ тариф нь явах юм? Энэ олсон ашгаа яаж хуваах юм? Өмчлөлийн хувьд. Энэ талаар одоо тодруулах ийм хоёр асуулт байна.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Д.Энхтүвшин гишүүний эхний асуултад хариулъя.

Энэ дээр. Тийм. Ер нь бид одоо энэ Хятадын төрийн өмчтэй “Чайна Энержи” компани бол өөрөө эрчим хүчний компани. Нүүрсийг бас дотооддоо олборлолт хийдэг. Гадааддаа Австрали, Индонез гээд Монгол гээд улсуудаас бас худалдан авдаг ийм компани. Жилдээ 800 сая тонн нүүрсийг хэрэглэдэг ийм компани байгаа.

Тэгэхээр энэ дээр “эрчим хүчний нүүрс” үлдэх асуудал байхгүй.

Бид бүхэн энэ компанитай хийх гэрээн дээрээ ажлын хэсэг дээр 3 нүүрсний асуудал гурвуулаа яригдаж байгаа.

Тэр нь юу вэ гэхээр гуравны нэг нь коксжих нүүрс, эрчим хүчний нүүрсүүд яригдаж байгаа. Үнийн хувьд мэдээж ялгаатай. Манай бирж дээр ч гэсэн одоо энэ 3 төрлөөрөө борлуулагдаж байгаа. Гурвуулаа ондоо үнээр борлуулагдаж байгаа ийм нүүрсний асуудал байгаа.

Тэгэхээр бид бас энэ уул уурхайн Эрдэнэс Тавантолгойн ордоо бас ингээд дан коксжих нүүрсээ зараад эрчим хүчний нүүрс үлдэх гэдэг энэ асуудлыг ярилцдаг.

Эрдэнэс Тавантолгойн орд гэхэд өөрөө нүүрсний 13 давхаргаас бүрддэг. Үүний тодорхой 2 давхаргад нь коксжих нүүрс байгаа.

Тэгэхээр ойролцоогоор 20 орчим хувьд нь коксжих нүүрс.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье.

Ц.Туваан: Коксжих нүүрс байгаа.

Тэгэхээр бусад сул коксжих болон эрчим хүчний нүүрсээ борлуулах асуудал яригдаж байгаа.

Дээрээс нь энэ 11 дүгээр заалт бол бид Хятадын төрийн өмчит бусад компаниудтай. Одоо жишээлбэл бас манайд “Эрдэнэс Монгол” гээд компани толгой компани. Тэгээд дотор нь одоо энэ уул уурхайн чиглэлийн компаниуд орчихсон байдаг шиг Хятадын төрийн өмчит компаниудтай энэ гэрээг хийсний дараа дараагийн бүтээн байгуулалтын болон борлуулах хамтын ажиллагааны асуудлуудыг бас хамтад нь 11 дүгээр зүйл, заалт дээрээ ярилцаж байгаа ийм сэдэв байгаа.

Тэгэхээр энэ дээр бид нарт илүү байгаа, бас нэлээн түгээмэл нөөц ихтэй байгаа эрчим хүчний нүүрснийхээ борлуулах асуудлыг тусгаж оруулж өгсөн гэдгийг хэлье.

Хоёр дахь асуулт дээр нь Б.Дэлгэрсайхан сайд.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмэлт хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Өчигдөр Бйнгын хороон дээр тээврийн хүчин чадлын тухай ойлголт өгсөн.

Бид энэ төмөр замыг холбосноороо коксжсон нүүрс гэхээсээ илүү эрчим хүчний нүүрсний үнэ, тарифыг, ялангуяа үнийн нэлээн нөлөөлөх тийм ач холбогдолтой учраас төмөр зам холболтод эрчим хүчний нүүрсийг экспортлоход чухал ач холбогдолтой гэдгийг энэ ташрамд бас хэлье. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, та сая асуулаа. Тэгээд төмөр зам бол 5.8 жилийн хугацаанд өртгөө нөхнө өө.

Өнөөдрийн байдлаар бидний хийж байгаа тооцоогоор 1 тонн нүүрсийг 45 центээр зөөвөрлөхөөр ингэж тооцоо гаргасан байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Өнөөдөр бидний хэлэлцэж байгаа энэ төмөр замын хил холболтын асуудал олон жил гацсан. Эдийн засгийн хувьд үр өгөөжтэй гэдэг олон утга агуулгаар эсрэг байр суурь илэрхийлж байгаа хүн бол ховорхон байгаа байх.

Үүнийг бүгд дэмжээд явуулах ёстой гэж үзэж байгаа.

Тэгэхдээ тэр гэрээ хэлцэл дунд бас зарим нэг зайлшгүй бодох ёстой юмнууд бол байгаа. Үүнийг хэлэхгүй байж болохгүй.

Бид хил холболт хийгээд, “Чайна Энержи” компанитай нүүрс борлуулах гэрээгээ хийгээд, урт хугацаандаа хийгээд явна.

Эхний хэдэн жил мэдээж тогтвортой гэдэг юм уу, өсөлттэй гэдэг юм уу ийм үнээр явахыг үүсгэхгүй. Ер нь бараг тэгэх болов уу гэж зүгээр төсөөлж байгаа юм.

Хэдэн жилийн дараа энэ үнээ буулгаад, манай нөгөө нүүрс экспортолдог, борлуулдаг, бусад үндэсний аж ахуйн нэгжүүдэд нөлөөлөх ийм хэмжээнд хүрэх нөхцөл байдал үүсэх үү? Үүнийг энэ гэрээн дээр яаж зохицуулдаг юм уу, тусгадаг юм уу? Одоо тийм юм байна уу гэж асуумаар байгаа юм.

Бусад нэг өдөр нүүрс авах нөгөө хязгаарлалтаа тавиад, хэмжээгээ бууруулаад, үнээ багасгаад ингээд эхлэхээр бусад аж ахуйн нэгжүүдэд нөгөөх нь нөлөөлөөд, цаашлаад энэ нь улс орны эдийн засагт нөлөөлөөд явах дээр ямар зохицуулалтуудыг хийж байгаа вэ гэдэг нэг ийм зүйл байгаа юм.

Хоёрдугаарт нь, миний бас нэг яриад байгаа зүйл бол манай 4 боомтоор гарч ирж байгаа нүүрсний үнийг индексжүүлж дундаас нь үнэ гаргана гээд байгааг нөгөө бусад орнуудтай жишиж олон улсын үнэтэй уялдуулах ийм бодлогыг энд яаж оруулж болохоор байна? Энэ боломж бий юу гэдэг ийм хоёр зүйлийг асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Цэвэгдоржийн Туваан сайд.

Ц.Туваан: Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулъя.

Энэ 3 хэлэлцээрийн гэрээний хоёрдугаар асуудал дээр нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний асуудал байгаа.

Тэгэхээр олон улсад бол ер нь энэ нүүрсний худалдааг бол урт хугацаанд гэрээгээр арилждаг ийм зүйл байгаа.

Тэгэхээр ер нь сүүлийн үед манай яаман дээр байгаа судалгаагаар энэ нүүрсний хэрэглээ болон үнийн асуудал дээр эрчим хүчний нүүрсэн дээр дэлхийн чиг хандлага ер нь ногоон эрчим хүчний чиглэл рүү шилжиж байгаа учраас бас тодорхой, одоо тухайлах юм бол 2035-2040 он дээр эрчим хүчний нүүрсний хэрэглээ бас аажим бага зэрэг буурах ийм tendency_[хандлага] зарагдаж байгаа.

Харин коксжих буюу гангийн үйлдвэрлэлд хэрэглэдэг өндөр калоритой нүүрсний хэрэглээ бол хэвээрээ байна гэсэн ийм судалгаа байгаа.

Энэ борлуулах гэрээ 27 сая тонн бол 5 жилийн хэмжээ байгаа. Энэ жилдээ ойролцоогоор 5-аас 6 сая тонны эхний 5 жилдээ борлуулалтын асуудал яригдаж байгаа.

Тэгэхээр энэ өнөөдрийн борлуулж байгаа 85 сая тоннтой харьцуулахад бага хувь байгаа.

Тэгээд давхар энэ төмөр зам ашиглалтад ороод нүүрс борлуулахаас гадна давхар авто замаар борлуулж байгаа, авто тээврээр борлуулж байгаа, ачиж хүргэж байгаа асуудал зэрэгцээд явна.

2030 оноос хойш бид бусад боомтуудынхаа хилийг холбоод нүүрсний экспортоо 120-иос бүр цаашилбал 165 сая тонн хүртэл нэмэгдүүлнэ гэж байгаа. Энэ дотор 20 сая тонн бол бас тодорхой 10 гаруй хувийг эзлэх ийм асуудал байгаа.

Тэгэхээр энэ бол бусад компаниудын үнэ, биржийн арилжаа энэ тэр бол зэрэгцээд хэвээрээ явна гэдгийг хэлье.

Үнэ бодох аргачлал дээр энэ хоёр дахь гэрээний үнийн аргачлалын хэсэг дээр хоёр тал яг эцэслэн ажлын хэсэг дээрээ бол бас тохироогүй байгаа.

Тэгэхээр нөгөө талаас тавьж байгаа санал бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын одоо Эрдэнэс Тавантолгой компаниас худалдаж авч байгаа бусад компанийн үнийг жишиг болгож бодвол яасан юм бэ гэдэг ийм саналыг тавьсан.

Өөрөө энэ үнэ бол Хятадын 5 боомтын нүүрсний борлуулалтын үнийн индексүүд дээр суурь үнийг нэмээд ингээд тодорхой хувилж гардаг. Энэ үнэ бол тогтмол байхгүй. 3 сар болгон буюу улирал тутам тэр мэдээллүүдээ аваад өөрчлөгдөж байх ийм үнэ байгаа гэдгийг хэлье.

Мөн одоо тэр олон улсын биржүүдийн үнэ энэ тэрийг өчигдөр гишүүд хэлсэн. Энэ асуудлыг бид бас тооцож ярилцана гэдгийг энд хэлье.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Ганбаатар: Ц.Туваан сайдын сая яриад байгаа урт хугацаатай гээд байгаа компаниуд үнээ өсгөх үүрэгтэй шүү дээ. Тийм үүрэг бол хүлээгээд 2 жил болж байгаа. Биржийн үнэнд дөхүүлэх үүрэгтэй. Тэр гэрээний үнэ байнга өсөөд явж байх ёстой. Өөрсдөө тийм бичгээ өгсөн. Тэрийгээ хүлээн зөвшөөрсөн байдаг шүү. Тэрийг уул уурхайн сайд анхаараарай.

Хоёрдугаарт, Эрдэнэс Тавантолгой компани 2025 онд хэдэн сая тонн нүүрс экспортолно гэж төлөвлөсөн байгаа юу? Одоо. Нэгдүгээр улиралд хэд юм? Хоёрдугаар улиралд хэд юм? Гуравдугаар улиралд хэд юм?

Өнөөдөр 35 гарсан байж магадгүй байх. Сүүлд харахад 32, 33 байсан. Одоо тэр 5, 6 тоо нь нэмэгдээд ямар төлөвлөгөөтэй байгаа вэ гэдгийг сонсьё. Нэгдүгээр улирал, хоёрдугаар улирал. Зөв хэлээрэй.

Тэгээд би тэгээд нэгдүгээр улиралд шахна шүү. Яг яаж гаргасан бэ гэдгийг чинь.

Хоёрдугаарт, Ц.Туваан сайд ч гэсэн хэлэхгүй байх юм. Эрдэнэс Тавантолгой ч. Энэ урт хугацааны яг энэ төмөр замын холболттой бол Биржийн тухай хуульд өөрчлөлт орчихсон байгаа шүү дээ. Биржийн тухай хуульд 2023 онд өөрчлөлт ороод урт хугацаатай яг энэ төмөр замын холболтод орвол биржээр арилжаалахгүй байж болно гээд Биржийн тухай хуульд өөрчлөлт орчихсон байгаа. Үүнийгээ хэлээрэй. Энэ чинь хуулийн дагуу шүү гэдгийг хэлсэн нь зөв биз дээ.

Тэгээд өчигдөр бас Байнгын хороон дээр хэлж байна лээ. Бартер гэдэг зүйл байхгүй гэж. Үүнийгээ албан ёсоор хэлээдхээрэй бас. Ямар нэгэн бартер байхгүй. Дандаа бэлэн мөнгөөр.

Монгол Улс чинь одоо ингээд 83 сая тонн нүүрс зарна гээд төсвөө баталчихсан. Тэгээд нэгдүгээр улиралд, хоёрдугаар улиралд янз янзын зүйл яриад одоо энэнээс боллоо, тэрнээс боллоо, орлого тасарлаа гэдэг зүйл байхгүй биз дээ. Яг албан ёсоор хариулмаар байна. Эсвэл Б.Дэлгэрсайхан сайд хариулах юм уу? Албан ёсоор яг хариулмаар байна.

Тийм зүйл байхгүй ээ. Орлого тасрахгүй ээ. Тодотгол хийхгүй ээ гээд. Үүнийг албан ёсоор сонсмоор байна.

Дараа нь, өчигдөр сорчилж нүүрс авахгүй ээ. Бид бүх гаргаж байгаа нүүрсээ бүгдийг нь өгнө өө. Тэрийгээ бас албан ёсоор хэлээдэх. Сорчилж нүүрс өгөхгүй ээ. Наад 4 компани чинь дөрвүүлээ их л сонин юм ярьдаг юм даа.

Одоо шинээр гэрээ байгуулах гэж байгаа чинь сорчилж нүүрс авахгүй ээ гэдгийгээ албан ёсоор сонсьё. Тэгээд тэр бартер авахгүй юм байна. Тэгээд Эрдэнэс Тавантолгой компани яг нэгдүгээр улирлаас эхлээд л бараг 15 сая тонн нүүрс экспортлох шаардлагатай болж байх шиг байна л даа.

Тэгээд би бол тэгж л ойлгож байна. Хамгийн багадаа 10. Асуучхаад өөрөө хариулахгүй бол нэгхэн минутын тодотгол дээр юм ярьж болдоггүй юм л даа. Уул нь 1 минут асуучхаад 3 минут тодотгомоор байгаа юм. Хариулт сонсчхоод тодруулъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

Х.Мөнхжаргал: Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал байна.

Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

“Эрдэнэс Тавантолгой” компани биржийн арилжаа эхэлснээс хойш нийтдээ 25 сая тонн нүүрсийг биржээр арилжаалсан байгаа. Үүний 10 сая тонныг 2023 онд, 15 сая тонныг 2024 онд арилжаа хийгдээд, үүн дотор 2024 онд коксжих нүүрс 3 сая, сул коксжих 9 сая, эрчим хүчний нүүрс 3 сая гэсэн. Сорчлохгүйгээр борлуулах бодлогыг баримталж ажиллаж байгаа.

2025 онд одоо энэ “Чайна Энержи” компанийн 5 сая тонн нүүрсний борлуулалтыг тооцохгүйгээр компанийн зүгээс нийтдээ 30 сая тонн нүүрс борлуулна гэсэн төлөвлөгөө оруулаад төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлуулахаар хүлээгдэж байгаа.

Үүн дээр нэмээд “Чайна Энержи”-гийн 5 сая нэмэхээр нийтдээ 35 сая тонныг 2025 онд борлуулна гэсэн хүлээлттэй байгаа.

Нэгдүгээр улирлын хувьд “Эрдэнэс Тавантолгой” компанийн нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орсонтой холбоотой бас баяжуулах нүүрсний борлуулалт биржээр борлуулах борлуулалтын бас нэг шинэ бүтээгдэхүүн нэмэгдсэн. Үүнтэй нийлээд эхний нэгдүгээр улиралд 4.3 сая тонн нүүрсийг борлуулах тийм зорилтыг тавьж ажиллаад байгаа. Зөвхөн биржээр. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Өчигдөр Ж.Ганбаатар гишүүний Байнгын хороон дээр асуусан асуултыг нэмж хариулъя.

Ер нь бид хийх гэж байгаа энэ гэрээнд ямар нэгэн байдлаар өөрийн чинь хэлдгээр ямар нэгэн коксжих нүүрсийг илүү сорчлохгүй байх, мөн коксжих, эрчим хүчний нүүрсийг зохимжит хэмжээнд хувь харьцаагаар нийлүүлэх, зөвхөн нэг төрлийн нүүрсийг сорчлохгүй байх гэдэг ийм асуудлыг тавьсан.

Тэгээд үүнийг өнөөдрийн Байнгын хорооны саналын зөрүүтэй томьёололд оруулж эндээ оруулъя гэдэг ийм саналтай байгаа.

Гэхдээ бид өнөөдөр хоёр Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах, баримтлах үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд одоогийн ярьж байгаа энэ зүйлүүдийг тэмдэглэж аваад, үүндээ оруулахгүйгээр компаниуд хоорондоо гэрээгээ хийхдээ нарийвчилж оруулъя гэдэг ийм бодлого баримтлаад хоорондоо бас ярилцаад явж байгаа.

Тээврийн хувьд ямар нэгэн асуудалгүй явна гэдгийг. Өөрөөр хэлбэл одоо өнгөрч байгаа 2024 онд 32 сая тонныг ямар ч асуудалгүй тээвэрлэсэн. Энэ нь

одоо бас тээврийн үнэ тарифтай холбоотой асуудал байсан. Ирэх жил 2025 онд яг энэ бодлогоороо цаашаа явна гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Ганбаатар: Энэ яг хийх гэж байгаа зүйлээ яг хийгээрэй дээ. Нэг, хоёрдугаар улиралд өөр юм ярив аа. Тэгээд ярих юм бол тэгээд хариуцлагаа өөрсдөө хүлээгээрэй. Энд нэг ийм юм ярьчихаад яг биелэлт дээрээ шал өөр юм ярих вий дээ.

Одоо наадхыг чинь харахаар ойролцоогоор 90 сая тонн. Ядаж хил гаалиа 24 цаг болгохгүй бол болохгүй. Б.Дэлгэрсайхан сайд аа.

24 цаг болгох хэрэгтэй. Наад “Эрдэнэс Тавантолгой” компани тусдаа гарцтай болох хэрэгтэй.

“Оюу Толгой” тусдаа гарцтай байгаад байхад “Эрдэнэс Тавантолгой” яагаад тусдаа гарцтай байж болохгүй байна. Оюу Толгойн тусдаа гарцыг хамт ашиглах хэрэгтэй шүү дээ. Тэр гарц чинь 3-хан цаг болчихоод хаагдчихдаг юм байна лээ. Оюу Толгойн хэдэн цуваа яваад л тэгээд л хаагдчихдаг. Тэрийг нь ашиглая гээд зөндөө явсан шүү дээ. Б.Тулга сайд мэдэж байгаа. Маш сайн урагшилсан. Тэгэхгүй бол энэ 90 сая чинь амжихгүй шүү. Тэгээд сүүлд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Би одоо түрүүчийн чуулган дээр асуулт асуухад хариултыг нь гүйцэд өгөхгүй байгаа юм. Дахиад асууя.

Нэгдүгээрт, одоо энэ чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол гарах гээд байна шүү дээ. Ц.Туваан сайд аа. Тэгээд энэ дээр чинь та бүгд 2025-2029 онд 27 сая тонн нүүрс гаргана гээд ингээд хатуу заачихсан байгаа байхгүй юу. Тэгээд нөхцөл байдал өөрчлөгдөөд илүү гарвал яах вэ? Та нар Улсын Их Хурлын тогтоол зөрчинө шүү дээ.

Тэгэхээр энэ тоогоо яг ингээд тэр чигээр нь явуулахад та ингээд зөвшөөрч байна уу?

Хоёрдугаарт, 30 оноос эхлээд 20 сая тонноос дээшээ гаргана гээд байгаа байхгүй юу. Энэ чинь тэгээд хязгааргүй дээшээ юм уу? Монголын бүх нүүрс энэ хөнгөлөлттэй гарцаар чинь гарвал яах вэ? Ингэж хязгааргүй дээшээ хаях шаардлага байсан уу, үгүй юу гэж. Энэ хоёр асуултад хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Бид бүхэн ажлын хэсгийн 60 удаагийн хуралдаан дээр бас энэ асуудлууд нэлээн яригдаад хоёр талаасаа энэ хэмжээн дээрээ ирж байгаа. 2025-аас буюу ирэх жилээс 2029 он хүртэлх 5 жилийн хугацаанд эхний 3 жил 5, 5, дараагийн 2 жил нь 6, 6 сая тонн нүүрсийг өнөөдрийн “Эрдэнэс Тавантолгой”-н олборлож байгаа амнаас нэмж олборлож борлуулна гэсэн ийм төсөөлөлтэй явж байгаа.

Тэгэхээр одоо яг энэ хэмжээг баримтална гэсэн байдлаар оруулж ирж байгаа. 5 сая тонн, 6 сая тонн гээд.

Цаашдаа 2030 оноос төмөр замын хил холболт явагдаад, борлуулалт нэмэгдсэн үед 20 сая тонн гээд ер нь эндээ барих хэмжээгээ л бид хэд оруулж ирж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд энэ дээшээ одоо бас хязгааргүй явахгүй. Үүнтэй холбоотой бас зэрэгцээд авто тээврээр тээвэрлэлт явагдана. Дээрээс нь уул уурхайн биржийн арилжаанууд бас давхар явагдана гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Үгүй үгүй. Ийм байна шүү дээ. Ц.Туваан сайд аа. Одоо тэр гарц чинь одоо бид төмөр зам тавихад гарц чинь дискаунтлагдсан гарц гээд.

Тэгэхээр чинь Хятадууд чинь түүгээрээ авъя гээд байвал бид явуулахгүй гээд нэмэргүй шүү дээ.

Тэгэхээр ингэж задгай дээшээ тавьж өгөх шаардлага байна уу л гээд байгаа байхгүй юу. Бүр бууруулахгүй гэдэг чинь дээшээ энэ хязгааргүй гэсэн үг шүү дээ. Үүнээс дээшээ л байна гэсэн үг байхгүй юу. Ерөөсөө.

Тэгэхээр та хэд эндээ 20-иор бид барина гэж мянга бодоод нэгэнт ингээд гарцыг нь нээгээд өгчих юм бол Хятадууд чинь бүх нүүрсээ тэр гарцаар чинь чихвэл яах вэ л гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг чинь өөрчилж болохгүй юм уу л гээд өчигдрөөс хойш би асуугаад та нар ерөөсөө ингээд яг бодитой хариулт өгөхгүй юм. Энэ чинь эргээд эрсдэл үүсэх юм биш үү? Бид дотроо ярьж болно. Бид 20 саяыг бодож. Гэтэл нөхдүүд чинь бид үүгээр чи авъя гээд байвал одоо яах вэ л гэж байгаа юм. Энэ дээр одоо нэг хариулт өгчих.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Өчигдөр уг нь Байнгын хороон дээр их тодорхой ярьсан. Ер нь 2025-2029 оны хооронд өгөх 27 сая тонн нүүрс маань бол бид өнөөдрийн Эрдэнэс

Тавантолгойн олборлож байгаа энэ хүчин чадлаа одоо максимум дээд хэмжээнд нь тулгачихсан тоо гэдгийг бас та зөв ойлгоорой. Үүнээс илүү нэмэгдэх ямар ч боломж бололцоо байхгүй ээ.

Зүгээр айлын, одоо урд хөршид бол энэ 27 сая тонн гэдгийг тавьсан шалтгаан бол бид энэ хоорондоо төмөр замаа барьж дуусаад, жигдрүүлээд, ингэх хугацаа нь өөрсдийнхөө хүчин чадал, бололцоог ашиглах нэг цаг хугацаа авч байгаа.

Нөгөө талаар шинэ ам нээхэд чинь хайгуулаа хийнэ, нөөцөө тогтооно, түүний дараа хэдэн метрийн доороос нүүрсээ олборлох юм гээд энэ цаг хугацаатай уялдуулж энэ тоог тавьсан юм.

Д.Амарбаясгалан: Нэмж минут өгье.

Б.Дэлгэрсайхан: Үүнээс илүү нэмэх ямар ч боломж бололцоо байхгүй ээ.

Бид бараг гүйцээж өгч чадах уу, үгүй юу гэдэг дээрээ байгаа гэдгийг энд хэлье.

Хоёрдугаарт, 2030 оноос хойш 20 сая гэдэг бол яг “Чайна Энержи”-тэй хийж байгаа үнэ 20 саяас илүү гарахгүй. Хэрэв олборлолт илүү гараад цаашаа явдаг юм бол биржийн үнээрээ явна гэдгийг би энд зориуд хэлье. Тэгээд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Яг хаана тийм заалт байгаад байгаа юм? Б.Дэлгэрсайхан сайд тэрийг тодорхойлж өгөөч. Эсвэл Хятадуудтайгаа яг 20-иос илүүгүй тохирох тохирсон юм бол энэ дээрээ 20 гээд оруулчихъя л даа. 20 саяас бууруулахгүй биш 20 сая тонн гээд л оруулчихъя л даа.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Үгүй ээ. Та нэг юмыг ойлго. Бид өнөөдөр төмөр замаа холбох асуудлыг л өнөөдрийн энэ хоёр улсын гэрээн дээр тулгуурлаж байгаа.

Тэгэхээр 20 сая гээд заачихвал энэ төмөр замаар өөр нүүрс явахгүй болчихвол яах вэ гэдэг эрсдэл байгааг олоод 20 буюу түүнээс дээш л гэж оруулж өгч байгаа юм. Төмөр замаа аль болохоор бид максимум дээд хэмжээнд нь ашиглаж аль болохоор төмөр замынхаа өртөг мөнгөө хурдан түргэн хугацаанд олж авч, ингэснээрээ тээврийн зардлын үнэ төмөр замаар явснаараа хямдрах энэ бололцоог л хурдан хугацаанд нөхөх ийм бодлого барьж байгаа шүү дээ.

Тийм учраас яг 20 гээд тулгачхаж бол болно. Би бол тантай санал нэг байна. Тэгтэл 20-ийг авна, илүүг авахгүй гээд төмөр замаа хаавал яах вэ гэдгийг бодож байгаа байхгүй юу. Тэр талаас нь бас та ойлгоорой гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэг нь нүүрс олборлож зарах юм яриад, нэг нь төмөр замаар тээвэрлэх юм хариулаад болж өгдөггүй. Дараагийн хариулт дээрээ жоохон тодорхой хариулах нь зүйтэй байх.

Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Тэгээд одоо ёстой нөгөө 14 мега төслүүдийн чинь нэн чухал, нэн шаардлагатай төслүүд л яг ойрын хэд хоног яригдаж байна л даа.

Юун нөгөө 5.4 их наядын Богд уулын нүхлэх, ган татлагат гүүр, юун нөгөө 1.2 их наядын хиймэл дагуул.

Маш ач холбогдол бүхий жинхэнэ нийгэм, эдийн засгийн үр ашигтай ийм Монгол Улсад нэн шаардлагатай төслүүд ярьж байгаад баяртай байна.

Тэгээд үүнийг яах вэ, алдагдсан боломжийн тухай яриад юу гэх вэ. Одоо ингээд хаая гээд байх шиг байна лээ. Тэгж болохгүй л дээ. Энэ бол бид нартай холбоотой учраас үр хойчдоо дахиж ийм юм гаргуулахгүйн тулд байнга ярьж байх хэрэгтэй, захиж байх хэрэгтэй.

Айлын тал нийт 13.9 тэрбум юанийн алдагдалд хүрч байна гэж ярьсан байна. Яах вэ, энэ дотор нөгөө барьсан өртгөө, ирээдүйд барих өртгөө бас оруулчхаж байна.

Яг жинхэнэ алдагдал нь гээд төмөр замаа барьснаас хойших алдагдал гэвэл 2.7 их наяд гээд. Энэ нь төгрөгөөр авч үзэх юм бол 6.6 их наяд төгрөг байна.

Монголын тал 2015 оноос хойш 2023 оны хооронд зөвхөн энэ 9 жилд хэрвээ экспортод нүүрс гаргасан бол 232 сая тонн нүүрс гаргах байсан юм байна. Энэ нь 18.5 тэрбум доллар. Өөрөөр хэлбэл 63.8 их наяд.

Тэгээд бидний хойд хөршөөсөө зээл авч өргөтгөл хийх үү, үгүй юу гээд хэрүүл хийгээд суугаад байгаа мөнгөн дүнтэй харьцуулах юм бол энэ чинь одоо 1 мегаваттыг 1.5 сая гээд тооцох юм бол 12.3 мянган ийм мегаватт цахилгаан, дулааны станц барих хэмжээний мөнгө. Энэ бол алдагдсан боломж. Бид үүнийг ярих хэрэгтэй. Заавал ч үгүй.

Яагаад гэвэл үүнээс үүдэж дараа дараагийн энэ мега төслүүд маань гацахгүй байх ёстой.

Тэгээд хоёр, гуравхан асуулт байна. Энэ Ганцмод боомт бол бас харьцангуй хөгжиж байгаа боомт юм билээ.

Тэгэхээр энэ төслийн үр дүнд Гашуунсухайт боомт ер нь хэр их хөгжиж яах юм бол оо?

Дээрээс нь, хэр олон тээврийн жолооч нар тэнд ажилтай орлоготой байна? Тэгээд тэд нараас хэд нь төмөр зам ашиглалтад ороод явахад ажилгүй болох вэ? Тэр олон жолооч нар тэр ар дээр нь байгаа ар гэрийнхэн нь яг яаж шилжих вэ? Ямар ажлын байр луу шилжих юм бол. Энэ талаар бодож байгаа тооцоо, судалгаа байгаа юм болов уу? Мөн хэрхэн хөгжих вэ гээд.

Тэгээд үнэ дээр Ц.Туваан сайд аргачлалаа маш тодорхой зураглаад гаргаад танилцуулмаар байгаа юм. Ийм ийм аргачлалаар ингэж өдий төгрөг болох юм гээд. Тэгэхгүй бол үнэтэй холбоотой асуултууд маш их ирж байна л даа.

Тэгээд бас нэг санаа зовж байгаа юм юу гэвэл магадгүй дахиад хоёр шинэ орд нээх гэж байгаа. 2030 оноос. “Онч хараат”, “Бор толгой”.

Тэр үеийн олборлолтын өртөг нь нэмэгдээд ирэхийн цагт энэ үнэ чинь бас буруу болж эхлэх юм биш үү? Өртөг нь нэмэгдээд, тооцоолоогүй дүн гарч ирэх юм бол бидний зарах гээд 16 жилийн турш гэрээ байгуулчихсан энэ мөнгөн дүнг чинь бас асуудалд орох юм биш биз дээ. Ийм хоёр, гурван асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд эхний асуултад хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Би бас Ж.Баярмаа гишүүнтэй санал нэг байна.

Бид ингээд урд хөршийн л алдагдсан боломжийг яриад байдаг. Өөрсдийн алдагдсан боломжоо ярьдаггүй. Тэгээд үнэхээр одоо таны гаргаж хэлж байгаа тооцоогоор бол бид 18.5 тэрбум долларыг олох ёстой байсан гэдэг.

Энэ бол одоо бид дотооддоо ярих асуудал. Бид дотооддоо хэрүүлээ хийх ёстой. Өнөөдөр хоёр улсын хоорондох энэ гэрээ хэлэлцээр дээр үүнийг ярих нь хэр байдаг юм. Би мэдэхгүй байна.

Ер нь цаашдаа ярих ёстой юу гэвэл ярих ёстой.

Ганц мод боомтын хувьд хөгжиж байгаа нь үнэн. Гашуунсухайт боомтын хувьд хөгжинө. Бид өнгөрсөн жил энэ хот, тосгоны болоод нутаг дэвсгэрийн

засаг захиргааны хуулийг баталсан. Энэ дагуу Гашуунсухайт боомт маань тосгон болж хөгжинө.

Ер нь энэ боомтуудаа сумын статустай ийм тосгон болгож хөгжүүлнэ. Өнөөдрийн байдлаар Ганцмодод 10-аас 15 мянга гаруй хүн амьдарч байна. Гашуунсухайтад.

Хэдэн жолооч байгаа юм бэ гэж та асуулаа. Ойролцоогоор 20 мянган машины бүртгэлтэй байдаг. Тоогоороо. Өнөөдөр Зам, тээврийн яаман дээр байгаа тоогоороо. Газар дээрээ бодитойгоор 7800 машин явж байна. Энэ хэдхэн хоногийн өмнө өөрийн биеэр очиж уулзаж авсан тоо. Энэ дээр 3500 жолооч ажиллаж байгаа. Хоёр машины хооронд нэг жолооч ажилладаг юм байна лээ.

Тэгэхээр цаашдаа бид аль болохоор жолооч нарынхаа тоог нэмэх, нүүрс олборлоод цаашаа явахад төмөр зам холбогдлоо ч гэсэн бид машинаар гаргах тоо хэмжээгээ бууруулахгүй.

Тийм учраас одоо энэ ажлын байр бол ямар нэгэн хэмжээгээр алдагдахгүй. Цаашдаа харин Гашуунсухайт Ганцмод дээр аль болохоор хүмүүсийн амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, төрийн үйлчилгээ тэнд хүргэх тэр боломж бололцоог засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуулийн дагуу энэ 2025 оны 6 сарын 01-нээс энэ хууль хэрэгжиж эхэлнэ. Энэ үеэс одоо бид бүтээн байгуулалтын ажлаа хамт авч явна.

Өчигдөр манай Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж дарга маань хэлсэн. Аль болохоор одоо бид энэ боомтоо хөгжүүлэх, одоо тэр орон нутагт ажиллаж амьдарч байгаа иргэдийг ажил төрөлтэй болгох дээр онцгой анхаараарай. Үүнийг оруулж өгөөрэй гэсэн. Бид үүнийгээ гэрээндээ тусгаж өгнө гэдгийг хэлье. Баярлалаа. Надад хамаарах асуудлыг нь би хариулчихлаа.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд асуултад хариулъя.

Ц.Туваан: Бид бүхэн энэ 3 гэрээний хоёр дахь асуудал бол нүүрс худалдах, худалдан авах гэрээний асуудал байгаа.

Тэгээд бид бол энэ дээр ямар нэгэн, түрүүн Ж.Ганбаатар сайд ч гэсэн хэлж байсан. Бартерын асуудал байхгүй. Бид мөнгөөр энэ нүүрсээ зарах асуудал яригдаж байгаа шүү. Бид борлуулж байгаа гэж манайхан ойлгомоор байна.

Нөгөө талаас маш олон удаа ярилцсан. Тэгэхдээ одоо та нар манай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 4 компанитай борлуулж байгаа нүүрсний үнээрээ л бид нарт өгчих өө. Бид нарт одоо өөр янз бүрийн тийм өөр томъёогоор бодох хэрэггүй. Энэ үнэтэйгээ адилхан нөхцөлийг л санал болгочих гэдэг ийм байдал байгаа. Тэгээд энэ үнийг нь боддог аргачлалыг, би бас түрүүн үнэ тогтдог аргачлалыг яриад байгаа. Тэр суурь үнэ, нэмэх нь Бүгд Найрамдах Хятад Ард

Улсын 5 боомтын нүүрсний борлуулалтын үнийн индексийг тодорхой хувиар хувьчилж аваад гаргадаг ийм үнэ байгаа. Үнэ бол тогтвортой биш. Улирал тутам хөвд хөдөлдөг ийм үнэ байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь 3 дахь гэрээний асуудал буюу энэ уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр энэ дээр одоогийн манай Эрдэнэс Тавантолгойн олборлож байгаа олборлолт бол одоо дээд хүчин чадлаараа ажиллаад энэ 30 сая тонн нүүрсний олборлолтыг хийж байгаа.

Тэгэхээр бид дахиад 2030 оноос хойш 20 сая тонныг борлуулах, дахиад цаашаа 120-иос 160 сая тонн хүргэх ийм зорилгодоо хүрэхийн тулд бид 2 шинэ амыг нээж ажиллуулна гээд энэ дээрээ нээлттэй тендер зарлаад энд шалгарсан компани нь тэр 2 шинэ аман дээр операторын үүрэг гүйцэтгээд явах юм байгаа юм.

Мэдээж энэ дээр өртгийн хувьд ойролцоо өртөгтэй байна гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Г.Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Өдрийн мэнд хүргэе. Тэгээд 14-ийн мега төсөл хөдөлж байгаад үнэхээр баярлаж байгаа. Бас энэ том ажлыг явуулж энэ хэлэлцээрийн ард гарч байгаа манай хамтарсан Засгийн газрын сайд нартаа, тэр дундаа Цэвэгдоржийн Туваан сайддаа бас баяр хүргэе.

Ингээд хэлэлцээрийн 11 дээрээс ганц, хоёр юм асуучихмаар байгаа юм. Төслийн 11 дээр “говийг усжуулах” гээд зүгээр нэг ийм олон ийм зүйл заалтын дунд ингээд оруулчихаад байгаа юм.

Тэгэхээр ер нь бид энэ говийг бүсчилсэн хөгжлийн хүрээнд ч тэр, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр дээр ч тэр энэ “аж үйлдвэрийн бүс болгоно” гээд зарлачихсан байгаа. Тэгээд яг амьдрал дээрээ яваад очихоор бүс болох боломж байхгүй. Яагаад гэхээр тэнд ус байхгүй юм билээ.

Боомт дээр нь очоод ажиллаад үзэхээр асар их хөрөнгө оруулалт хийчихсэн. Гараа угаах гэхээр ус байхгүй. Нольд нь ороод усаа татах гэхээр ус байхгүй. Тэгээд боомтынх нь 55-аас 70 километрийн цаанаас усаа татдаг. Аж үйлдвэрийн салбарынх нь үйлдвэрлэгч нар баяжуулах үйлдвэрийнх нь хамт олон тэр аж ахуйн нэгжүүдэд ус байхгүй.

Тэгэхээр энд хөгжил бол аж үйлдвэрийн бүс болох боломжгүй гэхихсэн байгаа.

Тэгэхээр бид Улсын Их Хурлын тогтоолын 11 дүгээр заалтыг задлаад усыг тусад нь авч үзвэл яасан юм бэ гэсэн саналыг Эдийн засгийн байнгын хороон дээр дэвшүүлсэн байгаа.

Хэрвээ говийн бүс рүү ус очих юм бол 14 мега төслийн маань олон төслүүд явах юм. Энэ Тавантолгойн 450 мегабайт дулааны цахилгаан станцын төсөл байна. Мөн дээрээс нь “Хэрлэн-Тооно” гээд том төсөл чинь өөрөө хөдөлчихнө. Тэгээд ийм боломж бололцоо байгаа юу гэж Ц.Туваан сайдаас бас асуух гэсэн юм.

Хэрвээ энэ боломж бололцоо байвал одоо яг энэ хэлэлцээр явж байгаа үедээ бас хаа хаанаа ойлголцоод үүнийгээ нэг үг өгүүлбэрийг нь зөв засаад оруулчих юм бол цаашдаа говийн бүсийн аж үйлдвэрийн одоо ёстой тэр нөгөө нүүрс, хими, кокс химийн цогцолбор, мөн дээрээс нь тэр гангийн үйлдвэрийн чинь бараг суурь, Тавантолгой энэ 450 мегаваттын цахилгаан станцын асуудал. Мөн дээрээс нь “Хэрлэн-Тооно” гээд бүхэл бүтэн энэ 14 мега төслийн нэг том төсөл ингээд ороод ирчихсэн. Ингээд олон төслүүдийг чинь явах эх үүсвэрээс бүрдчих гээд байгаа юм.

Тэгэхээр мэдээж үүнийг явуулахын тулд бид Хятадын талтайгаа тохиролцох, ойлголцох, ярилцах ийм асуудал гарна.

Тэгэхээр яг одоо ингээд Их Хурлын тогтоол гарч байгаа дээр үүнийг тусад нь салгаад оруулах боломж бололцоооо байна уу гэж байна. Нэгдүгээрх асуудал.

Хоёрдугаар асуудал бол Эрдэнэс Тавантолгой дээр сүүлийн он жилүүд асар их хөрөнгө оруулалтууд хийгдээд энэ баяжуулах үйлдвэрийг барьчихсан байгаа. Жилийн 10 сая тонныг баяжуулна гэж байгаа юм.

Тэгэхээр бас энэ тогтоол дээр нэмж оруулаад, магадгүй тэгээд энэ тооцоо тооцоолол нь ямар байдаг байгаа юм. Ц.Туваан сайд энэ дээр хариулт өгчихвөл бас зүгээр байгаад байгаа юм.

Бид 2025-2029 оны хугацаанд өгөх гэж байгаа 27 сая тонн нүүрснийхээ тодорхой хэмжээг нь энэ баяжуулсан нүүрсээр буюу шинэ хэлэлцээрийн зүйл, заалтууд оруулж ирээд бидний баяжуулсан үнийг нь хүртэл шинээр оруулж ирээд. Шинэ нөхцөл гэсэн үг шүү. Оруулж ирээд ингээд тохиролцоод цаашаа явах боломж байгаа юу? Ингэх юм бол бид баяжуулах үйлдвэрийгээ бүрэн ашиглах боломж бололцоонууд бүрдэх юм болов уу гэж харж байгаа. Энэ дээр нэг хариулт авчихмаар.

Гуравт нь, Б.Дэлгэрсайхан түрүүн бас жоохон дутуу хариулчихлаа. Би бас энэ говийн бүсээр нэлээн ажилласан. Боомтын сайдтай. Мөн дээрээс нь тэндээс сонгогдсон гишүүд. Мөн дээрээс нь тэр орон нутгийн хүмүүстэй нэг их ажилласан.

Юу ярьж байна гэхээр аж ахуйн нэгжүүд, ялангуяа түрүүн та хэллээ. Тэр 20 мянган жолоочийн асуудал байна. 7 мянган машин явж байгаа гэж байгаа. Яг энэ төсөл хэрэгжсэний үр дүн дээр хэчнээн ажлын байр тэндээс байхгүй болох вэ? Тэр байхгүй болж байгаа жолооч нарыг, аж ахуйн нэгжүүдийг ер нь цаашдаа яаж ажлын байр хангах бодлого байгаа юм. Тэрийг нарийн бас тоо тооцоололтой нь хэлэхгүй бол өнөөдөр бүрхэг юм ярьчихдаг. Магадгүй ингээд цаг хугацаа хурдан явна. 3, 4 жилийн дараа бүтээн байгуулалт болчихдог. Төмөр зам ордог. Тэнд байгаа ажил орлогоо, амьдралаа авч явж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Г.Очирбат гишүүний асуултад хариулъя.

Энэ 11 дүгээр заалт дээр бид бодлоготойгоор оруулсан. Нэлээн ийм амбицтай заалтууд байгаа.

Саяхан хэдхэн сарын өмнө Улсын Их Хурлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж өгсөн. Энэ хөтөлбөрийн гол цөм нь 14 мега төсөл байгаа.

14 мега төслийн нэгдүгээрт эрэмбэлэгдсэн Гашуунсухайт-Ганцмодны хил холболтын төмөр замын асуудлыг бид өнөөдөр ярьж байна. Тэгээд энэ асуудал бол нэлээн тийм хүлээлт үүсчихсэн. Одоо маш олон зүйлийн гогцоо түгжээ мултрах ийм төсөл байгаа.

Ялангуяа урд хөрштэйгөө хийх дараагийн хөрөнгө оруулалтууд, дараагийн бүтээн байгуулалтын асуудлуудын гогцоог тайлах тийм төсөл байгаа. Тэгээд энэ дотроо бид энэ говийг усжуулах энэ асуудлыг бол бас оруулж өгсөн гэдгийг хэлье.

Энэ асуудал шийдэгдсэнээр төмөр замынхаа хил холболтыг хийгээд борлуулаад олох ашиг байгаа. Үүнээс гадна бас дам давхартаа гарах холын ач холбогдлууд нэлээн байгаа. Энэ зүйл, заалтуудаа бид 11 дүгээр зүйл дотор оруулж өгсөн.

Тэгэхээр энэ дотор говийг усжуулах төслүүдээ бид хэрэгжүүлэх ийм зайлшгүй шаардлагатай байгаа. Одоо Монгол Улсад бас тулгамдаад байгаа хоёр том асуудлын нэг нь эрчим хүчний дутагдал. Дээрээс нь, говийн буюу ялангуяа уул уурхайн салбар хамгийн түлхүү хөгжиж байгаа говийн бүстэй усны дутагдал гэсэн ийм хоёр асуудал байгаа.

Тэгэхээр энэ асуудлаа бид тэр утгаар нь оруулж өгсөн гэдгийг хэлье.

Манай “Энержи ресурс” компани нүүрсийг баяжуулж, бирж дээр “баяжуулсан нүүрс” гэдэг байдлаар арилжаанд орж арилж ч байгаа. “Эрдэнэс Тавантолгой” компани өнөөдрийн байдлаар 10 сая тонн нүүрсийг баяжуулах үйлдвэрийг барьж дуусаад комисс хүлээж авах шатдаа явж байна. Энэ 10 саяар дахиад 3 ийм 10 саяын буюу нийтдээ 30 саяын баяжуулах үйлдвэр барих төлөвлөгөөтэй явж байгаа.

Тэгэхээр баяжуулсан нүүрсний борлуулалт экспорт бол уул уурхайн биржээрээ борлуулагдаад цаашдаа хэвийн үргэлжлээд явна гэдгийг энд хэлье. Тэгээд Б.Дэлгэрсайхан сайд жолооч дээр.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Г.Очирбат гишүүний асуултад хариулъя.

Энэ төсөл хэрэгжсэнээрээ ажлын байр эсрэгээрээ нэмэгдэнэ. Ялангуяа төмөр зам холбогдоод эхэлбэл төмөр зам дээр ажлын байр өнөөдрийн байгаагаасаа нэг дахин нэмэгдэнэ. Яагаад гэхээр ийм их хэмжээний ачилт хийж байгаа төмөр зам бол.

Өөрөөр хэлбэл одоо манай гол төмөр зам гэхэд өнөөдөр ойролцоогоор 16 мянган ажилтантай. Та мэдэж байгаа байх. Энэ жилийн байдлаар 42 сая тонн ачаа тээвэрлээд байна.

Гэтэл жилдээ 20-иос доошгүй, бараг 30 сая тонн гаргах энэ төмөр зам дээр ажлын байр нэмэгдэнэ.

Бид өнөөдрийн машинаар гарч байгаа 30 сая тонн нүүрснийхээ хэмжээг буулгахгүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж минут өгье.

Б.Дэлгэрсайхан: Өнөөдрийн энэ гэрээгээр хийх гэж байгаа, ялангуяа 2025-2029 оны хооронд эхний 2 жилд 5 сая тонноор нэмэгдэж байгаа энэ хэмжээгээр машинаар гаргах нүүрсний хэмжээ нэмэгдэх тусам жолооч нарын тоо нэмэгдэнэ, машины тоо нэмэгдэнэ.

Тэгэхээр ажлын байр бол энэ дээр улам нэмэгдэнэ.

Дээрээс нь ганц Эрдэнэс Тавантолгой биш, энэ гарцаар орон нутгийн жижиг Тавантолгой, Энержи Ресурс гээд олон компаниуд нүүрсээ экспортолдог учраас энд ажлын байр улам нэмэгдэнэ үү гэхээс биш хасагдах ямар ч тийм боломж байхгүй. Бид аль болохоор ажлын байрыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Г.Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Тэгээд энэ 20 жил дахиж яригдахааргүй ийм том асуудлыг өнөөдөр энэ парламент хэлэлцээр хийж байгаа. Мөн дээрээс нь 35 тэрбум долларын асуудлыг ярилцаж байгаа.

Тэгэхээр бүгд анхааралтай байх ёстой. Тэр утгаараа бас энэ 14 мега төсөл дээр хамгийн эхэнд орсон энэ Гашуунсухайт-Ганцмод яваад эхлэхэд хэлэлцээртэй холбоотой Улсын Их Хурлын тогтоол гарч байхад Их Хурлын гишүүд маань энд оруулах, ялангуяа чиглэл дээрээ оруулах юмнуудаа нэлээн тийм деталь харж байж оруулаад цаашаагаа бусад төслүүд нь дам маягаар цуг явах ийм юм руу нь оруулбал их зүгээр шүү гэж хэлэх гэсэн юм.

Тэгээд Б.Дэлгэрсайхан сайд түрүүн хэллээ. Ажлын байр нэмэгдүүлнэ гэж та бодож байна. Эсрэгээрээ бас магадгүй төмөр зам маань ороод ирэх юм бол тийм ээ, бүх бараа, бүтээгдэхүүнээ төмөр замаар гээд манай худалдан авагч тал маань төмөр замаар байх сонирхолтой. Яагаад гэхээр тэнд өртөг буурна. Тэгээд сонирхолтой болно.

Тэгэхээр энэ дээрээ та бас илүү сайн анхаарч ажиллаарай гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Та бүгддээ өглөөний мэнд хүргэе.

Магадгүй энэ асуудлыг хэлэлцэх эсэхийг шийдэж байхад асуух нь зохистой байсан. Тэгээд би харамсалтай нь нэрээ өгч чадаагүй учраас асууж чадаагүй. Гэхдээ миний асуух асуултыг Б.Дэлгэрсайхан сайд буюу Зам, тэвээрийн яам, Гадаад харилцааны яамнаас албан ёсоор хариулж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Энэ Ганцмод-Гашуунсухайт боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлснээр бусад төмөр замуудын холболтуудыг хийнэ.

Ингэснээрээ бид олон боомтуудаараа бараа, материалаа татах, экспортоо дэмжих энэ үйл ажиллагаа явна. Магадгүй цаашдаа Монгол Улсад орж ирж байгаа импортын бараа, бүтээгдэхүүний тээврийн зардал ч гэсэн багасаад явах бололцоо бүрдэх байх. Ер нь алсдаа.

Энэ хүрээндээ Бүгд Найрамдах Хятад Ард Улстай яригддаг төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай хоёр улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээр яригдаж байсан. Энэ хэлэлцээр Ганцмод-Гашуунсухайтын хил холболтын асуудлаас болоод зогссон байдаг. Энэ транзит тээврийн хэлэлцээрээр уг нь Монгол Улсаас гарч байгаа нийт бараа, бүтээгдэхүүний буюу Хятадын нутаг руу гарч байгаа бараа, бүтээгдэхүүний гуравны нэгтэй тэнцэх хэмжээний бараа, материалыг гуравдагч хөрш рүү Хятадын төмөр замаар бас хөнгөлөлттэй тээвэрлэж хүргэх тийм квот,

боломжийг уг нь Монгол Улсад олгоно гэдэг ийм зүйл яригддаг. Яригддаг байсан.

Тэгэхээр бид хэд энэ Ганцмод-Гашуунсухайтын хэлэлцээрийн явцад бусад боомтуудыг холбохоосоо гадна энэ транзит тээврийн хэлэлцээрийг цаашдаа ярьж анхаарах ёстой юм. Энэ транзит тээврийн хэлэлцээрийн ач холбогдлыг холбогдох яамд хэлж өгөөч.

Тэгээд бид алдагдсан энэ боломжууд, цаашдаа эдийн засгаа дэмжиж, экспорт хийх гэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудаа бас дэмжиж өгөх талаас нь илүү их анхаармаар байгаа юм.

Тэгэхээр уг асуудал дээр хариулж өгөөч. Тэгээд би бас олон гишүүдтэй санал нийлж байгаа. Ялангуяа сая Жудагийн Баярмаа гишүүнтэйгээ бүрэн санал нийлж байна.

Тэр алдагдсан боломжийн араас явж хариуцлага тооцох ёстой шүү гэдэг дээр бүрэн санал нэг байна. Тэгээд саяын тэр транзит тээврийн хэлэлцээр ямар шатдаа яваад, яагаад зогсчов? Үүний ач холбогдол ер нь юу юм? Бид үүнийг ер нь байгуулах ёстой юу, үгүй юу гэдэг дээр албан ёсны байр суурийг, бас мэдээллийг Зам, тээврийн яам болон Гадаад хэргийн яамнаас өгөөч ээ гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Бас хэрэгтэй зүйл асууж байна. Бид өнөөдрийн хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр дээр зөвхөн Ганцмод-Гашуунсухайт боомтыг ярьж байгаа.

Энэ төслийн 10 дугаар зүйл дээр бусад боомтуудыг хэзээ холбох вэ, шат дараатай холбоно гээд оруулсан байгаа.

Тэгээд Байнгын хорооны хурал дээр манай зарим гишүүд зэрэг холбоно, хамт эхлүүлнэ гэдэг ийм санаачилга гаргаж байгаа учраас бид өчигдөр орой шөнө суугаад бас энэ асуудал дээрээ нэлээн ярьсан.

Тэгээд үүндээ юу гэж оруулах вэ гэхээр зэрэг бусад боомтуудыг холбоход, зэрэгцүүлж холбоход аль болох “тохиролцох” гэдэг ийм үгээр оруулбал одоо арай дээр юм уу гэж үүнийг ингэж хийсэн байгаа. Аль болохоор хоорондоо ярьж тохирох гэдгээр арай зөөллөж оруулах нь зөв байх. Яагаад вэ гэхээр нэг боомтын тухай эхэлж.

Ер нь урд хөршийн барьж байгаа бодлого бол эхлээд Ганцмод-Гашуунсухайттай холбочихъё. Бусад боомтуудыг шат дараатай холбоно гэдгээ нэгэнт хэлчихсэн учраас бид энэ хүрээнд нь аль болохоор богино хугацаанд

холбохыг дэмжиж ажиллах гэдгээр оруулбал зүгээр юм болов уу гэж редакц дээр янзалж байгаа.

Транзит тээврийн хувьд таны хэлж байгаа маш зөв өө.

Ер нь бол манай яамны хувьд хоёр хөрштэйгөө транзит тээврийн гэрээгээ хийчихсэн. Транзит тээвэр явахад бэлэн байгаа. Одоо ганцхан харамсалтай нь одоо энэ транзит тээвэр явахад “транзит тээврийн виз” гэдэг асуудал маш их асуудал болж байгаа. Үүнийг шийдэх ёстой юм байна лээ. Өөрөөр хэлбэл бидний нөгөө баталсан, Хууль зүйн яамнаас баталсан визний хөнгөвчилсөн юман дээр тэр 16-гийн “к”, 17-гийн “к” гэдэг дээр транзит визний тухай асуудал байгаа.

Тэгэхээр үүнийг транзит виз дээр манай Гадаад яам бас их анхаарч ажиллана гэж Засгийн газрын хурал дээр ярьсан.

Тэгэхээр транзит визний асуудал шийдэгдчихвэл энэ транзит тээвэр бол үнэхээр одоо урд хойд хоёр хөрш хоёулаа явуулъя гэдэг ийм хүсэлтэй байгаа. Урд хөршийн бид нарт тавьж байгаа хүсэлт бол бид ингээд энэ хойгуур Манжуураар хойшоо гараад 3-аас 4 мянган километр орж явж байж ингээд Оросын гол Сибирийн нутаг руу орж байна. Танайхаар дамжин өнгөрөхөд мянган км явах юм байна.

Тэгэхээр та нар үүнийг шийд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Б.Дэлгэрсайхан сайд аа, би ингэж асуугаад байгаа юм.

Монголын талаас буюу Монголоос Хятадыг чиглэн экспорт хийгээд, Хятадын нутгаар дамжин гуравдагч хөрш рүүгээ гарах энэ экспортын боломжийг илүү нэмэгдүүлэх. Өөрөөр хэлэх юм бол Хятадтай ярилцаж байсан энэ хэлэлцээрийн дагуу манайхаас гарч байгаа нийт бараа, бүтээгдэхүүн гуравны нэгтэй тэнцэх хэмжээний бараа, материалыг Хятад нутаг дэвсгэрээрээ хөнгөлөлттэй үнээр дамжуулж гуравдагч хөршийн боомт дээр хүргэх энэ боломжийг Монгол Улсад олгоно гэдэг яриа хэлэлцээр явж байсан. Үүнийгээ нэг сэргээж яриад бас нэг албажуулах талаас нь анхаараачээ л гэдэг зүйлийг би хэлж байгаа юм.

Тэгэхээр Гадаад хэргийн яамнаас хүн байгаа бол бас үүнийг ямар процесс дээр яваад зогсчихсон байгаа. Үүнийг ер нь буцаагаад ярих боломж байгаа юу гэдэг зүйлийг протоколд хариулаад үлдээгээд өгөөч ээ л гэж хүсээд байгаа юм.

Д.Амарбаясгалан: Зам, тээврийн яамны газрын дарга Б.Артур. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Артур: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

2014 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай Төмөр замын дамжин өнгөрөх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулсан.

Тухайн үед Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого туссан шинээр байгуулах 4 боомт. Энэ 4 боомтоор Бүгд Найрамдах Хятад Ард Улстай төмөр замын боомт байгуулах, мөн байгуулагдсанахаа дараа Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төмөр замын сүлжээгээр нийт экспортолсон ачааны гуравны нэгтэй тэнцэх хэмжээний ачааг олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын нэгдсэн нэвтрэх тарифт зааснаас 40 хувийн хөнгөлөлттэйгөөр явуулах ийм хэлэлцээрийг байгуулсан байдаг.

Энэ байгуулсан хэлэлцээрт хүчин төгөлдөр болгох нөхцөлтэйгөөр тухайн үед байгуулж байсан. Яагаад вэ гэхээр тухайн үед манай тал төмөр замынхаа боомтуудыг байгуулж, шинээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье.

Б.Артур: Энэ шинээр байгуулсан боомтууд о байгуулагдсаны дараагаар Хятадын сүлжээгээр явах үед энэ хөнгөлөлтийг авна гэж тохиролцсон байдаг.

Манай тал 2015 оны 01 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар энэ асуудлыг хэлэлцээд батлаад Хятадын талд нот бичгээр хүргэгдсэн. Хятадын тал хараахан баталж ирүүлээгүй байгаа.

Мөн өндөр дээд хэмжээний бүх уулзалтын үеэр Хятадын талд энэ хэлэлцээрийг баталж өгөх саналыг манай талаас байнга тавьж явж ирсэн байгаа. Хариулт дууслаа.

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууя.

Н.Номтойбаяр: Мөнхийн улс төр болсон Эрдэнэс Тавантолгойтой холбоотой энэ хэлэлцээр өчигдөр энэ хэлэлцэж байгаа байдлыг харлаа. Тэгээд энэ хэлэлцээрт тусгачихсан зарим зүйл, заалтуудыг бас харлаа. Цаашдаа мөнхийн улс төрийн хэрүүлийн сэдэв л болох ийм л үндэс суурь тавигдаад байна л даа.

Яг үнэндээ энэ хэлэлцээрт байгаа нөхцөл байдлууд 100 хувь Монголын эрх ашигт таатай бөгөөд нийцтэй байдал бол байхгүй нь үнэн. Яагаад вэ гэхээр бид өөрсдөө хэлсэн ярьснаасаа буцаад, төрийнхөө бодлого, шийдвэрийг байнга

өөрчлөөд, өөрөөр хэлбэл хулхидаад, зальдаад явсаар байгаад 10 жилийн дараа үнэнтэй нүүр тулж ийм хүлцэнгүй байдлаар л явж байгаа.

Тэгэхдээ ямартаа ч энэ хэлэлцээр бас нэг шатад ахиад дараа дараагийн эдийн засгийн олон талт хамтын ажиллагааны суурь тавигдаж байгаа учраас дэмжээд байгаа юм.

Тэгэхээр энэ нөхцөл байдлаас гарах хоёр арга зам харагдаад байна. Нэгдүгээрт, яах аргагүй яагаад ийм нөхцөл байдалд хүрэв гэдэг дээр бид эргэж харж хариуцлагын асуудлыг ярих хэрэгтэй.

Эрүүгийн хуульд маш тодорхой зүйл, заалтууд байгаа. Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг ч гэж заалт бий. Юу болсон юм, яасан юм. Тэгээд хамтарлаа гээд бие биеийнхээ булхайг бас хаацайлаад байх ийм зүйл ердөөсөө байж болохгүй.

Тэгэхээр энэ ийм хүнд нөхцөл байдалд яагаад бид хүрэв гэдгийг ямагт бид бас шаардаж явах л хэрэгтэй.

Энэ гэрээн дээр нэг зүйл хэлэлцээр дээр байгаад байгаа юм. Энэ Ц.Туваан сайд энэ дээр маш тодорхой байр сууриа илэрхийлэх нь зөв байх. Энэ 3 дээр.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй байх үүргийг ингээд хүлээчхэж байгаа юм. Энэ нөгөө хамрах цар хүрээ нь яг юу юм бэ? Бүхэлд нь гэж ойлгох уу? Бүхэлд нь бол цаашдаа бид Монголын төр өөрсдөө мэдээд зөв, эрүүл эдийн засгийн суурь зарчим барьсан реформын шилжилтийн ажлуудыг хийж болохгүй гэсэн үг үү?

Эрдэнэс Тавантолгойн менежментийг гаднын менежментийн компанид өгнө гээд Ерөнхий сайд мэдэгдсэн. Үүнтэй хэр зөрчилдөх вэ?

Дээрээс нь энэ үнэтэй холбоотой асуудлууд нэлээн маргаан дагуулаад байна. Тэгээд саяхныг хүртэл энэ Уул уурхайн сайдаар ажиллаж байсан Ж.Ганбаатар гишүүн маш тодорхой хууль зүйн гаргалгаа, заавар, зөвлөмжийг өгчихлөө. Тэгээд хуульд нь ийм зүйл байсныг нь бид мэдээгүй. Энэ биржийн тухай хуультай уялдуулаад л болохгүй юм байна, яах вэ, ийх вэ гээд л ярилцаад байгаад байсан. Тэгээд маш тодорхой хуульд нь байгаа л юм байна.

Дээрээс нь, түрүүн Ц.Мөнхбат гишүүн асууж байна, О.Цогтгэрэл гишүүн бас асууж байна. Үнийг доод хэмжээнд барьснаараа бусдыгаа бас татаж унагах вий гээд. Хуульдаа үнийг өсөлттэй байлгах буюу биржийн үнийн хэмжээнд авчрах ийм зохицуулалтууд энэ өмнөх урт удаан хугацааны гэрээндээ ч гэсэн бас байгаа л юм байна.

Дээрээс нь энэ төмөр зам, энэ нүүрс гэхээр л зөвхөн Эрдэнэс Тавантолгой гээд бид бусдыгаа орхичхоод байх шиг байна.

Зам, тээврийн сайдаас нэг асуулт байна. Энэ хэлэлцээрийн явцад зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар, Хэнтий хамарсан Бичигт-Зүүнхатавчийн босоо тэнхлэгийн төмөр зам болон хэвтээгээрээ Нөмрөг хүртэлх төмөр замын эдийн засгийн эргэлтэд оруулах, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх, зөвхөн нэг транзит тээврээс бусдаараа энэ уул уурхайн салбар болон хүнс, хөдөө аж ахуйн салбарын хүрээнд хэрхэн яаж эргэлтэд оруулъя.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Би Н.Номтойбаяр гишүүний хамгийн сүүлийн асуусан асуултаас хариулъя.

Ер нь төмөр замын төрөөс баримтлах бодлогод зүүн, баруун босоо тэнхлэгийн төмөр замыг бид аль болохоор явуулах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Ялангуяа Зүүн бүсийн Бичигт-Зүүнхатавчийн төмөр замыг ирэх 2025 ондоо бид багтааж энэ ажлыг эхлүүлнэ. Энэ төмөр зам ашиглалтад орсноороо Хөөтийн нүүрсний орд бас эргэлтэд орох, цаашилбал зүүн бүсэд байгаа ашигт малтмалын ордууд сэргэх ийм боломж бололцоо бүрдэнэ.

Дээрээс нь, өөрсдөө бид хатуу хучилттай зам энэ боомт руугаа тавихаар манай Зам, тээврийн яамны 2025 оны төсөвт орчихсон. Энэ зам 2025 онд эхэлнэ. Энэ хүнд даацын зам гэдгээр явах юм. Ийм дэд бүтцүүд бий болно.

Ингэснээрээ Монгол Улсын экспорт тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ гэж үзэж байгаа.

Х.Булгантуяа: Н.Номтойбаяр гишүүн тодруулъя.

Н.Номтойбаяр: Ямар ч байсан зүүн бүсийн төмөр замын асуудлууд хэлэлцээрийн түвшинд яригдаж байгаа юм байна.

Хамгийн гол нь бид энэ эдийн засгийн хувьд үр ашигтай байлгах. Саяын энэ царигтай холбоотойгоор, эдийн засгийн хамтын ажиллагаатай холбоотойгоор өнгөрсөн 10 жилийн хугацаанд үүссэн энэ асуудлууд маань бас нэг сургамж болоод, дахиад нэг ийм асуудал үүсэхгүй байх хэмжээнд ирээсэй гэж бодож байна.

Тэр дээр зөвхөн уул уурхай гэлтгүй энэ хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн маш том эдийн засгийн хөшүүрэг л бас байгаад байгаа юм л даа. Тэгээд сайд нь байхгүй байгаа юм байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар гишүүн байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан.

Б.Жаргалан: Өглөөний мэнд.

Манай улс 2004 оноос нүүрс экспортолж эхэлсэн байдаг юм. Одоогоос 20 жилийн өмнө гэсэн үг.

Анх 2004 онд 1.6 сая тонн нүүрс гаргаад, 16 сая амдоллар олж байжээ. Тэгээд өнгөрсөн 20 жилийн хугацаанд буюу 2004-2023 оны хооронд Монгол Улс нийтдээ 410 сая тонн нүүрс экспортолсон. Нийт 37.8 тэрбум ам.долларын орлого олсон гэсэн үг.

Харин энэ дүнгийн үлэмж хувь нь өнгөрсөн 8 жилд хийгдсэн байдаг. Өнгөрсөн 8 жилд 278 сая тонн нүүрс гаргаж, 29.5 тэрбум ам.долларын орлого олжээ. 100 их наяд төгрөг гэсэн үг.

Тэгээд Монгол Улс нүүрснээс ийм их орлого олж байгаа хэрнээ энэ нь иргэдийн амьдралд наалдсангүй, утаа, түгжрэлийг арилгасангүй, шинэ технологи бий болгосонгүй, эдийн засгийг солонгоруулсангүй. Харин ч энэ танхим дахь зөрчлийг улам даамжруулж, нийгэм дэх талцал хуваагдлыг нэмэгдүүлсээр ирсэн юм.

Харин одоо бид ирэх 16 жилийн хугацаанд 270 сая тонн нүүрс бас нэмж гаргаад нийтдээ 34 тэрбум ам.долларын гэрээ хийж байна. Ийм гэрээ хийхдээ бас үнээ түгжиж байгаа.

Тэгээд энэ тоонуудыг хэлээд байгаа нь өнөөдрийн бидний яриад байгаа гэрээний энэ “Чайна Энержи”-тэй хийх хэлцлийн, энэ компанитай байгуулах гэж байгаа гэрээ хэлэлцээрийн эдийн засгийн ач холбогдлыг нь хүмүүст тоон утгаараа хүргэе гэж бодсон.

Тэгээд хэлэлцээртэй холбоотой нарийн ширийн асуудлуудыг сая маш богинохон хугацаанд Байнгын хороод дээр, өмнөх чуулган дахь хэлэлцүүлэг дээр асуусан.

Одоо ингээд цаашлаад өнөөдөр Улсын Их Хурлын тогтоол ингээд ороод ирж байна. Улсын Их Хурлын тогтоол болохоор Монгол Улсын Их Хурал Монгол Улсын Засгийн газарт “Чайна Энержи” компанитай байгуулах ерөнхий нэг тийм гэрээ хэлэлцээрийн цар хүрээг нь тодорхойлж өгч байгаа.

Тэгвэл энэ чиглэлээ Засгийн газар аваад цаашдаа яг ямар процесс өрнөх тал дээр хэлэлцээр дээр ажиллаж байгаа хүмүүс маань бүр нэг ийм тодорхой хэлээд өгмөөр байна.

Өнөөдөр тогтоол батлагдлаа гэж үзэхэд ар дээр нь Засгийн газар хоорондын гэрээ ийм хугацаанд батлагдана. Ар дээр нь хоёр компани хоорондын асуудал ингэж ингэж явна. Хэзээ оператор компанийн тендер зарлагдах юм. Хэзээ хил холболтын терминалын барилга байгууламжийн тендер зарлагдах юм гээд энэ бүх зүйлүүдээ процессоо нэг зураглаад яг протоколд тэмдэглэх зорилгоор хэлээд өгмөөр байна.

Тэгээд Улсын Их Хурал энэ тогтоолоо баталлаа гэж үзэхэд дараа нь ер нь одоо яг энэ Эрдэнэс Тавантолгойн асуудалтай холбоотой ямар асуудал ахиж Улсын Их Хуралд орж ирэх юм бэ? Өөр ямар бичиг баримт байх юм бэ? Одоо энэ гэрээ чинь бол ахиж орж ирэх юм уу гэдэг нэг ийм асуулт байна.

Мөн энд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хүмүүс байж байгаа. Эрдэнэс Тавантолгойгоос нэг ийм юм асуумаар байна.

Та нар ер нь компанийнхаа ирээдүйг юу гэж харж байгаа юм бэ? Өнгөрсөн хугацаанд бид ямар их хэмжээний нүүрс олборлосон, тээвэрлэсэн, экспортолсон талаар бас ингээд тоо баримтуудыг дурдлаа.

Эрдэнэс Тавантолгой компани ер нь бол ингээд Монгол Улсад байгаа хамгийн том нүүрсний компани. Цаашдаа олон улсад гарах түвшний ийм компани болмоор байна. Энэ тал дээр ер нь алсын хараа чинь юу байна аа? Энэ гэрээ хийгдсэнээр Эрдэнэс Тавантолгойн үйл ажиллагаанд ямар нэг арга хэлбэрээр ер нь нөлөөлөх зүйл та нарт харагдаж байна уу?

Шинэ хоёр ам нээгдэх юм байна. Тэнд өөр олборлогч компани ажиллах юм байна. Төмөр замаар одоо ингээд... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Би Б.Жаргалан гишүүний ярьж байгаатай санал нэг байна.

Ер нь өнгөрсөн 8 жилд багагүй хэмжээний нүүрс гаргаж 29.5 тэрбумын орлого олсон гэж. Үнэн. Бид энэ мөнгөөрөө өнөөдөр Гашуунсухайт-Ганцмодны төмөр замаа барьсан.

Дээр нь Тавантолгой-Зүүнбаянгийн төмөр замаа бас барьсан.

Ер нь дэд бүтэцгүйгээр овор их хэмжээтэй нүүрс, ялангуяа нүүрс, төмрийн хүдэр, ийм овор их хэмжээтэй ачааг төмөр замгүйгээр цаашдаа дэлхий нийтээрээ төсөөлөхийн аргагүй болсон.

Тийм учраас бид өнөөдөр энэ Ганцмод-Гашуунсухайтын төмөр замаа барьчихсан учраас холбох тухай асуудлыг ярьж байгаа.

Цаашдаа ч гэсэн үүнийг дагаад энэ мөнгөөрөө бид энэ Тавантолгой дээр нойтон баяжуулах үйлдвэр барьсан, ачиж буулгах том терминал барьсан гээд ингээд ямар ч гэсэн бид нар бол Монголын талдаа аль болохоор их хэмжээний нүүрс гаргах энэ дэд бүтцээ нэлээн сайн хийж авсан.

Энэ дээр ямар нэгэн тийм үргүй зардал бол гараагүй. Цаашдаа том гэрээ батлагдсаны дараа 3 гэрээ хийгдэнэ. 2 гэрээ нь одоо манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай холбоотой гэрээ байна. Нэг гэрээ нь Зам, тээврийн яамтай холбоотой гэрээ хийгдэнэ.

Тэгээд энэ гэрээ Засгийн газарт нэгэнт эрхийг нь олгочхож байгаа учраас бид энэ гэрээн дээрээ Та бүгдийн өгч байгаа зөвлөгөө, зөвлөмж, энэ бүх нарийн зүйлээ оруулж явуулна гэдгийг хэлье.

Тэгээд цаашдаа энэ үр ашигтай том бүтээн байгуулалт. Өөрөөр хэлбэл таны саяын хэлдэг бүтээн байгуулалтуудаа яаж хийх, үүнийгээ бид Засгийн газар дээрээ ярина гэдгийг л хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эрдэнэс Тавантолгой компанийн гүйцэтгэх захирал Х.Мөнхжаргал. 19 дүгээр микрофон өгье.

Х.Мөнхжаргал: Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

“Эрдэнэс Тавантолгой” компани 2024 онд нэлээдгүй амжилттай, нэлээдгүй том төслүүдийг хэрэгжүүлээд Улсын комисст хүлээлгэж өгөх шатандаа явж байна.

Ерөнхийдөө компанийн нүүрс борлуулах үйл ажиллагаа бас биржээр явагдсантай холбоотой орлого энэ жилдээ тогтвортой болсон.

2025 онд бас хүлээгдэж байгаа томоохон төсөл, хөтөлбөрүүд байгаа. Үүний нэгийг одоо бид өнөөдөр энэ танхимд хэлэлцээд сууж байна. Үүнээс гадна Тавантолгой дулааны цахилгаан станц, газрын тос дамжуулах хоолой дээр тус компани санхүүжилтийн юутай ажиллаж байгаа.

Компанийн цаашдын ирээдүй дээр Засгийн газар тодорхой шийдвэрүүдийг гаргачихсан. Гадаадын менежмент. Тийм багаар ажиллана. Дээрээс нь нээлттэй хувьцаат компани болох асуудлуудыг үүрэг даалгавар чиглэл өгчихсөн. Үүн дээр тус компанийн толгой компани “Эрдэнэс Монгол” компанид ажиллаж байгаа. Баярлалаа. Хариулт дууслаа.

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд. Ажлын хэсгийн дарга. Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Одоо өнөөдөр энэ процесс явагдаж байна. Цаашдаа Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд ямар процесс явагдах талаар.

Ц.Туваан: Б.Жаргалан гишүүний асуултад нэмж хариулъя.

Бид бүхэн өнөөдөр энэ үндсэн чиглэлээ батлах буюу энэ Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах чиглэлийг Улсын Их Хурлаас авч байгаа. Тэгээд энэ чиглэлээ баталсны дараагаар бид бүхэн хоёр улсын Засгийн газар хоорондоо хэлэлцээртээ орно. Энэ хэлэлцээрээ хийж дуусгаад хэлэлцээрээ Улсын Их Хурлаар соёрхон батлуулахаар дахин орж ирнэ.

Тэгээд энэ соёрхон батлагдсаны дараагаар бас энэ гуравласан гэрээний асуудлууд орж ирнэ.

Тэгэхээр сая бас энэ цаг хугацаанд Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээ бас орж ирж байгаа шиг тэр гэрээ бас орж ирж болно. Тэгэхдээ ер нь энэ гэрээгээ Засгийн газартаа хийх эрхээ авч байгаа ийм асуудал гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Саяын процессын хувьд болохоор бас цаг хугацаагаа хэрхэн яаж төлөвлөж байгаа вэ гэдэг дээр нэмээд хариулчихмаар байна.

Тэгээд “Эрдэнэс Тавантолгой” компанийнханд гэж хэлэхэд ерөнхийдөө бид Эрдэнэс Тавантолгойг зөвхөн нэг төсөв бүрдүүлэгч нэг ийм аж ахуйн нэгж, бусад элдэв янзын Засгийн газрын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх ийм зорилгоор ашиглахаасаа илүү “Эрдэнэс Тавантолгой” компани Монгол Улсын бас нүүр царай болсон, одоо энэ нүүрсний зах зээл дээр дэлхийд тэргүүлэгч тоглогч болсон ийм компани болох ёстой юм.

Эс бөгөөс одоо бас яг Эрдэнэтийн хувь заяаг давтах гээд байна шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр одоо бид бол цаашдаа энэ танхимд нүүрс экспортлох талаар биш, шинэ технологийн талаар. Тийм ээ. Ийм өөр өөр цоо шинэ салбаруудын талаар ярилцмаар байна л даа.

Тэгэхээр энэ дээр одоо яг “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэс Тавантолгой” компаниуд бас түүчээлэх ёстой шүү гэдгийг бас хэлэх байна.

Тэгээд цаг хугацааныхаа хувьд Ц.Туваан сайд аа, нэмээд хариулаад өгөөч.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Өнөөдөр 12 сарын 27-ны өдөр. Бид бүхэн энэ чиглэлээ батлуулаад шууд Засгийн газар хоорондын хэлэлцээр лүүгээ орно.

Мэдээж хоёр тал байгаа учраас нөгөө талын хугацаа. Хэр зэрэг хугацаа авах вэ гэдэг асуудал бол байгаа. Бидний хүсэл бол аль болох хурдан буюу энэ намрын чуулган дотроо багтаагаад шийдвэрээ гаргачих юм бол энэ бүтээн байгуулалт маань ирэх хавраас шууд дулаан орохоор эхлээд явахаар ингэж харж байгаа.

Тэгэхээр бид бүхэн бас нөгөө талынхаа хугацааг нэлээн харна. Хятадын Элчин сайдтай болон бусад албаны Хөгжил шинэтгэлийн хорооных энэ тэртэй яриад үүнийг маш хурдан хугацаанд шийдэж өгөөч ээ гэдэг урьдчилсан байдлаар саналуудаа хэлчихсэн байгаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт авч, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй нийт 24 санал байна.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг намын бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно гэж дэгийн зохицуулалт байгаа.

Ингээд зарчмын зөрүүтэй саналуудыг танилцуулъя.

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Нэг.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “төмөр замын бүтээн байгуулалтын” гэснийг “төмөр замын тээврийн хүчин чадлын” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин.

Байнгын хорооны дэмжсэн санал байгаа.

Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

69.6 хувиар санал дэмжигдлээ.

Сангийн сайд Болдын Жавхлангийн хурууны хээ уншдаг төхөөрөмж хурууны хээ хоёр зөрсөн байгаа. Өнөөдөр. Өчигдөр бас систем дээрээс шинэчлэх гэж байгаад амжаагүй байгаа юм байна. Тийм байна.

Тийм учраас өнөөдөр бас энэ дэмжсэн саналдаа протоколд өөрөө тэмдэглүүлээд явчих нь зүйтэй байх гэж байна. Цайны цагаар янзалчих юм байна. Тийм ээ.

Ингээд 69.6 хувиар санал дэмжигдлээ. Сангийн сайд Болдын Жавхланг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

2.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын “бууруулахгүй” гэсний дараа “, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн олборлолтын төлөвлөгөөтэй нийцүүлэн коксжих, сул коксжих, эрчим хүчний нүүрсийг зохимжит хувь харьцаагаар нийлүүлэх буюу зөвхөн нэг төрлийн нүүрсийг сорчлохгүй байх” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал.

Ж.Золжаргал гишүүн гаргасан саналаа тайлбарлаж үг хэлье.

Ж.Золжаргал: Энэ ямар нэгэн том гэрээ ч байна уу, энэ дарга нарын нөлөөтэйгөөр тэр нүүрсийг тэр хамгийн чухал компани гээд. Тэгээд тэр нь хамгийн сайн нүүрсийг нь авна гэдэг команд ирээд уурхайчид нь ажлаа хийж болдоггүй. Үр дүнд нь ингээд нэг төрлийн нүүрсийг ухаж ахиу өгсөөр байгаад ордоо эвдээд хаячихдаг. Байгалийн баялаг хаягддаг. Монгол Улсын ашигт малтмал, нөөц баялгийг аль болохоор хаягдал багатай иж бүрнээр ашиглах гэсэн ийм үзэл санаа байдаг шүү дээ. Эрх зүйн орчинд.

Тэгэхээр үүнийгээ ч бодсон тэр, уурхайн үйл ажиллагаа урт хугацаанд тогтвортой явахаа бодсон ч тэр, зарчмын хувьд ийм жам ёсны гарах нүүрснийх нь хольц юмыг харгалзан үзэж явах ёстой юм. Тэгээд энэ утгаар оруулсан байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Тийм. Улсын Их Хурлын гишүүдийн хэлээд байгаа саналыг ажлын хэсэг, Засгийн газар маш сайн сонсож авах хэрэгтэй байх.

Хоёр зүйл яриад болохгүй байна шүү дээ.

Нэгдүгээрт, 20 сая тонноос бууруулахгүй гэж байгаа юм.

Тэгэхээр тэр нь 20 саяасаа дээшээ гараад ихсээд явбал яах юм бэ гэдэг зохицуулалтыг тодруулж энэ гэрээ хэлцэл дээрээ тодорхой болгох хэрэгтэй юм байна гэдэг нэг дэх асуудал яриад байдаг.

Хоёр дахь асуудал нь, өөрсдөө хөрс хуулалт, олборлолтын ажил хийчхээд тэр дотроосоо сорчилж авбал яах юм бэ. Бусад нүүрс нь орхигдож хаягдвал яах юм бэ гэдэг асуудал яригдаж байгаа учраас үүнийг гэрээн дээрээ маш тодорхой оруулж ирэх ёстой. Үүнийг зориуд протоколд тэмдэглүүлж хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Ингээд Ж.Золжаргал гишүүний гаргасан, Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

57.8 хувиар санал дэмжигдлээ.

Дэмжсэн саналд Бөхчулууны Пүрэвдорж, Далайн Батбаяр, Цагаанхүүгийн Мөнхбат, Б.Пунсалмаа гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, Р.Эрдэнэбүрэн гишүүн, Р.Батболд, М.Сарнай гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, О.Саранчулуун гишүүн, М.Энхцэцэг гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Х.Булгантуяа гишүүн нар дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Б.Дэлгэрсайхан гишүүн горимын санал гаргаж байна.

Б.Дэлгэрсайхан: Өчигдөр орой Байнгын хороон дээр олон гишүүд ийм санал гаргасан.

Тэгэхээр гишүүдийнхээ гаргасан горимын саналыг сонсоод, тэгээд үүнд нь ажлын хэсэг давхар тайлбар сонсооч ээ гэдгийг гишүүдээсээ хүсэх гэсэн юм. Бид нарт бас энэ том гэрээн дээрээ оруулж болох юм, оруулж болохгүй юм бас байна.

Араас нь дахиад 3 гэрээ явагдах учраас энэ гэрээнүүддээ оруулах жижиг сажиг заалтуудаа том гэрээн дээрээ хэтэрхий оруулхаар нөгөө талаас хийгдэхгүй гэдэг юм ирвэл хэн хариуцах вэ гэдэг ийм асуудал гарч ирж байгаа учраас бидний тайлбарыг бас сонсооч ээ гэдгийг хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Та сая санал хураалтын өмнө наад үгээ хэлэх ёстой л доо. Тийм үү.

Тэгээд та төхөөрөмжийнхөө ард намхан яахаар чинь харагдахгүй байна л даа. Гараа ингэж өргө. Яах билээ. Санал хураагаад дэмжсэн саналыг дэмжчихсэн шүү дээ. Дараагийнх гэж байхгүй л дээ Байнгын хороон дээр боломжгүй өнгөрчихлөө шүү дээ. Тэгээд гараа өргөвөл жоохон ингээд харагдахаар өргөхгүй бол энэ олон гишүүд дунд чинь төхөөрөмжийнхөө ард ингээд намхан суучихаар харагдахгүй байна шүү дээ. Нийт 24 санал. Зарчмын зөрүүтэй 24 санал байгаа. Нийт. Байнгын хороон дээр 12 санал нь дэмжигдсэн, 12 санал дэмжигдээгүй байгаа.

Тэгэхээр мэдээж энэ чухал гэрээ хэлцэлтэй холбоотой асуудал ярьж байгаа учраас тайлбар хийх шаардлагатай бол Засгийн газрын ажлын хэсгийн зүгээс тайлбараа сайн хийгээд явах нь зүйтэй. Энэ боломжийг хязгаарлах зүйл ерөөсөө байхгүй. Гол нь гараа сайн өргө. Харагдахгүй байна.

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 10 дахь дэд заалтын “үе шаттайгаар” гэснийг “зэрэг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан.

Б.Дэлгэрсайхан сайд. Ажлын хэсэг.

Б.Дэлгэрсайхан: Өчигдөр Байнгын хороон дээр Б.Жаргалан гишүүний гаргасан саналыг дэмжиж байгаа юм.

Тэгэхдээ энэ санал дээрээ бид ийм өөрчлөлт хийж өгөөч ээ гэж байгаа юм. Энэ “үе шаттайгаар” гэснийг “зэрэг” гэж оруулах гэж байгаа юм.

Тэгэхээр зэрэг бид өнөөдөр Гашуунсухайт-Ганцмодны асуудлыг ярьж байгаа болохоос биш бүх боомтын асуудлыг ярьж байгаа биш байхгүй юу.

Тийм учраас энэ дээрээ хэдүүлээ тэр орж ирсэн томьёоллоор нь байлгавал яасан юм бэ. Хэрэв “зэрэг” гэж оруулах юм бол “аль болох” гэж зөөллөж оруулахыг бид ажлын хэсэг дээрээ томьёолж өгч байгаа юм. Үүнийг бас зөв ойлгоорой. Тэгэхгүй бол энэ чинь нэг юм ярьж байгаа мөртлөө 4 боомт яриад тулгаад байхаар хүндрэлтэй байгаа шүү.

Санал гаргасан гишүүнд тодорхой санал байна уу? Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Энэ хэлэлцээрийн бас нэг чухал хэсэг нь манай талаас гарч байгаа гол ач холбогдолтой зүйл нь юу вэ гэхээр бусад боомтуудаа ашиглалтад оруулъя, бусад боомтуудынхаа хил холболтыг хийе гэсэн зорилго тавьж байгаа гэж ойлгож байгаа. Түүнийг манай Засгийн газрын гишүүд байнга хэлж байгаа. Тийм ээ.

Тэгэхээр энд тодорхой хэмжээнд хөнгөлөлттэй үнээр 16 жил “Чайна Энержи” компанитай гэрээ байгуулсны ар дээр эхний ээлжид Гашуунсухайт-Ганцмодын боомтын хил холболт хийгдээд, тэгээд араас нь нөгөө боомтууд явна гэсэн ийм л нөхцөл байгаа юм.

Тэгэхээр үүнийгээ л илүү хүчитгэх санаа байгаа юм. Одоо энэ зэрэг гэж оруулж байгаа нь. Тийм.

Тэгэхээр яах вэ, Б.Дэлгэрсайхан сайд өчигдөр Байнгын хороон дээр уг нь дэмжсэн юм.

Тэгэхээр гүйцээн боловсруулах чиглэл аваад ч юм уу, тэгээд ажлын хэсэг рүү оруулчихъя. Тийм ээ.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. /алх цохив/

4.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “харилцан ашигтай” гэсний дараа “хувилбарт шийдэл бүхий гэрээний хүрээнд” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал.

Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Энэ санал хураалт гацсан байна. Санал хураалтыг хүчингүй болгоод. Санал хураалт дахиж явуулахад бэлэн үү? Санал хураалт. /алх цохив/

Энэ санал хураалтыг хүчингүй болгоё. Бас гацчих шиг боллоо, сая. 30 секунд төхөөрөмжөө бас нэг ресет хийгээд бэлдсэн нь зөв байх. Тэгээд санал хураалт эхлүүлье. Бэлэн болоод над руу хэлээдэх. 30 секунд.

Болсон байна. Тэгвэл 4 дэх санал хураалт дахиж уншиж танилцуулъя.

Тогтоолын төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “харилцан ашигтай” гэсний дараа “хувилбарт шийдэл бүхий гэрээний хүрээнд” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг авъя.

Б.Энхбаяр: Яах вэ, бид нэг талаасаа чиглэл өгөх тогтоол гаргаж байгаа асуудлыг хэлэлцэж байгаа боловч одоо энэ гаргаж байгаа саналуудыг харахаар цаашид энэ чиглэлийн хүрээнд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний гэдэс дотор руу нь нэлээн орсон ийм саналууд харагдаад байна. Гэрээ байгуулахад эргэлзээтэй болох.

Жишээлбэл, “хувилбар шийдэл бүхий” гэдэг чинь “алтернатив сонголттой шийдэлтэй гэрээ” гэж байхгүй шүү дээ. Ингээд нэг гэрээн дотор хоёр сонголт. Алиныг нь ч барьж болох сонголтыг хоёр тал сонгох боломжтой ийм арилжааны гэрээ гэж байдаггүй шүү дээ.

Энэ чинь гэрээ гэдэг чинь тодорхой байдаг биз дээ. “А” замаар явах уу, “Б” замаар явах уу гэдгийг явцын дунд өөрчлөөд юм уу, сонгоод яваад байдаг.

Харин тухайн гэрээнээс олж байгаа үр дагавруудыг юм уу, шийдлүүдийг яаж зохицуулах вэ гэдэг шийдэлтэй нэг тодорхой гэрээ байх ёстой л гэж би

ойлгоод байх юм. Гэрээ бол тодорхой, ойлгомжтой л байж хатуу мөрдөгддөг зарчимтай.

Тэгэхээр гэрээг сонгож хэрэглэж болохоор Засгийн газарт чиглэл өгнө гэдгийг би ерөөсөө сайн ойлгохгүй байгаад байх юм. Энэ Засгийн газар өөрөө байр сууриа илэрхийлдэггүй юм уу? Энэ оруулж ирсэн асуудал дээрээ тайлбар хийж хамгаалахгүй байсан юм уу? Яагаад ингээд нэг тайлбар өгөхгүй ингээд ийм том том зарчмын асуудлаар мэдээлэл дутуу санал хураалт явуулаад байгаа юм бэ?

Д.Амарбаясгалан: О.Батнайрамдал гишүүн. Санал гаргасан гишүүн тайлбар хийх үү?

О.Батнайрамдал: Үүний гол агуулга нь ерөөсөө энд нөгөө сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсний гүн боловсруулалт. Тэр битгий хэл шар шороон шуурга гээд янз бүрийн асуудлууд байгаа юм л даа.

Тэгэхээр энэ нь бол бас өөрөө ч гэсэн, санхүүгийн талаасаа ч гэсэн янз бүрийн гэрээний хувилбартай байх гэж бодож байгаа.

Тэгэхээр тэрийг л илүү ойлгомжтой болгох хүрээнд харилцан ашигтай хувилбар шийдэл бүхий гэрээнд хамтран ажиллах. Нэг ёсондоо энэ шар шуурган дээр гэрээ хийхэд сэргээгдэх эрчим хүчний гэрээ энэ хоёр хоёр өөр гэрээ явах байхгүй юу. Санхүүжилтийн талаас ч гэсэн, хоёр талаасаа ч гэсэн.

Тэгэхээр үүнийг л илүү ойлгомжтой болгож тусгая гэж байгаа юм. Түүнээс биш.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: О.Батнайрамдал гишүүн бас буруу тайлбарлаад байх шиг байх юм.

Ингэж ойлгосон шүү дээ. Засгийн газраас өргөн барьсан энэ тогтоолд нэгдүгээрт нөгөө Ганцмод-Гашуунсухайт боомтын хилийн холболтын асуудлыг шийдвэрлэх. Тийм ээ. Энэ хүрээндээ тэр хөрс хуулалт хийх, нүүрс худалдаж авах гээд дагасан хоёр асуудал нь хамт шийдэгдээд. Эдгээр асуудал шийдэгдсэний үндсэн дээр цаашдаа сэргээгдэх эрчим хүчний салбар болон бусад салбар дээр хамтын ажиллагааг өргөжүүлэх гэдэг заалт орж ирж байна гэж ойлгосон шүү дээ. Тийм үү? Тэгээд тэр дээр нь ийм санал гаргаад байгаа юм уу?

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд тайлбар хийе.

Б.Дэлгэрсайхан: Би Б.Энхбаяр гишүүний хэлж байгаатай яг санал нэг байгаа юм.

Өчигдөр тэгээд Байнгын хороон дээр энэ саналаа хэлсэн боловч гишүүд бүгдээрээ хүч түрээд тэгээд хийчихсэн болохоор. Би одоо ямар гишүүдийгээ ямар ингээд. Үгүй одоо юуг нь нуух вэ дээ.

Яг үнэндээ хоёр Засгийн газар хоорондын хийх гэж байгаа үндсэн чиглэл батлах тухай тогтоолд ийм жижиг сажиг юм битгий оруулж өгөөч ээ. 3 гэрээ хийхдээ бид та бүгдийн саналыг аваад тусгаад явъя гэдэг ийм л санал хэлсэн юм.

Тийм учраас янз бүрийн өөрчлөлт. Бидний оруулж ирснээс өөрөөр агуулгыг нь өөрчлөх хэмжээний ийм юм битгий хийж өгөөч ээ. Харин дахин боловсруулах чиглэл өгнө гэдгээр эд нарыгаа цэгцлээд, агуулгын хувьд янзалчихъя, үг үсгийн хувьд янзалчихъя гэж байгаа болохоос биш.

Хамаа намаагүй энэ тэндээс нь өөрчлөлт хийвэл эрсдэлтэй шүү гэдгийг би өчигдөр ч хэлсэн. Түрүүн бас хэлсэн. Б.Энхбаяр гишүүн маш тодорхой хэлээд өгсөнд бас талархаж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өгчих үү. Тэгээд ярилцах уу? Байнгын хороон дээрээ. Тэгье. 4 дэх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө. /алх цохив/

5.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “дэд бүтцийн бүтээн байгуулалт,” гэсний дараа “орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутагт ажлын байр шинээр бий болгох,” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж.

Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

65.7 хувиар санал дэмжигдсэн байна.

6.Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Байтаг-Улиастайн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, Булган-Такашикен боомтод улсын хилийн 126, 127 дугаар тэмдгийн хооронд авто замаар улсын хилийн шугамыг дайран өнгөрөх цэгийг тохирч, хилийн гарц дээр шинээр нэмэх, нүүрс ачиж буулгах талбай, ачаа тээврийн терминал болон улсын хил дамнасан авто замын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэх талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохиролцох.” гэсэн 11 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Санал гаргасан Б.Пүрэвдорж гишүүнд үг өгье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр хил холболтын асуудлаар том хэлэлцээр явж байгаа. Энэ дээр тодорхой бүсүүдийн төмөр замын холболтын асуудлыг 10 дугаар заалтаараа нэмж өгч байгаа.

Тэгэхээр энэ дээр говийн бүс, зүүн бүсийн төмөр замын холболтын асуудлыг шийдвэрлэж, үүгээр нүүрс болон уул уурхайн бүтээгдэхүүнийг болон импортолж байгаа бараа, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх тэр асуудлыг шийдвэрлэсэн байгаа.

Тэгэхээр баруун бүсийн холболтын асуудал энэ дээр огт байхгүй байгаа. Тэгэхээр манай Ховд аймгийн Ярантын боомт бол байгалийн тогтцын хувьд жижигхэн.

Тийм учраас тэрүүгээр нийтдээ 300 машин гардаг. Түүний 180 машин нь нүүрсний экспортын машин гарч байгаа. 120 нь иргэдийн нэвтрэлт байдаг.

Тийм учраас нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, баруун бүсийн хөгжлийг илүү өндөр шатанд гаргахын тулд шинэ гарц нээж, зөвхөн түүгээр нүүрсний экспортыг гаргах ийм зорилтын хүрээнд. Мөн түүнчлэн Байтагийн боомт, Улиастайн боомт бол улиралд нэг удаа ажилладаг. Түүгээр жил 50-хан машин нэвтэрдэг.

Энэ боомтыг байнгын болгосноор өдөрт 500 гаруй машин нэвтрэх ийм боломжийг нээж өгөх юм. Ингэсний үр дүнд бас тодорхой МонЭнко болон Зүүн Хөшөөтийн, мөн түүнчлэн Хотгор зэрэг Увсын, Баян-Өлгий, Говь-Алтайн нүүрсний экспортыг нэмэгдүүлэх боломжийг нэмж өгч байгаа юм.

Ингэсний үр дүнд зөвхөн Ховд аймаг гэхэд 2 жилийн дотор энэ хавар 1 их наяд төгрөгийн эдийн засагтай болсон. 2 жилийн дотор нүүрсний экспортыг нэмэгдүүлсний үр дүнд 2 их наядын эдийн засагтай болох ийм боломжийг нээж өгч байгаа.

Энэ хүрээндээ яг энэ асуудлаар хэлэлцээрийн. Хэрвээ саад болохоор би энэ асуудлаа татаж авъя гэж ярьсан.

Гэвч Ерөнхий сайд болон яг энэ нэг асуудлыг хариуцаж байгаа Б.Дэлгэрсайхан, Ц.Туваан сайд нар энэ асуудал яг хэлэлцээд явах нь зүйтэй. Асуудлаа оруулаад хэлэлцүүлээрэй гэж зөвшөөрөл өгсний үндсэн дээр энэ саналыг оруулсан гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энэ нөгөө Б.Жаргалан гишүүний гаргасан саналтай ер нь нэгтгээд гүйцээн боловсруулахад орох нь зөв байх аа. Тэгэхгүй бол энэ чинь бусад хилийн боомтуудыг бас тус тусад нь ингэж оруулах болчихно шүү дээ. Тийм.

Тэгэхээр үүнийг юу яая. Б.Пүрэвдорж гишүүн. Үүнийг дэмжихгүй байгаа хүн байхгүй байх. Б.Жаргалан гишүүний гаргасан бусад хилийн боомтуудын холболтын үйл ажиллагааг үе шаттайгаар юм уу, нэг зэрэг эхлүүлэх юм уу гэдэгтэй энэ агуулга дотроо энэ бүгдийг оруулъя.

Та хэд маань Байнгын хороон дээрээ дахиж сайн ярилцаад гүйцээн боловсруулах ажил дээрээ оруулж ирэх нь зүйтэй. Тэгэхгүй бол бусад боомтуудын асуудлыг хөндөөгүйгээр энэ тогтоол дээр нэгийг нь хөндөөд явахаар энэ бас нэг өрөөсгөл асуудал үүснэ.

Тийм учраас гүйцээн боловсруулах асуудал руу чиглэл өгье.

Б.Пүрэвдорж гишүүний гаргасан санал бол зөв санал. Энэ бас баруун бүс нутгийн эдийн засагтай шууд холбогдох чухал асуудал учраас дэмжиж байна.

7.Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд “Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай” хэлэлцээр байгуулах ажлыг анхаарах.” гэсэн дэд заалт шинээр нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг.

Санал гаргасан гишүүнд микрофон өгье. П.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би бас энэ заалтыг хэлэлцээрт сөрөг нөлөө үзүүлчихгүй гэж бодож байгаа.

Ганцмод-Гашуунсухайт боомтын хил холболтын цэгээс гадна зарим боомтуудыг үе шаттайгаар холбох ажил байгаа.

Дээрээс нь Хятад Улс руу чиглэж экспорт хийж байгаа нийт бараа, бүтээгдэхүүний гуравны нэгтэй тэнцэх манайхаас гаралтай бараа, бүтээгдэхүүнийг Хятадын нутаг дэвсгэрээр 40 хувийн хөнгөлөлттэй тээвэрлэх асуудлыг урьд нь ярьж байсан.

Энэ асуудлыг Монголын Засгийн газар албажуулж байсан бөгөөд Хятадын Засгийн газраас яг хараахан албажуулж соёрхон батлаагүй ийм процесстой байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ асуудлыг зүгээр ямар ч байсан хөндөж энэ хэлэлцээрийг нь бас үе шаттайгаар асуудалд анхаараач ээ гэдэг зүйлийг ингээд өгч байгаа юм. Тэгээд энэ бол өөрөө эргээд Монгол Улсын уул уурхайн болон уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хямд тарифаар гуравдагч орны боомт дээр хүрч очно гэдэг бол экспортыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой хэлэлцээр байгаа юм.

Үүнийг Засгийн газар хил холболтын асуудал яригдаж байгаа дээрээ бас хөндөж ярилцаач гэдэг зүйлийг зөөлөн байдлаар оруулсан гэдэг зүйлийг хэлмээр байна.

Тэгээд та бүгд дэмжээд өгөөч ээ гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг. Борхүүгийн Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Түрүүн П.Сайнзориг гишүүн бас асуусан.

Тэгэхээр үүнийг гүйцээн боловсруулах чиглэл аваад тэгээд энэ найруулга дээрээ нэг болгож оруулчихвал ямар вэ. Тэгэхгүй бол өөр өөр заалт ингэж орж ирээд байхаар хэцүү юм. Үүнийг зөв ойлгоорой л гэж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Аль асуудалтай нэгтгэнэ гэж?

Б.Дэлгэрсайхан: Одоо ухаандаа П.Сайнзориг гишүүн ингээд транзит тээвэр гэж ярьж байгаа.

Энэ транзит тээврийн гэрээ хэлэлцээр бол Хятад Улстай бид хийчихсэн юм. Тэгээд Б.Жаргалан гишүүний ярьж байгаа нөгөө зэрэг холбох гэдэгтэй агуулга санаа давхцаж байгаа учраас үүнийг гүйцээн боловсруулахаар хамт аваад бид ярилцъя гэж бодож байгаа.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өгье. /алх цохив/

8.Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Бүтээн байгуулалтын болон олборлолтын бүх үе шатад Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.” гэсэн дэд заалт шинээр нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг гишүүнд микрофон өгье.

П.Сайнзориг: Дарга аа, үүнийг бас гүйцээн боловсруулах чиглэл өгчихдөг юм уу даа.

Би ингэж бодлоо. Сая Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж бас яг ийм агуулга төстэй ажлын байр бий болгох гээд.

Хоёрдугаарт, манай хэлэлцээр дээр гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлэх гэдэгтэй агуулга давхцаагүй шүү гэдэг зүйлийг би зүгээр хэлээд байгаа юм. Энэ бол нөгөө туслан гүйцэтгэгч гэдэг ч юм уу, тээвэрлэлт дээр манай тээврийн компаниудыг оролцуулаарай. Бусад бүтээн байгуулалт дээр манай барилгын компаниудыг оролцуулаарай гэдэг санаа байгаа юм.

Тэгэхдээ энэ ажлын байр гэдэгтэйгээ ер нь давхцаж байна гэж би өөрөө бас харж байна.

Тэгэхээр Байнгын хороон дээрээ нэг ярья. Агуулга орчихсон байна гэвэл бид хэд гишүүдээрээ ярьж байгаад олонхоороо шийдээд тэгээд буцаад орж ирье. Та гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. /алх цохив/

9.Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Төмөр замын ачаа тээвэрт хоёр тал тэгш эрхтэй байх, Монгол Улсын бусад аж ахуйн нэгж, байгууллагын ачааг тээвэрлэх боломжтой байх.” гэсэн дэд заалт шинээр нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан.

Засгийн газар. Ажлын хэсэг. Борхүүгийн Дэлгэрсайхан сайдад микрофон өгье.

Б.Дэлгэрсайхан: Ж.Алдаржавхлан гишүүний оруулсан төмөр замын ачаа тээвэр хоёр тал тэгш эрхтэй байх, Монголын бусад аж ахуйн нэгж, байгууллагын ачааг тээвэрлэх боломжтой байх гэдэг бол Зам, тээврийн яам хийх гэрээн дээрээ үүнийг оруулчихсан байгаа учраас энэ ингээд ерөнхий чиглэл авч байгаа гэрээ хэлэлцээр дээр ийм жижиг асуудлыг битгий оруулаач ээ. Үүнийг бас зөв ойлгооч ээ л гэж хэлэх гэсэн юм.

Үүнийг одоо тэгээд гүйцээн боловсруулахад бас хэлээд өгөөч гэж.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан гишүүн Жуковын Алдаржавхлан.

Ж.Алдаржавхлан: Өчигдөр хоёулаа хамт сууж байгаад л та чинь жигтэйхэн дэмжээд л, энэ ёстой хэрэгтэй заалт байна шүү дээ л гэсэн шүү дээ.

Тэгээд өнөөдөр ийм болохоор чинь яах вэ? Тэгвэл эргээд ярилцъя. Тэгэх үү. Дарга аа. Гүйцээн боловсруулах. Гүйцээх. Тийм.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өгье. /алх цохив/

Б.Дэлгэрсайхан сайд яалт ч үгүй хүчинд автсан юм шиг байна даа. Бүх санал дээр асуудал ярьж байна.

10.Тогтоолын төслийн 3 дахь заалтын “Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Г.Тэмүүлэн/-нд” гэснийг “Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж.

Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

61.2 хувиар санал дэмжигдлээ.

11.Тогтоолын төсөл дэх нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд “тээврийн багтаамж” гэснийг “тээврийн хүчин чадал” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин.

Байнгын хорооны дэмжсэн саналыг. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Энэ дэмжсэн санал байхгүй юу.

Тэгэхээр бид энэ үг хэллэгээ дотроо яриад гүйцээн боловсруулах чиглэл авчихъя л гэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Яг нэг ижилхэн агуулгатай зүйлийг хоёр өөрөөр хэлчихсэн байсныг жигдлэх л санаа байгаа.

Тэгэхээр “тээврийн багтаамж” гэх юм уу, “тээврийн хүчин чадал” гэх юмыг өөрсдөө дотроо ярьж байгаад гүйцээн боловсруулах чиглэл өгөхөд асуудалгүй байх аа.

Д.Амарбаясгалан: Энэ чинь тэгээд гүйцээн боловсруулах чиглэл өгнө гэдэг чинь энэ санал хүчингүй болно л гэсэн үг шүү дээ.

Нөгөө “тээврийн багтаамж” гэдэг үг нь хөндөгдөөгүй юм чинь.

Яах вэ, гүйцээн боловсруулах чиглэл өгье. Үндсэндээ Д.Энхтүвшин гишүүн тэгнэ шүү дээ. Нөгөө ижил байгаа заалт нь хөндөгдөөгүй байхад, энэ заалтыг өөрийн чинь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгнө өө гэдэг чинь тэр заалттай нь ижил болгоно л гэсэн үг шүү дээ.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Тэгвэл дутуу ойлгосон байна. Санал хураалгуулчихъя.

Д.Амарбаясгалан: Санал хураалт. /алх цохив/

39.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

12.Дээрх саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн дугаарыг өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж. Санал хураалт. /алх цохив/

58.3 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй саналуудыг танилцуулъя.

Түр завсарлаадахъя.

Энэ төхөөрөмж дээр бас нэг бага хэмжээний асуудал гараад байгаа юм байна. Тэгэхээр 10 минут түр завсарлаадахъя. 10 минутын завсарлага. /алх цохив/

ЗАВСАРЛАГА

Гишүүд ээ танхимд урья. Чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналаар санал хураалт явуулж эхэлнэ. Гишүүд суудлаа эзэлье.

Санал хураалт эхлүүлье.

1.Тогтоолын төсөл дэх нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд “Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн” гэснийг “Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин.

Д.Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтүвшин: Тогтоолын төсөлд яг нэг ижил агуулгатай зүйлийг бас гурван өөр янзаар хэлсэн байгаа.

Нэгдүгээрт нь, “Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын” гэж. Заримд нь болохоор “хилийн Гашуунсухайт боомтын” гэж. Заримд нь болохоор “Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн”, “Гашуунсухайт-Ганцмод боомтын” гээд гурван өөрөөр хэлчихсэн байсны нэг адилхан болгож өөрчилъе гэсэн ийм санал байгаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хороо яагаад энэ саналыг дэмжээгүй юм. Энэ зарчмын л санал байна шүү дээ. Нэр томьёог ижил болгоё гээд, жигдэлье

гээд нэг тогтоол дээр гурван өөрөөр биччихсэн байна гэдэг байж болохгүй л зүйл л дээ.

Р.Сэддорж дарга, Б.Дэлгэрсайхан гишүүн микрофон өгье.

Б.Дэлгэрсайхан: Д.Энхтүвшин гишүүн нэг саналыг тэгж өөрөө тайлбарлаад байгаа юм.

Түүнээс яг өгүүлбэр тус бүрдээ бол яг анхныхаараа байх нь зөв л гэж Ажлын хэсэг үзэж байгаа шүү дээ. Тэгээд дэмжигдээгүй байхгүй юу. Өгүүлбэр болгон чинь өөр өөрийн гэсэн утга агуулга агуулж байгаа учраас тэгээд ижил болгож болохгүй байгаа байхгүй юу. Тэр чинь. Тийм.

Д.Амарбаясгалан: Санал хураалт явуулъя. Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

44.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Замира горимын санал.

С.Замира: Баярлалаа. Энэ юу нь ажиллаагүй. Сая.

Тийм учраас энэ саналыг хүчингүй болгоод дахиж санал хураалт хийж өгнө үү гэж горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Санал хураалтыг хүчингүй болгох Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

51.0 хувиар санал дэмжигдлээ.

Нэг дэх санал хураалтаа дахиж хураалгана.

Тогтоолын төсөл дэх нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд “Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн” гэснийг “Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын” гэж өөрчлөх.

Санал гаргасан Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн. Санал хураалт. /алх цохив/

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төсөл дэх нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд “эдийн засгийн үр ашиг” гэснийг “эдийн засгийн өгөөж” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин.

Санал гаргасан гишүүн Д.Энхтүвшинд микрофон өгье.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурал тогтоол гаргаж байгаа юм чинь яаруу сандруу гэмээр хийчихсэн юм шиг яг нэг агуулгатай зүйлийг хоёр өөрөөр.

Трүүн бас санал хураалгасан тэр асуудалтай яг адилхан заалт байгаа. Энэ эдийн засгийн үр ашиг. Нэгэн дээр нь болохоор “эдийн засгийн үр ашиг” гээд биччихсэн нөгөөдөх дээр нь “эдийн засгийн өгөөж” гээд биччихсэн.

Тэгэхээр үүнийг бас жигдлэхгүй бол бид хууль тогтоох байгууллага байж байж яг энэ нэг агуулгатай юмыг хоёр, гурван янзаар хэлдэг нь зүй зохистой биш байх гэж бодож байна.

Тэгэхээр Та бүхнийг бас яг энэ бичсэн үг, үсгүүдийг нь хараад энэ дээр дэмжиж өгөхийг хүсэж байна. Бид нарын Улсын Их Хурлын хийж байгаа ажлын чанар харагдах учраас кнопдоо хүрэхгүй дэмжиж өгөхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн зүгээс Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан гишүүн үү? Ажлын хэсгийн ахлагч.

Энэ яагаад өөр өөр нэр томъёо хэрэглээд байгаа юм? Энэ асуудал дээр нэг тайлбар хийе.

Ц.Туваан сайдын микрофоныг өгье.

Ц.Туваан: Энэ дээр “эдийн засгийн үр ашиг”, “эдийн засгийн өгөөж” гэдэг байдлаар сольчихож болох байх.

Энэ одоо бараг ижил утгатай заалт. Тийм.

Д.Амарбаясгалан: Байнгын хороо иймэрхүү зарчмын саналуудыг хүлээж аваад гарч байгаа тогтоолоо жигдлэх тал дээр анхаарч байх хэрэгтэй шүү дээ. Их Хурлаас гарч байгаа тогтоол, бичиг үг үсэг, найруулгын хувьд алдаа дутагдалгүй гарч байх ёстой, хуулийн зөрчилгүй гарч байх ёстой. Аль аль талаасаа их хариуцлагатай ажиллаж байх ёстой шүү. Дутуу ажилласнаас болж л ийм саналуудыг гишүүд олон гаргадаг шүү дээ.

Тэгэхээр ингэе. Д.Энхтүвшин гишүүний энэ хоёр дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөөд, жигдлээд дараагийн хэлэлцүүлэг дээр оруулж ирэхээр шийдье. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. /алх цохив/

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын “16-г хүртэл жилээр тогтоох” гэсний дараа “нүүрсийг “Ганцмод боомт” нөхцөлөөр нийлүүлэх, тээврийг Монголын тал хариуцан гүйцэтгэх агуулгаар тохиролцох” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал.

Санал гаргасан гишүүн Ж.Золжаргалд микрофон өгье.

Ж.Золжаргал: Гурван аргумент хэлье.

Одоо хоёр жилийн өмнөөс эхлээд “хил нөхцөл”-өөр нүүрсээ хүргэдэг болсон шүү дээ. Төрийн өмчийн компани. Түүний үр дүнд орж ирсэн энэ татвар хураамжийн төсөвт орсон юм эрс нэмэгдсэн байгаа.

Тэрийг бас Та бүхэн анзаардаг байх.

Хоёрт нь, урьд нь “Чалко”-той байгуулсан бусад гэрээний жишгээр гэж байгаа нь тэр үнийн томъёо ашиглах зарчмаа л ярьж байна гэж би ойлгож байгаа.

Хятадын тал, худалдан авагч талд Монголын нутгаар явахад тээврийн эрсдэлүүд байгаа юм. Техникийн эрсдэл, зам арчилгаа энэ тэр.

Хоёрдугаарт нь, нөгөө шуурга болон байгаль цаг уурын.

Гуравдугаарт нь, бослого, янз бүрийн зам боодог иймэрхүү ажлууд явдаг.

Тэгээд үүнийг чинь гадаадынхан хэцүү шүү дээ. Зохион байгуулахад. Тэгээд энэ эрсдэлийг нь манайх аваад хил нөхцөлөөр хүргэж өгөх.

Гурав дахь аргумент бол ер нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа тээвэр, транзит тээврийг бид. Транзит тээвэр дээр бас л дийлэнх нь гадаадын том компаниуд. Хойд хөршийн.

Энэ эрдсийн нурмаг ачааны их хэмжээний тээвэр дээр урд хөршийн тээврийн компаниуд давамгайлдаг.

Тэгээд ийм том нутагтай, тээврийн үндэсний бодлого гэж байх ёстой. Хил нөхцөлөөр аваачаад өгөхөд нөгөө талдаа татгалзах тийм айхтар ноцтой юм бол байхгүй л гэж харах юм. Урьд нь бас ажлын хэсэг өнгөрсөн жилүүдэд “Чайна Энержи”-тэй ярьж байхдаа тийм л нөхцөлөөр ярьж байсан. Энэ зарчмаа тусгаж өгсөн нь дээр болов уу гэсэн ийм санал байгаа юм.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Ер нь яах вэ, анхны энэ томьёоллоороо явах нь зөв байх. Тэгэхгүй бол бид хоёр талдаа ярьж ярьж энэ чинь орж ирсэн томьёолол байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, урд хөршийн болгоомжлоод байдаг юм юу вэ гэхээр зэрэг өөрсдөө ирж хяналт тавина. “Хил нөхцөл” гэдгийн гол утга нь тэр тээвэртээ байгаа юм биш юм билээ.

Яагаад вэ гэхээр манайхан эндээс ачаад явуулахдаа дур нь хүрвэл коксжсон нүүрсээ ачдаг, дургүй нь хүрвэл хог ачаад явуулчихдаг. Тэгээд тэнд бас нэг ийм. Одоо энэ дээр ярихад ч хаашаа юм. Бас нэг тийм буруу зөрүү л юм байгаа юм байна лээ дээ.

Тэгэхээр энэ нь хуучин томьёоллоороо байх нь зөв байх л гэж би хэлсэн юм. Тэгээд дахин гүйцээн боловсруулахаар ойлгуулчихдаг юм уу, яадаг юм. Тэгвэл үүнийгээ санал хураалгачих л даа. Одоо тэгээд.

Д.Амарбаясгалан: Тогтоолын төслийн энэ 3 дахь санал хураалтыг Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

54.8 хувиар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын “жишиг болгож” гэснийг “зах зээлийн өнөөгийн нөхцөлд нийцүүлэн өөрчилж, суурь үнийг шинэчилж, үнийн индексийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын болон олон улсын зах зээл дээрх үнийн мэдээлэл, Монголын хөрөнгийн биржээр худалдаалсан нүүрсний үнийн мэдээллийг ашиглан тооцоолох,” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг.

Ж.Золжаргал гишүүн үг өгье.

Ж.Золжаргал: Саяын тэр тээвэртэй холбоотой юм бол одоо энэ олон мянган авто тээвэр, тэгээд шинээр барьчихсан төмөр замын асуудалтай...

Д.Амарбаясгалан: Энэ саналтайгаа холбогдуулж ярья.

Ж.Золжаргал: Энэ саналтай холбоотой жишиг болох үнэ 5 суурь үнээ эхэлж тохирдог.

Тэгээд Хятад Улсын 5 үнийн мэдээг ашиглаж байгаад индексээр өөрчлөлтийг нь боддог. Монгол Улс 2 жил бирж ажиллуулсан. Үр дүнтэй ажилласан 400 гаруй компани бүртгэлтэй. 25 30-аад сая тонн нүүрс зарчихсан.

Тэгэхээр цаашдаа бол энэ нь үргэлжлээд л явж таарна. Том гэрээ нь бол тогтворжуулна. Бирж нь бол нэмэлт шинэ оролцогчдыг оруулна.

Тийм болохоор энэ биржийнхээ индексийг авч ашиглах нь зүй ёсны асуудал. Ямар биржийн үнэ ингээд нөгөө талдаа тийм мухардсан хатуу юм тавиад байгаа биш.

Дээрээс нь одоо индекс 5 чинь тавуулаа Хятадын индекс шүү дээ. Нэг олон улсынхыг оруулаад ингээд 3 эх үүсвэрийг тэнцвэртэй ашиглавал энэ нь илүү зохистой болно гэсэн.

Би бол үүнийг ерөөсөө гэрээний нарийн заалт гэж харахгүй байгаа. Энэ бол зарчмын юм. Монгол Улсын өөрийнх нь тэр биржийн тухай хууль энэ тэр батлаад явсан сүүлийн 2 жилийн бодлого нь уламжлагдаад явах ёстой. Ийм л бодолтой байна. Хэрвээ Та бүхэн үүнийг дэмжиж байгаа бол гар хүрэхгүй байж өгөөрэй гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Нөгөө Ц.Туваан сайдын яриад байгаа чинь шууд аргачлалыг чинь бүгдийг нь өөрчилнө гэсэн л санал байх шиг байгаа шүү дээ. Тийм.

Ц.Туваан сайд үг авах уу?

Ц.Туваан: Энэ дээр бол одоо бас 3 гэрээний хоёр дахь хэсгийн нүүрс худалдах, худалдан авах гэрээний үнэтэй холбоотой асуудал.

Тэгэхээр энэ дээр бид ажлын хэсэг дээрээ хоёр дахь гэрээнийхээ бараг 90 хувь дээр тохирчихсон байгаа. Үнийн асуудал дээр ярилцаж байгаа.

Тэгэхдээ Хятадын талаас Та бүхэн “Эрдэнэс Тавантолгой” компанийн манайд борлуулж байгаа, манай төрийн өмчит болон хувийн өмчтэй компаниудад борлуулж байгаа үнээрээ өгчхөөч ээ. Бид илүү нөхцөл шаардахгүй ээ л гэдэг ийм саналыг тавиад байгаа. Тэгээд тэр үнийг нь боддог аргачлал нь Таны саяын хэлсэн тэр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 5 боомтын үнэ. Дээр нь суурь үнийг дундчилж процентолж гарч ирж байгаа үнэ байгаа юм.

Тэгэхээр ингээд олон улсын энэ тэр гээд заагаад өгөхөөр бас гэрээ хэлэлцээр гацах эрсдэлтэй гэж харж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

58.1 хувиар санал дэмжигдлээ.

Нэг дэх санал хураалтын дүн 53.6 хувиар санал дэмжигдсэн шүү. Би бас тэр дүнг тодруулж хэлье.

5.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 5 дахь дэд заалтыг “Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн /үүнээс 7 сая тонн нь баяжуулсан нүүрс/, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонн /үүнээс 5 сая тонн нь баяжуулсан нүүрс/-оос бууруулахгүй байх гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

54.4 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын “бууруулахгүй байх” гэсний өмнө “Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад нийлүүлэх нүүрсний нийт хэмжээг жилд 120 сая тонноос багагүй хэмжээнд хүргэх тохиролцоог хийх” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал.

Үг өгье. Санал гаргасан гишүүн.

Ж.Золжаргал: Нэгдүгээрт энэ бол арилжааны тохирсон юмтай саад болох зүйл байхгүй заалт.

Хоёрдугаарт нь, түрүүчийн хоёр татгалзсантай холбоотой. Яагаад гэхээр үнийн индексийг одоогийн байгаагаар. Энэ чинь жил болгон 1 их наядар тооцогдох ийм хэмжээний зөрүү гарна. Урт хугацаанд тогтвортой нүүрс нийлүүлэх гэж байгаа, хамтарч ажиллах гэж байгаа том гээд окэй байж болж байна гэж бид яг үзэж байгаа. Гэхдээ том зөрүү гарна.

Нөгөөх нь хил нөхцөлөөр гэдэг чинь бас л энэ Монголын тал дээрх ашигтайгаа холбоотой.

Тэгэхээр энэ аль алиныг нь байхгүй болгочихсон тохиолдолд 20 сая тонн нүүрсийг хямдралтай үнээр нийлүүлнэ. Маш их тоо. “Эрдэнэс Тавантолгой” компани энэ жил анх удаагаа 30 сая тонныг олборлож байгаа. Өөрөөр хэлбэл талаас илүүг нь хөнгөлөлттэй нүүрс эзэлнэ гэсэн үг.

Тэгэхээр Хятад улсын нийт авч байгаа хэмжээ нь бага байх юм бол одоо зах зээл олон улсын байдал юу байдаг юм. Тэгэх юм бол энэ чинь нийтээрээ Монголын нүүрсний үнийг л доош нь унагаана гэсэн үг. Эрдэнэс Тавантолгойгоос гадна ерөөсөө нийтээрээ.

Тэгэхээр бид урт хугацаанд тогтвортой байдлаар бараг нугалсан хямд үнээр нүүрс өгөх ийм нөхцөл байдал руу орж болзошгүй.

Тийм учраас нэгэнт хоёр улсын Засгийн газар яриад Монголоос авах нүүрсний хэмжээг ихэсгэе. Энэ дээр чинь бас нөгөө бусад боомтыг дараа нь үргэлжлүүлнэ гээд биччихсэн байгаа шүү дээ. Тэр агуулгаараа ойрын жилүүдэд, одоо хэдэн жил гэдгийг нь ажлын хэсэг шийддэг юм байгаа биз. 120 сая тонн. 160 ч гэж яриад байсан. Ядаж тэр 120 сая тоннд хүргэнэ гэдэг зорилтыг тавьчихвал тэр том улс чинь өөрөө бодлогоороо ирэх жил нүүрсээ хаанаас яаж авах вэ, хуваарилах вэ гэдгээ тогтоодог учраас ийм амлалт өгчих юм бол их гүрний тоон дээр үргэлжлээд манай талдаа бас ашигтай явна гэсэн аль аль талдаа ийм бодол байгаа.

Тэгэх юм бол тэр хямдруулсан нүүрсний хэмжээ чинь нийт хэмжээндээ бага хувь эзлэхээр зэрэг одоо тэр сөрөг нөлөөнд нь саармагжина гэсэн ийм агуулгатай байгаа гэж бодож байна.

Тэгээд Та бүхэн хэрвээ дэмжиж байвал гар хүрэхгүй байж өгөөрэй. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

Болдын Жавхлан сайдын саналыг дэмжсэнд тооцож протоколд авъя.

7.Тогтоолын төслийн 1 дэх заалтад Монгол Улсын тэргүүлэх чиглэлийн 14 мега төслийн “Хэрлэн-Тооно” ус дамжуулах шугам хоолой татах бүтээн байгуулалтын ажлыг хамтран гүйцэтгэх гэрээ, хэлцлийг 2025 оноос эхлэхээр зохион байгуулалтын арга хэмжээ авах” гэсэн дэд заалт шинээр нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат.

Санал гаргасан гишүүнд үг өгье.

Г.Очирбат: Д.Амарбаясгалан даргад баярлалаа.

Эхний санал дээр үг өгөхгүй шууд санал хураалгачих юм. Тэгээд Их Хурлын гишүүд минь энэ ингээд түүхэн, дахиад 21 жил хөндөгдөхгүй хэлэлцээр гэрээ хийгдэх гэж байгаа. 35 тэрбум долларын асуудал яригдаж байгаа.

Энэ дээр 2024-2028 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг баталж өгсөн.

Энэ дээр Говийн бүсийг бид аж үйлдвэрчдийн тэргүүлэх чиглэлтэй болгож өгсөн. Тэгээд говийн бүсэд аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлнэ гэхэд үнэхээр ус байхгүй гэдгийг энд байгаа Их Хурлын гишүүд бүгд мэдэж байгаа.

Мөн дээрээс нь бид тэр 450 мегаваттын цахилгаан станцаа 14 мега төслөөр үүнийгээ явуулах ёстой. Ингэхийн тулд дахиад л ус хэрэгтэй болно. Нөгөө баяжуулах үйлдвэрээ өргөтгөнө. Ус хэрэгтэй болно. Ингээд усны асуудал үнэхээр тэнд тулгамдчихсан байгаа.

Тэгэхээр та 126 эрхэм гишүүд минь энэ дээр хоёр талыг хараад зөв шийдвэр гаргаасай гэж хүсэж байгаа. Нэгд.

Хоёрт гэх юм бол хоёр том хөрш маань Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улс энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг мэдэж байгаа.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээ 10 мянган долларт хүргэхээр Монгол Улс зорьж байгаа. Аж үйлдвэрийн салбараа босгох гэж байгаа. Хилийн боомтуудаа хөгжүүлж байгаа. Ингээд олон энэ тал ач холбогдолтой гэдгийг Та бүхэндээ нэгд хэлэх гэсэн юм.

Хамгийн чухал асуудал бол 14 мега төслөө явуулахын тулд говийн бүс бол аж үйлдвэрийн үндсэн чиглэлтэй бүс байгаа. Ингэхийн тулд хэдүүлээ тэнд станцаа барих ёстой, уур байх ёстой, ус байх ёстой, цахилгаан байх ёстой, технологийн бүх шийдлүүдийг бид зоригтойгоор дэмжих ёстой шүү.

Үнэхээр хүнд хэлэлцээрийг хийж байгааг нь ойлгож байгаа. Тэгээд үүнийг хэлэлцээр дундаа оруулаад, ярилцаад усны асуудлаа шийдчих юм бол дараа дараагийн аж үйлдвэрийн салбарын хөгжлийн суурь нь тавигдах гээд байгаа шүү. Тэгээд та хэд маань энэ дээр кнопдоо хүрэхгүй байж энэ саналыг босгож өгөөрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

50.5 хувиар дэмжээгүй санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтын “хамтын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх” гэснийг

“ажлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцан зохион байгуулах хүрээнд оператор аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулах” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан.

Санал гаргасан гишүүнд үг өгье.

Б.Жаргалан: Энэ тогтоол болохоор Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгч байгаа тогтоолоо.

Тэгээд “Эрдэнэс Тавантолгой” ХК бол Монгол Улсын төрийн өмчит компани. Энэ компанид Монголын нийт ард түмэн бас хувьцаа эзэмшиж байгаа.

Чиглэл өгөхдөө тус компанийн хувьцааг бусдад шилжүүлэхгүй байх гэсэн зүйл, заалт бид оруулмааргүй байгаа юм. Үүнийг сая Байнгын хороон дээр асуухад цаад тал анх хувьцаа эзэмшинэ гэж байсан. Одоо түүнээсээ буулт хийсэн. Тэрийг бид баталгаажуулж байгаа юм гэсэн тийм тайлбар хэлээд байгаа юм.

Гэхдээ нэгэнтээ та хэд маань тэр гэрээ хэлэлцээрээ тэгээд тохирч байгаа бол заавал Улсын Их Хурлаас ийм сонин агуулгаар Монголын бүх хүн хувьцаа эзэмшиж байгаа компанийн хувьцаа эзэмшлийг нь ингэж тодотгосон ийм үг, өгүүлбэрээр чиглэл өгүүлэх гээд байх хэрэг байхгүй л гэж харж байгаа.

Тэгээд ер нь энэ тогтоолтой холбоотой саналаа хэлэхэд гишүүд найруулгын шинж чанартай ч гэсэн зөндөө саналууд гаргасан. Энэ тогтоолын төсөл өчигдөр ирсэн. Тэгээд үг үсгийн хувьд, найруулгын хувьд нарийн нюанстай, агуулгын хувьд тогтоолын төсөл дээр ажлын хэсэг тааруу ажилласан байна гэж хэлмээр байгаад байгаа юм.

Яагаад вэ гэхээр энэ тогтоол цаашдаа яг л энэ архивд үлдэнэ. Эрдэнэс Тавантолгойтой холбоотой, төмөр замтай холбоотой Улсын Их Хурлын тодорхой нэр бүхий тогтоолууд бол одоо ингээд он удаан жил эшлэгдээд л явдаг.

Тэгэхээр ийм чухал тогтоол дээр хамгийн том төрийн өмчит компаниудынхаа асуудлыг ингэж оруулсан нь ерөөсөө зохимжгүй л гэж харагдаад байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

48.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ухнаагийн Отгонбаяр гишүүн горимын санал юм уу? Горимын санал.

У.Отгонбаяр: Сая гол нь дэмжсэн санал өгсөн. Тэгээд болсонгүй. Саяын саналыг цуцлаад дахиад санал хураалгаж өгнө үү. Горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: У.Отгонбаяр гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

56.2 хувиар санал хүчингүй боллоо.

8 дахь саналаар дахиж санал хурааа. Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

61.9 хувиар санал дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 9 дэх дэд заалтыг бүхэлд нь хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

52.4 хувиар санал дэмжигдлээ.

10, 11, 12 дахь саналыг Батбаярын Жаргалан гишүүн гаргасан юм байна. Санал гаргасан гишүүн санал уншихаас өмнө өөрөө үг авч байна. Тийм ээ. Үг өгье.

Б.Жаргалан: Энэ үлдсэн 3 зарчмын зөрүүтэй саналын санал хураалтад орох 10, 11, 12 дугаар саналуудыг татаж байна.

Д.Амарбаясгалан: 10 дахь саналыг санал гаргасан гишүүн Батбаярын Жаргалан татлаа. /алх цохив/

11 дэх саналыг санал гаргасан гишүүн Батбаярын Жаргалан татлаа. /алх цохив/

12 дахь саналыг санал гаргасан гишүүн Батбаярын Жаргалан татлаа. /алх цохив/

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Үдээс өмнө бас жоохон цаг алдсан учраас үдийн цайны завсарлагагүйгээр асуудлаа хэлэлцээд явчих уу? Гишүүд санал нэг байна уу? Тэгвэл чуулганы хуралдааныг үргэлжлүүлье. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

**Хоёр.Европын сэргээн босголт, хөгжлийн банк
үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг
хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.12.23-ны өдөр өргөн мэдүүлсэн,
зөвшилцөх, хэлэлцүүлэх/**

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Индэрт урьж байна. Эдийн засгийн байнгын хороо одоо шууд хуралдана. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улс 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкныг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын Их Хурал соёрхон баталснаар тус банкны 61 дэх гишүүнээр элсэн орж байлаа.

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны захирагч нарын зөвлөл 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн тогтоол шийдвэр гаргаж, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг 1 дүгээр зүйл болон 12.1 дүгээр зүйлүүдэд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэжээ.

Тус хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд оруулсан өөрчлөлтөөр Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны санхүүжилтийн үйл ажиллагаанд Төв болон Зүүн Европ, Өмнөд болон Зүүн газар дундын тэнгисийн бүс нутаг болон Монгол зэрэг орнуудыг хамарч байсныг өргөжүүлж Сахарын цөлөөс өмнөх Африкийн бүс

нутгийн орнуудад үйл ажиллагаа явуулах боломж бүрдэж байгаа бол хэлэлцээрийн 12.1 дүгээр зүйлд оруулсан өөрчлөлт нь тус банкны санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалахын тулд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Захирлуудын зөвлөлд хөрөнгийн зохистой харьцааны хэмжүүрүүдтэй холбоотой тохирох хязгаарлалтыг тогтоон хадгалах эрхийг олгож байгаа болно.

Энэхүү хэлэлцээрт оруулсан өөрчлөлтүүд нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны дотоод засаглал, үйл ажиллагааны хүрээнд тус банкны үйл ажиллагааг төрөлжүүлж, банкны тогтвортой байдал болон гишүүн орнуудад үзүүлэх дэмжлэгийг хүрээг тэлэхэд чиглэгдэж байна.

Өмнө нь 2013 онд тус банкнаас Өмнөд болон Зүүн газар дундын тэнгисийн бүс нутагт үйл ажиллагаагаа тэлэх зорилгоор Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкныг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг манай улс мөн хүлээн зөвшөөрч соёрхон баталж байсан болно.

Тус хэлэлцээрт оруулсан өөрчлөлтийг 2025 оны 01 дүгээр сараас мөрдөж эхлэх бөгөөд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны гишүүн орнуудын дөрөвний гурваас доошгүй хувь нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хүчин төгөлдөр болох юм.

Энэхүү асуудал Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлж дэмжигдсэн. Иймд тус хуулийн төслийг хэлэлцэн соёрхон баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Хосбаяр танилцуулна.

Г.Хосбаяр гишүүнийг индэрт урьж байна.

Г.Хосбаяр: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг

хэлээгүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ганболдын Болормаа Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Олон улсын санхүүгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна.

Одоо Байнгын хорооны саналаар Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах санал хураалтыг түр хойшлуулъя.

Эдийн засгийн байнгын хороо давхцаад хуралдаад байгаа. Тийм ээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Гурав.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл
/Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал танилцуулна.

Индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүд болох “Алсын хараа-2050” Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэсний соёлоо дээдэлсэн, суурьшлын тогтвортой тогтолцоотой эдийн засгийн төрөлжилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвар бүхий бүс, орон нутгийг хөгжүүлэх гэж, Хархорум хотыг ЮНЕСКО-д бүртгэлтэй соёлын бүтээлч хот болгоно гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Хархорум хотын сэргээн байгуулах тухай 230 дугаар зарлигийг үндэслэн Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл болон түүнтэй холбогдуулан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж заасны дагуу Засгийн газраас Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Их Хурал 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан.

Уг хуулиар хотын төрөл, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотыг байгуулах, тэдгээрийн удирдлагын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, бүрэн эрх зэрэг хотын эрх зүйн байдалтай холбоотой харилцааг зохицуулсан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2025 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх хэдий ч эртний төрт улс болох Хүннү гүрний Луут хот, Жужаны Мумо хот, Уйгарын Хар хот, Түрэгийн хаад, ноёдын орд өргөөнүүд, Их Монгол Улсын нийслэл байсан Хархорум хотыг сэргээн байгуулж олон улсад таниулах замаар гадаад улс орнуудын хөрөнгө оруулалтад түшиглэн улсын төсөвт ачаалал бага үзүүлэн Хархорум хотыг бүтээн байгуулах ажлыг өрнүүлэх, хотын тасралтгүй хөгжих үйл явцыг дэмжих, хотын үйл ажиллагаатай холбоотой харилцааг цогц байдлаар зохицуулах зорилгоор бие даасан хуулийн төслийг боловсруулсан болно.

Нөгөө талаас манай улсын хувьд нүүдлийн соёл иргэншлээс суурин, соёл иргэншилд шилжих үйл явц хурдацтай явагдаж, орон нутгаас зөвхөн Улаанбаатар хот руу шилжин суурьших үйл явц идэвхтэй өрнөсний улмаас Монгол Улсын нийт хүн амын 48.9 хувь нь Улаанбаатар хотод амьдарч,

бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 70 хувь, худалдаа үйлчилгээний 84 хувь, их дээд сургуулиудын 96 хувь нь тус хотод төвлөрч байна.

Мөн энэ тоо 2030, 2040 онд хүн амын шилжин суурьшилтай холбоотойгоор нэмэгдэж, Улаанбаатар хотын нөхцөл байдал улам бүр хүндрэх зэргээс шалтгаалж шинэ хотуудыг байгуулж Улаанбаатар хот руу чиглэсэн төвлөрлийг сааруулах, бүс орон нутгийн хөгжлийг дэмжих практик хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Их Хурал 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай 7 дугаар тогтоолоор Хархорум хотыг байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал эрхэлсэн захиргааг байгуулж, дүрэм, бүтэц, орон тоог баталж, Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай иж бүрэн судалгаа хийх ажлыг зохион байгуулж, зарим судалгааны ажлууд хийгдэж дууссан байна.

Мөн Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах зориулалтаар Архангай аймгийн Өгий нуур, Хашаат сум болон Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрт нийт 189 мянга 363 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, газрын хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицолыг баталж, Хархорум хотын эдэлбэр газрын хэмжээ, эдэлбэр газрын бүсчлэлийг тогтоох, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал боловсруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төсөл нь 7 бүлэг, 36 зүйлтэй бөгөөд хот нь эртний түүхт Хархорум хотын түүх, өв, соёл, уламжлалыг илэрхийлсэн “Мөнгөн мод” бүхий бэлгэдэлтэй байна.

Хуулийн төслийн зорилго нь бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангаж, түүх, соёлын өвийг сэргээх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, оршин суугчийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байгаль орчинд ээлтэй ногоон техник, технологийн дэвшилд суурилсан Хархорум хотыг төлөвлөх төлөвлөлт хийхэд тавигдах шаардлага, хотыг бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Мөн хуулийн төслөөр хотын эдийн засгийн үндсийг тогтоож, хотын зарим үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлэх, хот мэдээллээ ил тод байлгаж, оршин суугчийн оролцоог дэмжиж, тэдний санал, санаачилга, шүүмжлэлийг өдөр тутамдаа хүлээн авч шийдвэрлэдэг, ахмад настан, бага насны хүүхэд, жирэмсэн эх, хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрах орчныг бүрдүүлсэн нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх хүмүүнлэг хот байхаар зохицуулалтуудыг боловсрууллаа.

Нийслэлийн авто замын газраас хийсэн судалгаагаар хотын түгжрэлээс үүдэлтэй алдагдсан боломжийн өртөг тооцох нь нэг машин өдөрт 2.5 цаг буюу жилд 407 цагийг түгжрэлд өнгөрүүлж, авто замын түгжрэлээс үүдэлтэй жилд 2.9 их наяд төгрөгийн үргүй зардал гаргаж байна гэсэн дүгнэлт гарсан.

Тийм ч учраас Улаанбаатар хотын хэмжээнд үүсээд байгаа асуудал бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлээр шинэ хотуудыг барьж байгуулах, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх нь нэн шаардлагатай юм.

Түүнчлэн хуулийн төслийг дагалдуулж Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд мөн нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Хархорум хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд туссан техник, эдийн засгийн үндэслэл бүхий барилгажилтын төслийн хүрээнд импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсвэл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг хотын зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар гаргаж болохоор хуулийн төсөлд зохицуулсан нь Улаанбаатар хотын хэт түгжрэл, төвлөрлийг сааруулж шинэ хот руу иргэдийн урсах урсгалыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох болно.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна.

Г.Уянгахишиг гишүүнийг индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хотыг байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд Засгийн газрын 2024 оны 21 дүгээр

тогтоолоор Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах зориулалтаар Архангай аймгийн Өгий нуур, Хашаат сум болон Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрт нийт 189 мянга 363.19 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамж болон бусад бүтээн байгуулалтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг үе шаттайгаар боловсруулж, хот төлөвлөлтөд иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, салбарын мэргэжилтнүүдийн санал, зөвлөмжийг тусган ажилласан байна.

Хууль санаачлагч Монгол орны төв хэсэгт үндэсний соёл иргэншлийн онцлогийг тээсэн, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангасан, сэргээгдэх эрчим хүч, ухаалаг тээврийн хэрэгслийн шийдэл бүхий иргэндээ ээлтэй хотыг байгуулахын тулд бүтээн байгуулалт, хөгжлийн асуудлыг дэмжихтэй холбоотой эрх зүйн нарийвчилсан зохицуулалт шаардлагатай гэж үзэж, Хархорум хотын бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулсан байна.

Засгийн газар оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой хотыг хөгжүүлж, шинжлэх ухаан, инновацад тулгуурласан ажлын байрыг бүс нутагт шинээр бий болгосноор хүн амын хэт төвлөрлийг бууруулахаас гадна дотоод, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх ач холбогдолтой гэж үзжээ.

Засгийн газар Хуулийн төслийг D-Parliament.mn цахим хаягт байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байна.

Мөн Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө хууль зүйн дүгнэлт гаргаж Байнгын хороонд танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон холбогдох хууль тогтоомжтой нийцсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар тус хуулийн төслийн зорилгод түүх, соёлын өвийг сэргээх, төрт ёсны, түүхэн уламжлал, онцлогийг харгалзан үзсэн зохицуулалтыг тусгасан эсэх, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалт, төлөвлөлт, архитектурын шийдлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар “Шинэ Хархорум” хотын статус, хэв шинж, төлөвлөлтийн талаар асуулт асууж хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд “Шинэ Хархорум” хотыг байгуулах асуудал нь үндэсний үйл хэрэг, эрмэлзэл, итгэл үнэмшил, татах хүч учраас хуулийн төслийг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд хэлэлцүүлгийн шатад уг төслийн хотын газар зохион байгуулалт, хот хөгжүүлэх сангийн талаарх

зохицуулалтуудыг боловсронгуй болгох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянганхишиг хотын эрх зүйн байдлыг тогтоох асуудлыг зохицуулахаас илүүтэй бүтээн байгуулалтыг дэмжих агуулгын хүрээнд хуулийн төслийг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл тухайн нутаг дэвсгэрт амьдарч байгаа иргэдийн асуудлыг анхаарч үзэх нь зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Хархорум хотын бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.8 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хархорум хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Хархорум хотын эдэлбэр газрын хил заагийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Гочоогийн Ганболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн бодлого хариуцсан зөвлөх, Батаагийн Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт, Нэргүйн Нацагдорж “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Баасанхүүгийн Энхсайхан “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны зөвлөх, Баярсайханы Амарсанаа “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, Мөнххуягийн Мөнх-Эрдэнэ “Шинэ Хархорум” бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны хуулийн мэргэжилтэн, Сумъяасүрэнгийн Энхжаргал Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын хуулийн мэргэжилтэн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт

харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууж хариулт авна.

Улсын Их Хурлын гишүүдээс намын бүлгүүдээс ирүүлсэн нэрсийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах.

Ж.Галбадрах: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Энэ төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Мэдээж Улаанбаатар хотын маань төвлөрөл хэт төвлөрөлтэй. Үүнийг сааруулахын тулд бид боломжтойгоор газрууддаа энэ хотынхоо шилжүүлэлт, мөн шинээр хотуудыг байгуулах. Энд Хархорум хот, мөн Шинэ Зуунмод хотын асуудлууд яригдаж байна.

Нийслэлийг задлаад төвлөрлийг бууруулахын тулд бид Хархорум хотын, үүний өмнө олон улсын төслүүд, багууд ирж өөрсдийнхөө төслийг танилцуулах дээр очиж уулзаж харж байсан.

Тэгээд энд асуумаар хэдэн зүйл байна. Энд юу вэ гэвэл хот байгуулахад эрх зүйн орчныг бий болгох зайлшгүй шаардлага байгаа. Тэгээд энэ эрх зүйн орчныг бүрдүүлэхэд одоо мөрдөгдөж байгаа хотын захиргаа, хотын статусын талаар мөрдөгдөж байгаа хуулиуд одоогийн энэ хуулийн төсөлд хэр төвөг саад, зөрчил учруулахаар ийм заалтууд байгаа вэ? Энэ талаар асууя гэж бодож байна. Ялангуяа шинээр хөрөнгө оруулалт их шаардаж байгаа.

Тэгэхээр хөрөнгө оруулагчдад тийм ээлтэй. Мөн шинээр хот байгуулж ажиллах нөхцөлд энэ зоригтой зохицуулалт хийх энэ хуульд хэр тусаж чадсан бэ гэдгийг асуумаар байна.

Тэгээд Япон Улсад жишээ нь 1950-аад онд Цүкүба /つくば市, Tsukuba-shi/ хотыг Токио хотын төвлөрлийг бууруулах зорилгоор байгуулж байсан жишээг энд авсан байна. Мөн Казахстаны Астана хотын шинээр хот байгуулсан туршлагыг энд судалж гаргасан тухай танилцуулгад дурдсан байна л даа.

Тэгэхээр би зүгээр Цүкүба хотын жишээн дээр ингээд аваад үзэхэд Цүкүба хотыг байгуулахдаа сургалт, судалгааны хот гэдэг нэрээр, тийм зорилгоор байгуулж байсан. Үүнийхээ төлөө яаж байсан гэвэл их дээд сургуулиудыг. Жишээлбэл, Токиогийн их сургуулийн салбарыг дотроо боловсролын их сургуулийн Цүкүба хотод байгаа. Цүкүбагийн их сургууль бол Токиогийн их сургуулийн боловсролын их сургууль юм ч гэдэг юм уу.

Судалгааны төвүүдийг бас маш сайн гаргаж байсан. Тэр лүүгээ. Жишээ нь, энэ дотроос ингэж явж байгаа JAXA_[Japan Aerospace Exploration Agency] буюу Японы сансар судлалын төв нь Цүкүба хотод байдаг. Одоо Америкаар хэлэх юм бол NASA_[National Aeronautics and Space Administration] гэсэн үг байх нь байна шүү дээ.

Ийм маягаар ийм том том судалгааны төвүүдийг гаргаж, эрдэмтдийг явуулсны хүчинд тэнд үнэхээр судалгааны тийм хот болж чадсан. Токиогоосоо 50 километр зайтай. Анх 160-аад мянган хүнээр төлөвлөж байсан бол одоо сая гаруй хүнтэй ийм хот болоод ингээд хөгжөөд явсан байна.

Түүнтэй адилхан манай энэ Хархорум хот маань аялал жуулчлалын бүс гэдэг утгаараа аялал жуулчлал талаасаа хэр их анхаарч ингэж оруулж ирсэн бэ? Угаасаа л түүх, соёлын маань үндсэн төв байгаа учраас.

Тэгээд 500 мянган хүнтэй хот байгуулъя. Өнөөдөр манайд одоо Дархан, Эрдэнэт хот маань 100 мянга л дөнгөж хүрч байна. 100 мянга байгаа энэ үед бид энэ 500 мянгаар гээд ингээд их том төлөвлөөд явах нь ямар байдаг юм?

Нөгөө талаас хамгийн гол нь хот төлөвлөөд явахад бэрхшээл учрах нь газрын асуудал байдаг. Тэгээд энэ газрыг манай өөрсдийнхөө юу гэдэг юм улсын мэдэлдээ байлгах ёстой?

Бид одоо ингээд газар чөлөөлөлтүүдийг Хархорум хотод эхэлж байгаа гэж байна. Тэгвэл одоо цаашид бид нарын байгуулах гэж байгаа зүй газар орон нутаг маань улсынхаа сан мэдэлд хэдэн хувь нь байж байна? Бид гаргаж төлөвлөлтөө хийснийхээ дараа маш хямд үнээр.../минут дуусав/

Х.Булгантуяа: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Анх удаа бид хотыг төлөвлөж байгуулж бас үзэх хэрэгтэй гэдэг ийм санаачилгаар энэ Хархорум хотын бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн.

Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгч энэ “Шинэ Хархорум” хотыг бүтээн байгуулъя, Хархорум хотоо сэргээн байгуулъя гэдэг зарлигийг 2022 онд гаргаад Засгийн газрын дэргэд Хархорум хотын захиргаа байгуулагдаж, өнгөрсөн хугацаанд олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаад, дэлхийн олон архитектур, төлөвлөлтийн компаниуд Хархорум хотыг төлөвлөө гэдэг санаачилгаа гаргаж илгээсэн.

Ингээд энэ нээлттэй тендер, сонгон шалгаруулалт уралдаан хэлбэрээр зохион байгуулагдсан.

Тэгэхээр дэлхий нийтийн анхаарал өөрөө энэ Хархорум дээр байна. Энэ Каракорум гэдэг энэ нэр бол дэлхийд ийм брэнд болчихсон ийм нэр юм байна.

Тийм учраас энэ Хархорум хотыг Монгол Улс сэргээн байгуулъя гэдэг санаачилгыг дэлхийн олон компаниуд сонирхож энэ уралдаанд оролцсон. Тэгээд энэ уралдаанд ирсэн материалуудыг бид нэгтгэж аваад цаашдаа энэ хотыг төлөвлөхөд бол ашиглах ёстой.

Энэ ч утгаараа Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль бол бид яг хотыг шинжлэх ухаанчаар анх удаа төлөвлөж үзэх гэж байна. Яг хот дээр ямар ямар шаардлагуудыг барих юм, хот нь бүсчилсэн ямар ямар чиглэлийн бүсчлэлтэй байх юм, тэргүүлэх чиглэл нь юу байх юм бэ гэдгийг ингэж төлөвлөх гэж.

Ер нь ирээдүйд 500 мянган хүнтэй хот байхаар цогцоор нь төлөвлөж байгаа. Энэ ч утгаараа энэ хууль бол өөрөө хотыг 500 мянган хүнтэйгээр төлөвлөсөн. Цаашлаад төр, хувийн хэвшлийн түншлэлээр бүтээн байгуулалтыг өрнүүлэх бололцоог бий болгосон.

Тийм учраас дагалдуулаад Гаалийн тарифын хууль дээр өөрчлөлт оруулснаараа хөрөнгө оруулалт хийх юм бол бас энэ татваруудаас чөлөөлдөг, татваруудыг хойшлуулдаг энэ эрх зүйн орчныг нь бүрдүүлсэн ийм хууль болж өгч байгаа.

Мөн Хархорум хотын энэ бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийн энэ хотын тэргүүлэх гол чиглэл бол аялал жуулчлал. Энэ бол мэдээж Их Монгол Улсын нийслэл байна гэж 1220 онд Хархорум хотын үндэс суурийг тавьж байсан.

Тийм учраас Хархорум хот тухайн цаг үедээ худалдааны “hub”_[төв] байсан.

Тэгэхээр худалдааны “hub” байна гэдэг бол яг тэр Торгоны замын тулгуур төв нь өөрөө Хархорум байсан.

Тийм учраас бид цаашдаа Хархорум хот бол худалдааны, аялал жуулчлалын ийм бүс нутаг байх ёстой гэж төлөвлөж байгаа.

Ер нь Орхоны хөндийд одоогоор тийм бие даасан хот байхгүй ч гэсэн жилд бараг 40-өөс 50 мянган жуулчид ирж очдог ийм ЖАЙКА_[Japan International Cooperation Agency]-гийн гаргасан.

Х.Булгантуяа: Тодруулах уу? Тийм ээ. Тодруулъя.

Ж.Галбадрах: Баярлалаа. Тэгээд хөрөнгө оруулагчдад ээлтэй, тэр ажиллах нөхцөлийг хангах тийм зоригтой зохицуулалтууд нь юу байна вэ гэдгийг би бас тодруулж асуугаад байгаа юм. Жишээлбэл, сая тэр Цүкүба хотын хэмжээнд Токиогийн их сургууль гарлаа гэдэг шиг одоо их дээд сургуулиудаас ямар сургуулиудыг тийш нь явуулах. Ер нь сургууль, эмнэлэг сайтай байж хот хөгждөг.

Тэгэхээр ерөнхий боловсролын сургуулиудаас ч байж байна. Энэ тал дээр ер нь ямар хөрөнгө оруулалтын зарчмууд байж байгаа вэ гэдэг талаар бас нэг тодруулчихъя. Баярлалаа.

Х.Булгантуяа: Б.Жавхлан сайд нэмж хариулъя. Биш ээ. Н.Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тэргүүлэх чиглэл бол аялал жуулчлал.

Тэгэхээр тэр ЖАЙКА-гийн судалгаан дээр дайрч өнгөрч байгаа 40-өөс 50 мянган хүний тоог хэрвээ бид бие даасан хотыг байгуулбал нэмэгдүүлэх бололцоо байгаа. Яг хуучны тэр туурийг нь сэргээж, олон улсад үзүүлэх, яг хуучны тэр Хархорумыг нь дахиж сэргээж тийм музей хэлбэрээр, аялал жуулчлалыг татах ийм чиглэлээр ажиллуулъя.

Дээрээс нь виртуал орчин дээр Хархорум хотыг бүтээн бүтээн байгуулчихсан юм билээ. Манай залуучууд.

Тэгэхээр виртуал орчныг нь ч гэсэн олон улсад сурталчилъя. Тэгээд цаашдаа их дээд сургуулиуд гэхээр энэ хотын 6 чиглэл дотор тэр боловсролын чиглэл нэг бүлэг хэмжээнд авч үзнэ.

Тийм учраас цаашдаа мэдээж их дээд сургуулиудыг нүүлгэх ажлуудыг ч гэсэн. Хэрвээ дэд бүтцийг нь шийдсэн тохиолдолд бид явуулж болно.

Тэгэхээр эхний асуудал бол нэг бүлгээр зохицуулчихсан хөрөнгө оруулалтынхаа орчныг нээж.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг. П.Сайнзориг гишүүн байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан.

Ж.Алдаржавхлан: Хархорум хотын асуудал аялал жуулчлалын байдлаар хөгжих нь зөв өө гэж ойлгож байгаа.

Гэхдээ би хоёр, гурван зүйл дээр эргэлзэж байгаа. Улаанбаатар хот маань ийм хүнд нөхцөлтэй, дулааныхаа асуудлыг шийдэж чадахгүй, цахилгааныхаа асуудлыг шийдэж чадахгүй байхад дахиад хот байгуулах тийм санхүүгийн бололцоо хэр байгаа юм бол. Монгол Улсад маань. Тэрийг нэгд хариулж өгөөч ээ гэж.

Хоёрдугаарт нь, саяхан бид 5 сард Хот, тосгоны тухай хууль шинээр баталсан. Тэр хуулиас тэс өөр зохицуулалт энэ дотор явж байна. Адилхан хотын зөвлөлтэй байна гэсэн мөртлөө тэс өөр.

Яагаад тэр хуулиас өөрөөр хийж байгаа юм бэ? Хот болгонд зориулж хууль хийх юм уу? Цаашдаа.

Яагаад дөнгөж сая 5 сард батлагдсан хуульдаа нийцүүлээгүй юм бэ?

Улсын Их Хурлаар чинь манай өмнөх парламентын гишүүд сууж байгаад тэр хуулийг баталсан шүү дээ. Энд яагаад нийцүүлсэнгүй вэ?

Дараачийнх нь, ер нь хот хэчнээн хүнтэй байя гэж тооцоолж байгаа юм. Ямархуу хэмжээний хөрөнгө оруулалт ер нь энэ хотыг байгуулахад хэрэгтэй юм бэ? Казахстан чинь тэс өөр шүү. Тэр Алма-Атаг зохион байгуулдаг. Астана чинь тэс өөр улс. Бяртай чадалтай улс. Том том санхүүгийн арга хэрэгсэл хэрэглэсэн. Гэхдээ одоог хүртэл Алма-Ата чинь Казакстан Улсын хамгийн том эдийн засгийн төв хэвээрээ л байгаа.

Тэгэхээр надад эдгээр зүйлийг хариулж өгөөч. Бидэнд яг одоо шинэ хот байгуулах тийм санхүүгийн бололцоо энэ Монгол Улсад байна уу, үгүй юу? Тэгээд яагаад энэ Хот, тосгоны хуулиас тэс өөрөөр хийж байгаа юм бэ? Саяхан батлагдсан хуулиас.

Тэгээд энэ хотод хэдэн хүн амьдрах юм, хэчнээн хэмжээний хөрөнгө оруулалт хэрэгтэй юм бэ? Би эсэргүүцье гээгүй шүү. Зүгээр энэ эргэлзэж байгаа юмыг асууж байгаа юм. Үүнийг хариулж өгөөч.

Х.Булгантуяа: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль тэр Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хууль Их Хурлаар хэлэлцэж байхад би ажлын хэсгийг нь ахалж байсан.

Тэгэхээр ажлын хэсгийг нь ахалж батлуулсан хүний хувьд өөрийнхөө ахалж батлуулсан хуулиасаа тэс өөр зохицуулалт оруулна гэж байхгүй шүү дээ.

Тэр хуулийг би ажлын хэсгийг нь ахалж байсан. Тэгэхээр яг ямар заалт нь Хархорум хотын хуультай зөрчилдөөд байгаа юм бэ гэдгийг бас та тодорхой асуувал би хариулъя.

Ер нь ямар ч хууль эрх зүйн орчин тухайн цаг үед нийгмийн хэрэгцээ шаардлагадаа нийцүүлээд хууль батлагддаг. Тэгээд үүргээ биелүүлсэн бол эсвэл шинэчилнэ, эсвэл нэмэлт, өөрчлөлт ордог, эсвэл тэр хууль ингээд л хүчингүй болдог.

Тэгэхээр ер нь хотын статусыг бий болгож байгаа, хотын бүтээн байгуулалтыг дэмжиж байгаа засаг, захиргаа нутаг дэвсгэрийн шинэ нэгжийг дэмжих гэж байгаа, бодлогын өөрчлөлт хийх гэж байгаа хуулиуд тухайн цаг үедээ хэрэгцээ шаардлагаа биелүүлээд тэгээд хууль хүчингүй болох ёстой.

Тэгэхээр Хархорум хотын бүтээн байгуулалтыг дэмжих хууль бол яг энэ цаг үедээ нийцүүлж батлагдаж байгаа. Тэгээд тодорхой цаг хугацааны дараа

энэ хууль нэмэлт, өөрчлөлт оруулна уу, шинэчлэн найруулагдана уу ингээд зохицоод явах ёстой.

Эхэнд нь бид яагаад энэ асуудлыг шийдэх гээд байгаа юм бэ гэхээр ер нь Улаанбаатар хотын энэ байгаа нөхцөл байдал анхнаасаа л төлөвлөлтгүй явж ирсэн. Анхнаасаа хуулиар нь бид шалгуур шаардлагыг нь тавиагүй, хуулиа биелүүлээгүй, дүрэм журмаар асуудалд ханддаг, газрыг дур өмчлүүлдэг, эд эзэмшүүлдгээс болоод л ийм байдалд хүрчихсэн. Аргаа бараад бид газар зохиомол Геодези, зураг зүйн газрыг Ерөнхий сайдын дэргэд авчраад нутгийн өөрөө удирдах байгууллагынх нь шийдсэнээр нэгж талбарыг нь нэгдсэн байдлаар олгоод эхэлсэн.

Тэгээд үүнийг ингээд хуульд нь амилуулж өгье. Анхнаас нь. Түүнээс биш энэ том хот болохгүй шүү гэж ингэж тооцож ерөөсөө болохгүй.

Ер нь хотыг ард түмэн өөрөө байгуулах юм билээ. Бид бол зүгээр дэд бүтцийг нь дэмжих ёстой юм билээ. Хууль эрх зүйн орчныг нь сайжруулж өгөх ёстой юм билээ. Тэнд хүн амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд л хөшүүрэг л хийж өгөх ёстой юм билээ.

Тийм учраас Орхоны хөндий дээр энэ 189 мянга 363 га газрыг яагаад бид улсын тусгай хэрэгцээнд энэ хуулиар авах гээд байна вэ гэхээр Архангай аймгийн Өгий нуур, Хашаат сум, Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрийн яг энэ Орхоны хөндийг түшиглэж байгаа энэ газар нутаг бол юун энэ чинь Улаанбаатар. Энэ чинь жинхэнэ хот байгуулж болох устай, ой модтой, хангай хосолсон яг ийм тал нутаг байгаа байхгүй юу. Энд бол том хот байгуулж болох. Энэ 1220 онд судлагдаад хамгийн боломжийн газар гээд тогтоогдсон.

Хэрвээ үүнийг улсын тусгай хамгаалалтад аваад одоогоос үүнийг статусыг нь ойлгомжтой болгоод шалгуур шаардлагыг нь тавиад төлөвлөж өгөхгүй бол энэ яг удахгүй зүгээр одоо нэг ийм хашаа байшингаар хөглөрсөн гэр хороолол болно шүү. Удахгүй.

Анхнаас нь хуучныхаа хотыг 189 мянган га-гаа Их Хурал тусгай хамгаалалтад аваад яг газар эзэмшүүлэх тэр ашиглуулах гээд байгаа харилцааг нь хүртэл.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ж.Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Зөндөө юм дутуу хариулж байна. Тэр ажлын хэсгийг нь хариулчих эсвэл.

Тэр хэдэн хүнтэй болох гээд байгаа юм бэ? Энэ Хархорум хот чинь. Хэчнээн хэмжээний хөрөнгө оруулалт хэрэгтэй юм бэ? Тэр Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийн 15.2. 3 дахь гэсэн заалтаас яагаад өөрөөр хийж байгаа юм бэ? Энэ хоёр заалт чинь зөрчилдөж байна. 15.2 дугаар заалт, 15.3 дахь

заалт чинь тэр хуультай зөрчилдөж байна. Үүндээ яагаад нийцүүлээгүй юм гэж асуугаад байна шүү дээ. Би тодорхой асуугаад байгаа байхгүй юу. Тодорхой л хариулаад өгчих надад. Хэдэн хүнтэй болох юм, хэдэн төгрөг хэрэгтэй юм, энэ Хот, тосгоны хуулийн энэ заалттай яагаад зөрчилдүүлж хийсэн юм.

Х.Булгантуяа: Ж.Алдаржавхлан гишүүн маш тодорхой асуусан шүү. Санхүүжилт, санхүүжилтийн эх үүсвэрийг яаж шийдэх юм гээд. Ажлын хэсгээс хариулах уу? Г.Ганболд зөвлөх хариулчих. Тэгээд дутуу байх юм бол Н.Учрал сайд хариулчих. Г.Ганболд зөвлөх. 19 номерын микрофон.

Г.Ганболд: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн саяын асуусан заалт бол зөвлөлтэй холбоотой заалт байгаа. Хотын зөвлөл байгуулах. 4 жилээр байгуулна гэсэн заалт байгаа. Энэ дээр бид энэ хууль дээр тэр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиас өөр зөрчсөн, тэр хуулиас зөрүүтэйгээр оруулсан зүйл байхгүй.

Тэгэхээр та тэрийг. Шилжилтийн үеийн зохицуулалт чинь. Үгүй ээ, одоо яагаад загнаад байгаа юм. Би одоо энэ.../минут дуусав/

Х.Булгантуяа: Н.Учрал сайд хариулдаа.

Н.Учрал: 15 дугаар зүйл бол нөгөө хотын зөвлөл юм. Ж.Алдаржавхлан гишүүн ээ. Хотын зөвлөл 21 гишүүний бүрэлдэхүүнтэй байна гээд заачихсан юм.

Тэгээд улсын зэрэглэлтэй хот байна гэж үзэж байгаа. Тусгай хуулиар зохицуулж байгаа. Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар бие даасан хуультай бол энэ хуульд хамаарахгүй гээд заалттай.

Түүнээс биш таны ярьж байгаа тэр зөвлөл бол яг энэ дээр адилхан зөвлөлөөрөө орсон. Зөвлөл бол Хот, тосгоны эрх зүйн байдлын хуультай адилхан зөвлөл нь сонгогдоод явна.

Хот өөрөө захирагчаа сонгох яг тэр Хот, тосгоны эрх зүйн байдлын хуультай ижил зохицуулалттай. Хотыг 500 мянган хүнтэй байхаар төлөвлөж байгаа. Хөрөнгө оруулалтын хувьд Засгийн газрын зүгээс бид гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, улсын төсөв, орон нутгийн төсвийн санхүүжилтээр дэд бүтцийг нь шийднэ.

Түүнээс биш 70 хувийн хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийднэ гээд тусдаа бүлэг зохицуулж өгсөн.

Ингээд Гааль, тарифын хуулиар татварын таатай орчнуудыг бүрдүүлээд энэ хот тосгоны.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ж.Алдаржавхлан гишүүн нэмж. Н.Учрал сайд нэмж хариулъя.

Маш тодорхой асуултууд асуугаад байгаа юм. Ж.Алдаржавхлан гишүүн.

Н.Учрал: 500 мянган хүнтэй байна энэ хот гэж төлөвлөж байгаа. Хөрөнгө оруулалтын хувьд бид одоо юу гэдэг юм тэд эд гэж хэлэхэд хэцүү шүү дээ. Улаанбаатар хотыг байгуулахад тэдэн төгрөгийн хөрөнгө оруулалт хэрэгтэй гэж яриагүй биз дээ.

Эхлээд бид дэд бүтцийг нь шийдэхэд улс, орон нутгийн төсөв, гадаад, дотоодын санхүүжилтээр бид ирэх жил бүтэн дэд бүтцийг нь шийдвэрлэхээр ажиллаж байна. Энэ дээр зөвхөн улсын төсвөөр шийдэх гээд байгаа юм байхгүй. Энэ дээр гаднын хөрөнгө оруулалтын асуудлуудыг шийдвэрлэнэ.

Тийм учраас энэ хуулийг дагалдуулаад тэр Гааль, тарифын хуульд өөрчлөлт оруулаад төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын бүр бүлэг байгаа юм. Энэ бүлгүүд батлагдчих юм бол Хархорум хот бие даасан статустай болоод, ингээд нэг захирагчтай болоод, ингээд цаашдаа сая Ерөнхий сайдын Арабын улсуудад айлчилсан айлчлалын үеэр хүртэл энэ Хархорумын талаар нэлээд их сонирхож байгаа. Тийм.

Х.Булгантуяа: Ж.Алдаржавхлан гишүүн тодруулъя. Хариулт хангалтгүй байна гээд байх шиг байна.

Ж.Алдаржавхлан: Н.Учрал сайд аа, би энэ ажлын хэсэг чинь орж ажиллана шүү. Энэ Хархорумын. Та бүгд намайг оруулж ажиллаарай.

Би Г.Ганболд гишүүн байсан. Тухайн үед. Яах вэ, тухайн үед би Хот, тосгоны хуулийг оруулж ирж энд сууж байхад чи энэ хуулиа тат гээд сууж байсан. Өнөөдөр өөр юм яриад сууж байна. Би тэрэнд чинь л харамсаж байгаа юм.

Тийм учраас одоо энэ Хот, тосгоны хуультай нийцүүлэх юмаа заавал хийнэ ээ. Энд чинь 5.2 чинь хотын зөвлөлийг чинь иргэдээ сонгоно гэж тэнд чинь заачихсан байхгүй юу. Гэтэл та нар мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оруулна гээд энд биччихсэн байна. Тэр хуультай зөрчилдөөд байна.

Тийм учраас тэр хуульдаа нийцүүлье ээ л гэж байгаа юм.

Х.Булгантуяа: Г.Ганболд зөвлөх хариулъя.

Г.Ганболд: Шилжилтийн үеийн зохицуулалт гэж бид оруулсан юм л даа.

Яагаад гэхээр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар 15 мянган иргэнтэй болсны дараа албан ёсоор энэ хуулийн дагуу иргэд нь зөвлөлөө сонгоод нийт иргэд нь захирагчаа сонгоод явдаг ийм зохицуулалт байгаа.

Гэтэл 15 мянган хүн амтай болтол нь өнөөдөр энэ хотыг бүтээн байгуулах, хөрөнгө босгох тэр процесс нь шилжилтийн үеийн зохицуулалтаар явах гэж байгаа юм. Энэ хуулиар оруулж байгаагаар.

Тэр агуулгаараа шилжилтийн үеийн зохицуулалт дээр захирагчийг нь Засгийн газар томилох. Мөн хотын зөвлөлийн эрх, үүргийг тухайн мэргэжлийн байгууллагууд, Засгийн газар, Их Хурал, хотын зөвлөлөөс санал болгосон 13 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл. Түр зөвлөл нь энэ шилжилтийн үеийн зохицуулалтыг хийж явахгүй бол болохгүй байна гэдэг агуулгаар ийм зохицуулалт.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ж.Алдаржавхлан гишүүн ажлын хэсэгт нь ороод ажиллаад явчих.

Амгаланбаатарын Ганбаатар гишүүн.

А.Ганбаатар: Өдрийн мэнд хүргэе.

Энэ Хархорум хотыг бүтээн байгуулах хөгжлийг дэмжих тухай хуулийг концепцын хувьд дэмжиж байгаа. Түүх уламжлал талаасаа 1220 онд байгуулагдаж байсан хот. Тухайн үедээ дэлхийн нийслэл байсан. Бүх шашны баян бүрд. Худалдаа, арилжаа наймаа, тэгээд дипломат алба, харилцаа гээд.

Тэгэхээр энэ хотоо дахин сэргээж байгуулах нь түүх уламжлал талаасаа зүйтэй. Дэлхийд бид юугаараа гайхуулах вэ. Чингис хаан, Хархорум хотоор. Нөгөө талаасаа Улаанбаатар хотын төвлөрөл. Тухайлбал, энэ дээр материал дээр ирсэн тоо баримтыг харахад хүн амын 49 хувь нь Улаанбаатарт, аж ахуйн нэгжийн 70 хувь, худалдаа, үйлчилгээний 84 хувь, их дээд сургуулийн 96 хувь нь төвлөрчихсөн байж байгаа.

Тэгээд төвлөрлийг сааруулах энэ талаасаа. Тэр Зуунмод хот төсөл, Хархорум хот төсөл бол зөв болно. Энэ үүднээсээ ингээд хоёр утгаараа дэмжиж байгаа юм.

Засгийн газраас мэргэжлийн багийг томилоод, зөвлөлийг байгуулаад, 15 мянган хүн хүрэх сонгуулиар удирдлага сонгох хүртэл нь мэргэжлийн багаа хурдан томилоод явуулах ёстой гэсэн саналтай байгаа. Өөрөөр хэлбэл Н.Учрал гишүүн хэлж байна. Энэ тусгайлсан хууль гээд гаргаад явчих юм бол энэ хууль чинь тухайн цаг үедээ үйлчлээд буцаагаад цуцлагдчих юм байна шүү дээ.

Тэгэхээр энэ хуулиа хурдан батлаад бусад хууль тогтоомжтой Их Хурлын Тамгын газрын хуулийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийг хараад уялдуулаад. Миний

ойлгож байгаагаар тусгайлсан хууль өөрөө давамгай байдлаа аваад, тэгээд энэ харилцаагаа зохицуулаад л буцаагаад хууль нь цуцлагдчих юм байна.

Тэгэхээр тусгайлсан хуулийг нь бид дэмжиж өгч батлуулах ёстой, батлаад өгчих ёстой. Тэгээд энэ мэргэжлийн баг гэдэг юм уу, энэ ашиглалтын өмнөх захиргаа гэж барилгын хэлээр ярихад хот байгуулах ашиглалтын өмнөх захиргааг нь хурдан байгуулж өгөөд ажилд нь оруулбал яасан юм бэ. Нэн тэргүүнд энэ дэд бүтцийн асуудлууд байж байна. Угаасаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгдсөн байж байгаа. Төмөр зам, агаарын тээвэр, хурдны зам, метро гээд.

Хамгийн түрүүнд бид мэднэ шүү дээ. Москвад байдаг электричкээр хот хоорондоо холбогдоод явдаг. Машины бөглөө хурдны зам байгуулахаас хамгийн хурд нь энэ хурдны галт тэрэг.

Тэгэхээр үүнийгээ хурдан байгуулаад засаг захиргааны байгууллагуудаа байгуулаад, сургууль, эмнэлэг, соёл, спортын байгууламжуудаа байгуулчих юм бол энэ хот руу чинь 15 байтугай 500, магадгүй тэгээд хэдэн саяараа нүүж очно.

Тэгэхээр энэ төслийг энэ утгаар нь дэмжиж байгаа юм.

Тэгэхээр Их Хурлын гишүүд хамгийн түрүүнд тэр тусгайлсан хуулийг нь баталж өгөөд дэмжээд Засгийн газар энэ ашиглалтын өмнөх захиргаа гэж би зүгээр яриад байна л даа. Өөрийнхөөрөө томьёолоод. Энэ мэргэжлийн багийг нь удирдлагатай нь томилж өгөөд хурдан ажилд нь оруулбал яасан юм бэ. Дэмжиж байна гэдгээ үүгээр илэрхийлж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: А.Ганбаатар гишүүн сая санал хэллээ. Тийм ээ.

Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл. О.Цогтгэрэл гишүүн байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Б.Энхбаяр гишүүн байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа.

Ж.Баярмаа гишүүний микрофоныг өгье.

Ж.Баярмаа: Монгол Улсын их гүрний үеийн эртний нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулах гэж байгааг дэмжиж байгаа. Маш ихээр дэмжиж байгаа.

Гэхдээ бас нэг асууж тодруулах санаа зовсон хэдэн зүйлүүд байна л даа. Тэр Орхоны хөндий маань өөрөө соёлын өв гэж ЮНЕСКО-д бүртгэгдсэн байгаа.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор, магадгүй тэр газар доогуурх судалгаа энэ тэр иж бүрэн хийгдсэн байдаг юм уу? Бас янз бүрийн соёлын өв энэ тэртэй тэнд хотын бүтээн байгуулалттай холилдоод яадаг юм, алга болох, устах ийм эрсдэл байх бий вий.

Тэгэхээр судалгаа хэр зэрэг хийгдсэн юм бол оо. Тэгээд хот байгуулалт, соёлын өв, газар доорх ялангуяа хэр их уялдаж аюулгүй байдал хангагдаж байгаа юм бол оо гээд нэгд.

Хоёрт, газар олголт гээд. Тэр чинь иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гээд байж л таараа. Тэд нар нь мэдээж тодорхой хэмжээнд бодвол зөндөө газар олгочихсон л байгаа байх.

Тэгэхээр энэ газар олголттой холбоотой асуудал яаж шийдэгдсэн юм бол. Үүнийг ер нь цаашид яаж шийдэх юм бол оо гэсэн ийм асуулт байна. Тэгээд сая яах вэ хөрөнгө оруулалтын тухай асуудлыг хөндөж байна.

Тэгэхээр ер нь одоо жишээлбэл гадаадын хөрөнгө оруулалт, одоо юу гэдэг юм орлоо гэж бодоход энэ тогтворжуулалтын гэрээ гэж ер нь байх юм уу? Гэтэл манай гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль нь ямаршуу байдалтай байгаа билээ. Тэгээд түүнтэй бас яаж уялдах юм бол оо? Тэр талынхаа юмыг бодож байгаа болов уу.

Яах вэ, гаальтай холбоотой, гаалийн тариф, татвартай холбоотой зохицуулалтуудыг хийж байгаа гэж сонслоо. Гэтэл хөрөнгө оруулалт, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой энэ асуудлууд нь яаж байгаа юм бол оо?

Тэгээд ер нь мэдээж хот төлөвлөлт хамгийн чухал. Тэгээд мэдээж төлөвлөсөн зүйлээ мөрдөх нь хамгийн чухал байгаа.

Тэгэхээр шинэ хот анх удаа шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөж байна гэж байгааг дэмжиж байна. Тэгээд мэдээж үүнийгээ маш сайн мөрдлөг болгож ажиллахад саад болох тэр бусад зүйлүүдийгээ маш сайн янзалсан байх ёстой байх.

Сая зөндөө л ярилаа. Энэ дотор ч байна. Тийм ээ. Нийт хүн амынх нь 49 хувь нь Улаанбаатарт төвлөрчихсөн. Агаарын бохирдол бол бүр ерөөсөө гамшгийн хэмжээнд хүрчихсэн. Зүгээр энэ жилийн статистик тоог ярихад л жишээ нь угаарын хийнд хордсон дуудлага 1989, 1990 орчим байсан юм байна. Тэгээд нас барсан хүний тоо гэхэд 39.

Тэгэхээр эндээс үүдээд би юу асуух гэж байна гэвэл энэ Хархорум хотыгоо эртний нийслэл байсан гэдгээр нь ер нь ирээдүйд нийслэлийн шинж чанартай хот болгох ийм амбиц энэ тэр байгаа юу?

Яах вэ, ер нь дахиад нэг зүйлийг лавлаад тодруулахад аль ч хот өөрийн гэсэн концепц байгаа.

Тэгэхээр үүнийг энэ танилцуулгаас уншихад соёл, аялал жуулчлалын ийм смарт ухаалаг маягийн хот байх юм байна гэж ойлголоо. Гэхдээ эдийн засгийн

голлох салбар нь юу байх вэ? Жишээлбэл, Эрдэнэт гэхэд чинь Эрдэнэтийн үйлдвэр дээр суурилж, Багануур гэхэд Багануурын уурхай дээр гээд, Налайх гэхэд Налайхын уурхай дээр суурилж бий болсон байдаг.

Гэтэл энэ маань эдийн засгийн тэр хөшүүрэг нь юу болж хувирах вэ? Ирээдүйд.

Тэгээд одоо бид чинь бас нэг төсөв яваад байгаа. Төсөл. Номтын хөндий гээд. Тийм ээ. Тэр тэр чинь одоо бас юу болох гээд байгаа юм. Засаг захиргааны төвлөрсөн нэгж тэнд бий болоод тэнд. Мэдээж нийслэл бол засаг захиргааны төвүүд нь байж тэр өөрөө нийслэл гэдэг статустай байна. Тэгээд тэр нэг тийм нийслэл болох гээд байна уу, үгүй юу?

Тэгэхээр энэ Хархорум хоттой яаж уялдах вэ? Тэгээд ирээдүйд нийслэл болох тийм амбиц ер нь байгаа юу гэсэн ийм хэдэн асуултуудыг асууя. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ж.Баярмаа гишүүний асуултад ажлын хэсгээс Нэргүйн Нацагдорж. 19 номерын микрофон.

Н.Нацагдорж: Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя.

Орхоны хөндий бол Монгол угсаатны үнэт зүйл. Үүнийг ЮНЕСКО-д 2004 онд Дэлхийн соёлын өвд бүртгэсэн. Энэ бол 183 мянган га газар байдаг. Энэ юугаараа бүртгэгдсэн юм бэ гэвэл Монгол угсаатны 5 нь нийслэлийн туурь байгаа. Газар доороо байгаа гэсэн үг. Үүгээрээ бүртгэгдсэн.

Одоо 20 жил болж байгаа боловч энэ Орхоны хөндийн ЮНЕСКО-д бүртгэгдсэн газрын төлөвлөлт, судалгааны ажил, яаж таниулах вэ гэдэг менежментийн төлөвлөгөөгөө боловсруулж чадаагүй байгаа юм.

Тэгээд энэ Хархорум хотыг барих газрын байршил бол энэ ЮНЕСКО-д бүртгэгдсэн Дэлхийн соёлын өвийн газар дээрээ давхцаж болохгүй. Доор нь түүхэн тууриуд байгаа учраас судалгааны ажил хийж байгаад үүний зэрэгцээ 189 мянган га газрыг хот барихад тохиромжтой хот орчмын бүс газар гэж тогтоогоод энэ дагуу Засгийн газрын шийдвэр гарч тусгай хэрэгцээнд авсан байгаа.

Энэ авсан газар дээр мэдээж аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшиж байгаа, ашиглаж байгаа газрууд байгаа. Тэгээд хоёр удаа Архангай аймаг, Өвөрхангай аймгийн иргэдтэй уулзалт хийж төлөвлөлтийн концепцыг танилцуулаад цаашдаа хот барихад иргэдийн оролцоог яаж хангах вэ гэдэг асуудал санал солилцоод эд нар бүгд дэмжээд тэгээд хоёр аймгийн иргэдийн хурлаас хүсэлтээ гаргаад ингээд Засгийн газраас тусгай хэрэгцээнд авсан юм.

Тэгэхээр цаашдаа энэ хотын төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангана гэж байгаа. Иргэдийн оролцоог яаж хангах вэ гэвэл тухайн газар үйл ажиллагаа явуулж байгаа тэр шинжийг нь алдуулахгүй байхаар төлөвлөлтөд тусгая гэсэн ийм бодолтойгоор явж байгаа.

Газар олголтын асуудлыг мэдээж хүмүүс Улаанбаатар хотод суурин газрууд олгогдож байгаа энэ ойлголтоор яваад байгаа. Энэ хот бүхэлдээ төлөвлөгдсөн байх учраас газар олголт гэдэг зүйл одоогийнх шиг биш ээ. Газраа авчхаад барилга байшин барих ийм төлөвлөлт явагдахгүй. Бүтээн байгуулалтынх нь төсөл нь өөрөө гарчихсан байх учраас хөрөнгө оруулалт, тэр бүтээн байгуулалтдаа чиглэсэн, тэрийгээ дагасан газрын шийдвэр гараад явна гэсэн үг.

Энэ хөрөнгө оруулалтыг яаж дэмжих вэ гэж байгаа юм. Энэ мэдээж тогтворжуулалтын гэрчилгээг энэ хууль дотроо оруулж өгсөн байгаа. Энэ болохоор Хөрөнгө оруулалтын тухай хуулийн тэр заалт, тарифаар оруулж өгсөн.

Мөн Шинэ Зуунмод хотын дэмжлэгийн тэр гарсан шийдвэрийн дагуу хийж өгсөн байгаа. Шинэ 100 мод шиг хийж өгсөн. Тэр зохицуулалт дотор нь хийж өгсөн байгаа.

Энэ төлөвлөлтийг яаж мөрдөх вэ гэдэг. Одоо энэ төлөвлөлтийн хувьд энэ хуулиар юу зохицуулах гээд байна вэ гэвэл төлөвлөлтөд тавигдах шаардлага, бүтээн байгуулалтад тавих шаардлагыг энд тавьж өгч байгаа. Одоо Монгол Улсын хот байгуулалтын хууль, Газрын хууль, бусад суурин газруудыг төлөвлөхдөө улсаас төлөвлөлтөд тавьсан тийм шаардлага байхгүй байдаг. Зарчмууд байхгүй байгаа.

Тийм учраас энэ дээр төлөвлөлтөд ямар ямар шаардлагуудыг тавих вэ гэдгийг заагаад өгчихсөн байгаа. Энэ төлөвлөлтийн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд.

С.Эрдэнэболд: Одоо манай улсын 2050 хүртэлх алсын хараа, тэрний наад талын дунд хугацааны бичиг баримт, дээрээс нь саяын Улсын Их Хурлын сонгуулийн намын амлалтууд гээд нийтдээ Улаанбаатар хоттой нийлээд 11 бодлогын бичиг баримт хэрэгжиж байгаа.

Эдгээр 11 бичиг баримт ерөнхийдөө харьцангуй хоорондоо уялдаатай, зохион байгуулалттай явж байгаа.

Яг Хархорумын тухай асуудал өөрөө зайлшгүй бие даасан хууль шаардлагатай байгаа юм. Одоо мөрдөж хэрэгжиж байгаа Хот, тосгоны тухай хууль ч гэдэг юм уу, эсвэл Үндсэн хууль дээр байгаа нийслэлийн зохицуулалт ч

гэдэг юм уу, энэ зүйлүүд Хархорумын эрх зүйн статусыг хангалттай хангаж чадахгүй ийм дүр зураг байгаа юм.

Тэгэхээр ер нь мэдээж эдийн засгийн тооцоо, үндэслэл, хөгжлийн үндэслэл, тэгээд дээрээс нь тэр зураг төсөл, маш олон тэр аялал жуулчлал ч гэдэг юм уу, ус, хот байхад шаардлагатай стандартуудыг ярихаас гадна урьдчилаад ер нь энэ зүйлийнхээ зэрэгцээгээр энэ хуулийн зохицуулалт дээр нь бүр маш чамбай, нямбай, олон улсын судалгаатай ажиллах ёстой байгаа юм. Тэгэхгүй болохоор одоогийн дүрэм буюу одоогийн эрх зүйн хэм хэмжээгээр ирээдүйн том үйл хэргийг хэмжих гэхээр нөгөө measuring point буюу хэмжих нэгж нь ойлгомжгүй болчихоод та нар ч гэсэн олон удаа гацаанд орчихно. Иргэдийн дунд ч гэсэн төөрөгдөл бий болох гээд байгаа. Шийдвэр гаргахад хүртэл энэ дээр тодорхойгүй байдал үүснэ.

Тийм учраас энэ Хархорум бол 2024 оны хөх луу жил энэ асуудал яригдаж байгаа. Өмнө нь хэлж байсан 1220 оны цагаан луу жил Чингис хааны зарлигаар 804 жилийн өмнө байгуулагдаж байсан.

Тэгэхээр бид энэ асуудал дээр ийм хөнгөн гоомой ерөөсөө хандаж болохгүй. Жишээлбэл, 2024 онд энэ шийдвэр гарлаа гэхэд 2034 онд энд ямар татах хүч байх юм. Эдийн засгийн. Дээрээс нь, энд төрийн байгууллагууд очих юм уу, үгүй юм уу, эсвэл энд олон улсын байгууллагууд байх юм уу, их дээд сургуулиуд байх юм уу.

Тэгээд дахиад 2044 он, 2054 он гээд. Жишээлбэл, Арабын Нэгдсэн Эмират бол 2117 гэдэг хөтөлбөр гаргачихсан. 2117 онд Марс гараг дээр Эмиратын хот байгуулна гэхчхэн ийм ультра төслүүд явж байгаа.

Мэдээж суурин соёл иргэншил нь олон зуун жил төлөвшчихсэн орнуудын хувьд гэх юм бол газрын асуудлаасаа болоод шинээр нийслэл гэхээсээ илүүтэй хамгийн ойрхон сая Казахстаны жишээ бол нийслэлээ нүүлгэсэн жишээ байгаа юм.

Монгол Улсад ямар потенциал байна гэхээрээ 1 сая 565 мянган километр квадрат нутаг дэвсгэрийн нутгийн яг төв цэг буюу хүй нь өөрөө энэ Өвөрхангай аймгийн энэ бүс нутаг бөгөөд энгийнээр жишиж хэлэх юм бол Хустайн нурууны дархан цаазат газарт 58 мянган га, Хархорумын энэ хот байгуулах гээд байгаа нь 190 мянга гэдэг бол Хустайн нуруунаас 3 дахин том талбарт хот байгуулалтыг төлөвлөх тухай ойлголтыг бид ярьж байгаа.

Энд бүр түүх, соёл дурсгал, ундны ус, тэгээд Монголчуудын сүсэг бишрэл, цаашлаад эдийн засгийн хөгжлийн механизм, түүнийгээ олон улсын зэрэгтэй төмөр зам, авто зам, онгоцны буудал гээд бүх л талаар нь цогцолбор байдлаар нь хөгжүүлнэ гэдэг бол зайлшгүй энд бүр онцгой хөгжлийн хууль гаргах ёстой.

Хархорум төсөл буюу энэ үйл хэргийг тодорхойлсон ийм хөгжлийн хууль гаргах хэрэгтэй юм.

Тэгэхээр энэ хуулийн үзэл санаагаа Засгийн газраас давхар явуулах зарлиг гаргасны хувьд Ерөнхийлөгчийн институцээс давхар явуулах шаардлагатай. Ингэж байж энэ хэлэлцүүлэг, олон талын мэдлэг, мэдээллүүдийг зөв эрэмбэлж, энэ зүй тогтлын дагуу бид энэ асуудалд ул суурьтай шийдвэр гаргана. Би бол энэ саналыг дэмжиж байгаа.

Тэгэхээр асуулт бол бие даасан хуулийг гаргалаа гэхэд ер нь үүнийг хэзээ шат санаачлах вэ? Энэ зайлшгүй шаардлага байгаа. Энэ хуулийн үзэл санаа яаж санаачлагдах вэ, ямар хугацаанд харж байгаа вэ? Энэ дээр ер нь ажлын хэсэг тодорхой төлөвлөсөн, бодсон зүйл байна уу гэж асууя.

Х.Булгантуяа: Ажлын хэсэг хариулах уу? Н.Учрал сайд.

Н.Учрал: Ер нь дэлхийн улс орнууд түүхэн хотоо сэргээн байгуулахдаа хэдэн гол шалгууруудыг тавьдаг.

Нэгд, хот төлөвлөлтийнхөө нарийвчилсан стратегийг боловсруулдаг. Дэд бүтцийг сайжруулах ажлуудыг хийдэг. Дэд бүтцийг орчин үед сайжруулахдаа дандаа орчин үеийн дэвшилтэт технологиудыг ашигладаг болчихсон байна.

Нэг ёсондоо хотыг төлөвлөхөөд түүнийг заавал виртуал орчин дээр гаргаж харж түүн дээр хөрөнгө оруулалтыг татах механизмуудыг хийдэг. Тэгээд түүхэн дурсгалт газруудыгаа сэргээн засварладаг. Тэгээд ер нь орчин үеийн бүх хотууд ногоон байгууламжийг нэгд тавьж байгаа. Энэ нь өөрөө тогтвортой хөгжлийн зорилтод нийцэж байна уу гэдгийг гол хэмжүүрээ болгодог. Ингээд гол нь иргэдийн оролцоог хангуулдаг. Иргэдийн оролцоо.

Тэгэхээр яг энэ стандарт шаардлагуудыгаа хуульчилж өгсөн хот цаашдаа яг хот төлөвлөлтийнхөө стандартын дагуу зөв төлөвлөгддөг. Одоо жишээ нь дэлхийн хотууд байна л даа. Японы тэр Кобе гээд хот 1995 онд болсон газар хөдлөлтийн дараа сэргээн босгосон учраас уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хот байх нь нэгдүгээр зорилт нь байсан. Жишээ нь, Германы Берлин II дайны дараа хотоо дахин төлөвлөсөн учраас орчин үеийн хотын загварт шууд шилжүүлж байсан.

Тэгэхээр бидний онцлог өөрөө Хархорум хот бол 1220 онд анх байгуулагдсан. Хамгийн гол нь бүс нутгийн хувьд өөрөө хамгийн зөв байршилтай. Цаашдаа даацын хувьд хангалттай хэмжээний хүн амьдрахад тийм даац бүхий. Цаг уурын хувьд, орчин нөхцөлийн хувьд хамгийн зөв байршилтай ийм хот.

Тэр ч утгаараа бид энэ хотыг сэргээн байгуулахдаа тэр хуучны түүхэн дурсгалт газрыг нь сэргээж орчин үе рүүгээ нийцүүлэх маш их чухал. Тийм ч

учраас Хархорум хотын тэргүүлэх чиглэл зайлшгүй л энэ түүхэн аялал жуулчлал чиглэл рүүгээ илүү хандах ёстой юм билээ.

Тийм учраас бид тэргүүн ээлжид түүхэн аялал жуулчлалын нөгөө “Мөнгөн мод”-оороо гол бэлгэдлээ хийсэн ийм хот байлгахад анхаарч байгаа. Энэ ч утгаараа хууль дээр хүртэл ингэж бичсэн.

Тэгэхээр Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих хууль нэг талаасаа бүтээн байгуулалт, хөгжлийг нь татварын бодлогоор, хөрөнгө оруулалтын бодлогоор, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дэмжихээс гадна бид энэ Хархорум гэсэн брэндийг дэлхийд сэргээн босгох, Монголчууд бидний гол ялгарал, ондоошил өөрөө үүнд байгаа.

Тийм учраас энэ Хархорум гэдэг энэ брэндийг дэлхийд нутагшуулах зорилгоор эхлээд Хархорум хотоо хуультай болгоё. Тэгээд хөрөнгө оруулагчдыг татах гол бодлогуудаа гаргаж тавья гэдэг утгаараа эхлээд Их Хурлаас Ерөнхийлөгчийн зарлигт.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар.

Б.Батбаатар: Байнгын хороон дээр зарим хариултуудыг авсан. Тэгээд болж өгвөл давхцуулахгүйгээр асууя.

Шинэ нийслэл бүтээн байгуулагдаж байгаа гэж ойлгосон. Тун удахгүй Хархорум Монгол Улсын шинэ нийслэл болох юм байна гэдэг ийм хариултыг Байнгын хороон дээр олж сонссон.

Тэгвэл энэ нийслэл хотоо шинээр бүтээн байгуулах гэж байгаа бол одоо энэ 2025 он, 2026 он гээд төсвөөс, дотоодын хөрөнгө оруулагчдаас, гаднын хөрөнгө оруулагчдаас олж ирж байгаа, оруулж ирж байгаа тэр зүйл байгаа юу, үгүй юу.

Мөн шинэ нийслэл Хархорум хот бүтээн байгуулагдахад одоо Улаанбаатар хот бонд гаргадаг шиг бонд гаргах, тэр хотыг бүтээн босгоход санхүүгийн эх үүсвэр, нэмэлт эх үүсвэрүүдийг татан төвлөрүүлэх тэр боломжуудыг нээж байна уу, үгүй юу?

Дээрээс нь энэ хууль батлагдсанаар нэгэнт Хот байгуулах тухай хууль гарчихна гэдэг бол хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээгээд эхэлнэ.

Тэгэхээр жишээ нь Хархорумд ирэх жил 2025 онд наадам болох уу, болохгүй юу. Улаанбаатарт болох юм уу? Хүй долоод болох юм уу? Хархоринд болох юм уу?

Ерөнхийлөгчийн зүгээс 2025 оны наадмыг Хархорумд хийх саналтай байгаа юм байна гэж би үүнийг ойлгосон.

Мөн бид 30 гаруй жилийн өмнө хүнд хэцүү цаг үед, дэлгүүрийн лангуу хоосорсон тэр үед Монголын ард түмэн бүгдээрээ нэгэн дуугаар сүслэн босож Мэгжид Жанрайсагийг дахин бүтээж чадаж байсан. Монгол бөхийн өргөөг бүтээж байсан. Засгийн газар хөрөнгө оруулалт бас хийж байсан.

Энэ бол ард иргэдийн оролцоо, итгэл үнэмшил, сүсэг бишрэл, зүтгэл мөрөөдөл, тэр генерац өгдөг тэр зүйлийг нь өдөөн гаргаж ирж байсан. Хархорум хот дээр ийм зүйл босгох тухай төлөвлөгөө байгаа юу, байхгүй юу?

Монголчууд бид бүгдэд нь тийм сэрэл мэдрэмж, үндэстний дархлаа байгаа гэдэгт би итгэж байгаа.

Дараагийн асуулт нь Хархорум хотыг бүтээн босгоход, шинэ нийслэлээ бүтээн босгоход бас улс төрийн дэмжлэг өндөр хэмжээнд байх шаардлагатай. Энэ хууль батлагдсаны дараа нь түрүүн маргаан үүсээд байсан. 21 хүнтэй нэг хот байгуулах зөвлөл гээд байж байна.

Түүнээс гадна энэ улсын төсвийг, улсын хуулийг тогтоож байгаа Улсын Их Хурал бусад энэ орон зайнд байгаа хэсгээс татан оруулж, тэр улс төрийн дэмжлэг үзүүлэх тэр бүтэц, бүрэлдэхүүнийг хийх тухай бодсон зүйл манай Засгийн газарт, Ерөнхийлөгчид байгаа юу, үгүй юу гэдэг. Энэ тухай ямар нэг төлөвлөлт, ямар нэг бодол санаа байна уу, үгүй юу гээд ийм хэдэн зүйлийг асуух гэсэн юм.

Тэр гаднын хөрөнгө оруулалтууд, хот бүтээн байгуулахад хэчнээн аж ахуйн нэгж, архитектор зураг төсөл бүх юманд оролцсон гэлээ.

Тэгэхээр ийм зүйлүүд дээрээ хэр итгэл үнэмшилтэй явж байна вэ? Энэ дээр тохирсон дундын болон урт хугацааны төлөвлөлт байгаа юу?

Х.Булгантуяа: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Хархорум хотын бүтээн байгуулалт дээр урьдчилсан ТЭЗҮ хийгдсэн.

Тэгээд түрүүн Н.Нацагдорж архитектор хэлж байна. Захиргаа байгуулагдаад нэлээдгүй ажлуудыг хийгээд. Ер нь захиргааны түвшинд хийх ажлаа хийж дуусгасан.

Ингээд урьдчилсан тооцоолол гарахад урьдчилсан ТЭЗҮ дээр бараг 26.4 тэрбум доллар зарж байж, хөрөнгө оруулалт хийж байж энд 500 мянган хүний амьдрах нөхцөл бүрдэнэ. Үүний 70 хувийг хувийн хэвшлээр л хийх ёстой.

Тийм учраас төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийх шаардлагатай ажлуудын бүлгийг гаргаж өгсөн. Ер нь Улаанбаатар хот өөрөө бүгдийг хийдэг,

дэргэдээ зах замбараагүй олон орон нутгийн өмчит компани байгуулдаг. Тэгээд хувийн хэвшлээ оролцуулдаггүй хав дараад суучихсанаас болоод л өнөөдрийг хүрчихсэн шүү дээ.

Тэгээд цаашдаа даацаа хэтрээд бүр дийлэхээ болилоо. Аргаа бараад Засгийн газраас нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх жил болгож дараа жилийг зарлах ийм шийдвэрийг Засгийн газраас гаргасан.

Тэгээд нийслэлийн асуудлыг шийдвэрлэх гээд энэ нэг бетоны ширэнгэ болчихсон газар мянга сайхан зам бариад, мянга сайхан трамвай, метро бариад энд нэмэр байхгүй шүү дээ. Улам л механик шилжилт нэмэгдээд ер нь тоолж дийлэхээ больчихлоо шүү дээ.

Тэгэхээр цаашдаа Улаанбаатар хотын дунд тулгамдсан асуудлыг Засгийн газрын зүгээс шийдэх дээр анхаараад ирэх жил ажиллая. Гэхдээ давхар шинэ Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг баталж байх үед Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хуулийг батлаад бас тусгай хамгаалалтад газар аваад. энэ Шинэ Зуунмод хотыг бид шинэчлэн зохион байгуулах гээд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хөөцөлдөөд ажиллаж байна.

Яг үүнтэй адилхан бид Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих чиглэлээр Засгийн газрын зүгээс жишээ нь Турктэй түүх, археологийн олдворыг сэргээх төсөл дээр хамтарч ажиллах гэдэг саналыг илэрхийлээд ажиллаж байна.

Сая Ерөнхий сайдын Арабын улсуудад айлчилсан айлчлалын үеэр яг энэ Хархорум хот дээр эрчим хүч, инженерийн дэд бүтцийн чиглэлээр ажиллах саналуудыг бодитойгоор бид илэрхийлсэн.

Австрали Улстай цэвэр усны шугам хоолой, ногоон байгууламж, сэргээгдэх эрчим хүчний төслийг хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Болгартай орон сууцын төслүүд дээр ажиллаж байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хотын ногоон байгууламж, сэргээгдэх эрчим хүчний төслийг хамтарч хэрэгжүүлнэ. Оросын Холбооны Улсын зүгээс барилгын материалын үйлдвэрлэл, дэд бүтцийн төсөл дээр ажиллана. Солонгосын Засгийн газартай сая Солонгос, Монголын Засгийн газрын комиссын хуралд би бас өөрөө очсон. Энэ үеэр КОЙКА_[Korea International Cooperation Agency] олон улсын байгууллага Шинэ Хархорум хотын түүх, археологийн олдворыг олон нийтэд таниулах дээр хамтарч ажиллая гэдэг саналаа илэрхийлсэн.

Тэгэхээр энэ бол олон улсын хөрөнгө оруулалт татах том төсөл болж хувирна. Хархорум хот бол.

Тийм учраас хуулиа гаргая. Цаашдаа Ерөнхийлөгчийн институт, Засгийн газар, гүйцэтгэх засаглал хөрөнгө оруулалтыг татах ажлуудыг хийнэ.

Х.Булгантуяа: Батын Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Нэлээн хэдэн асуулт асуусан учраас Н.Учрал сайд гүйцэж арай амжсангүй гэж хугацааг нь харж байна. Тийм болохоор Монголчуудын тэр үндэсний дархлаа, тэр сэврэл мэдрэмж, дээрээс нь бүгдээрээ нэг тийшээ харж энэ улс оронд бас нэг хот босгох ёстой. Уламжлалт түүхэн нийслэл хот маань босгох ёстой гэдэг энэ зүйл рүү хандуулах энэ чиглэл рүү хийж байгаа ажлууд нь юу байгаа вэ?

Дээр нь үүн дээрээ улс төрийн дэмжлэг. Одоо яг энэ хотын захиргаа хийх ажлаа хийгээд дуусчихлаа гэж байна. Үндсэндээ. Тэгэхээр энэ улс төрийн дэмжлэгийг нь бий болгохгүй бол энд харахад дэмжиж байгаа боловч жижиг сажиг зүйлээр тээг тавиад байдаг зүйлүүд байж болохгүй ээ.

Тийм болохоор энэ чиглэлийн зүйлийг гүйцээгээд хариулаад өгнө үү л гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Ерөнхийлөгчийн манлайлал их өндөр байгаа.

Ерөнхийлөгч зарлиг гаргасан. Өөрөө Хархорум хотоо сэргээн байгуулъя. Хааныхаа зуны өргөөг энд хийе. Гадна, дотнын жуулчид ирээд тэр мөнгөн модыг очиж үздэг, хардаг, хуучны тэр түүхэн дурсгалт газруудыг нь үзэж сонирхдог. Энэ виртуал орчин дээр Хархорум хотоо сэргээн байгуулаад дэлхий дахинд сурталчилъя гээд.

Гол нь Их Хурлаас ийм бие даасан хуулийг нь гаргаад өгвөл Ерөнхийлөгч өөрөө манлайлаад. Гүйцэтгэх засаглал үүнд оролцоод яг энэ хэрэгжиж байгаа төслүүд дээр гадна, дотнын хөрөнгө оруулалтыг татах ажил дээр ер нь бүгдээрээ нийлж ажиллая.

Парламент ч гэсэн энэ дээр санал санаачилга гаргаад хуулийг нь гаргаж өгөөд, цаашдаа Хархорум хотоо ард түмнийхээ оролцоотойгоор байгуулах дээр анхааръя.

Тэгээд төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалтын энэ бүлгийг Та бүхэн батлаад өгвөл энэ бол их маш том дэм болно.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Хосбаяр.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийг дэмжиж байгаа. Энэ хууль батлагдсанаар үндэсний бахархал болсон томоохон төсөл хэрэгжих эхлэл тавигдана гэж харж байгаа.

Энэ хуулийн төслийг манай Их Хурлын гишүүд дэмжих байх.

Ер нь бүс нутгийн иргэдийн эрх ашиг, тэнд амьдарч байгаа хүмүүсийн оролцоо, тэнд амьдарч байгаа өнөөдөр оршин суугаа иргэдэд ямар боломж бололцоо гарч ирэх юм гэдэг талын зүйлүүдийг нь бас манай энэ ажлын хэсгийнхэн, мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар сайн сурталчилгаа хийж судалгаа хиймээр байгаа юм.

Тэгэхгүй бол тэр бүс нутагт амьдарч байгаа зарим иргэдийн хувьд ойлголт нь буруу байна. Жишээлбэл, тэр бүс нутагт ажиллаж байхад зарим иргэд бид нар ч одоо Хархорумын Налайх болох байх даа гэж ярьж байгаа хүн хүртэл байгаа. Тэр ямар ойлголттой байна вэ гэхээр бид нарын оролцоо бага байна, бид нарт наалдах юм бага байна л гэж ийм ойлголт, ийм бодолтой байгаад байна гэсэн үг.

Тэгэхээр өнөөдөр тэнд амьдарч байгаа, тэр нутагт олон үеэрээ амьдарч ирсэн оршин суугаа тэр олон хүмүүсийн эрх ашиг, боломж бололцоог нь тодорхой болгож өгөх шаардлагатай болов уу гэж бодож байна.

Ерөнхий төлөвлөлтдөө мэдээж үндэсний онцлог, түүх соёлын онцлогоо шингээх ёстой. Би бас ажлын хэсэгт орж ажиллаж байгаа гишүүний хувьд энэ дээр тодорхой байр сууриа илэрхийлээд явна.

Энэ хотын 70 хувийг нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөрөнгө оруулалт татаж бүтээн босгоно гэж байгаа. Ер нь хот байгуулахад хамгийн чухал бид нарын ярих ёстой сэдэв мөнгө л байгаа. Тэгээд бид өнөөдөр төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиа өөрчлөөд 2023 оноос хэрэгжүүлж эхлээд явж байгаа. Ер нь 2023 оноос хэрэгжиж эхэлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар амжилттай хэрэгжсэн нэг ч төсөл байхгүй байгаа. Тэгэхээр бид энэ хуулиа бас эргэж харах шаардлага байгаа болов уу гэж бодож байна.

Сая Б.Батбаатар гишүүний хэлээд байгаа шиг түүх соёлоо босгож ирэх, Монгол үндэстэн нэг чигт харах, ер нь үндэстнээрээ хөдлөх, хөрөнгө оруулалт, нөөц боломжоо энэ рүү дайчлах, чиглүүлэх тал дээр тусгайлсан хууль, эрх зүйн орчныг гаргаж ажиллавал ямар байдаг юм бэ?

Өнөөдөр Монголын хувийн хэвшил монголчууд бид санхүүгийн хувьд ч гэсэн тодорхой хэмжээнд боломжтой болцгоосон. Өнөөдөр Монголын ард иргэд 20 гаруй их наядын хадгаламж Монголын банкнуудад байна. Хувийн хэвшлийнхэн бас зөндөө жил хийх, хөрөнгө мөнгөө гаргаад төртэйгөө түншлээд ажиллах ийм боломж бололцоонууд байгаад байдаг.

Гэтэл төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль буюу нэг тийм төр дэндүү өөрийгөө эрсдэлээс хамгаалсан ийм хууль гаргачхаад байхаар бас төвөгтэй байгаа юм.

Тийм учраас энэ хотыг бүтээн босгох дээр энэ хууль дээр тусгайлсан хөнгөлөлт, тусгайлсан татварын бодлого, тусгайлсан салбараар нь авч үзэх. Одоо энэ бол аялал жуулчлалын хот учраас аялал жуулчлалын салбарт илүү хөрөнгө оруулалт орж ирэх байх гэж харж байгаа. Энэ чиглэлд түлхүү анхаарвал сайн байна.

Тэгээд нэг асуулт байгаа нь энэ бүтээн байгуулалтын ажил эхлэхэд бэлэн болсон гэж зарим зүйлээс харагдаж байгаа.

Тэгээд яг ажлын хэсгийнхнээс асуухад энэ цэвэрлэх байгууламж, дулааны станц, зам, эрчим хүчний шугамууд хийх ажлын зураг төслүүд яг бэлэн болсон уу? Ер нь яг 2025, 2026 онд энэ бүтээн байгуулалтын ажлын эхлэлүүд яг тавигдах уу? Энэ ажлууд яг хэзээнээс хийгдэж эхлэх вэ гэдэг дээр бас нэг тодорхой хэлбэл сайн байна.

Б.Пүрэвдорж: Бүгдээрээ сайн байцгаана уу? Асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулна.

Н.Учрал: Манай ажлын хэсэг нэмээд тэр хийгдсэн ажлуудаа ярих ёстой байх. Тийм.

Маш чухал асуудлыг Г.Хосбаяр гишүүн хөндөж байгаа. Үнэхээр энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг бид амьдрал дээр хэрэгжүүлэх хэрэгтэй. Тэгээд төр, хувийн хэвшлийн түншлэл гэж яриад байдаг. Хувийн хэвшил яг юунд оролцохоо төдийлөн мэдэхгүй л байгаад байна шүү дээ.

Тийм учраас энэ ажил ингэж цогцоор нь харахын тулд энэ чуулгандаа багтаагаад бид Төрийн өмчийн компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулиа гаргаад төр ямар бизнест орох вэ, орохгүй вэ гэдгийг тодорхой болгоно. Тэгэхгүй бол хувийн хэвшилдээ гэнэт нэг сюрприз бариад л бизнесээ хийгээд төлөвлөөд хувийн хэвшил чинь явж байхад гэнэт төр тэр бизнест нь халдаж орж ирэхээр яаж хувийн хэвшлийн орон зай хангагдах вэ дээ.

Тэгэхээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг мөн бид шинээр өргөн барина. Дээрээс нь Хөрөнгө оруулалтын хуулийг бас шинээр өргөн барина.

Ингээд Засгийн газрын зүгээс Хөрөнгө оруулалтын хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль, энэ Төрийн өмчийн компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль гэсэн энэ хуулиудаа шинээр өргөн барина.

Үүний дараа бас их ойлгомжтой болно.

Энэ Хархорум хотын бүтээн байгуулалтын хөгжлийг дэмжих хууль дээр бид төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хот өөрөө юуг хийхгүй вэ гэдгийг зааглаж өгсөн. Хот бол авто зам, зогсоолын төлөвлөлт, арчлалт, засвар үйлчилгээ, хотын нийтийн тээвэр, такси үйлчилгээ, олон улсын болон орон нутгийн зорчигч, ачаа тээвэр, логистик, харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам, хаягдал ус зайлуулах байгууламж, ашиглалт, засвар үйлчилгээ гээд эдгээр ажилд оролцохгүй гэдгийг хуульд хийж байгаа.

Анхнаасаа оролцохгүй гэдгээ тоглоомын дүрмээ тодорхой болгох ёстой. Тэгэхгүй хөрөнгө оруулалт татаж оруулж ирдэг. Тэгээд нөгөө хэд нь ороод ирсний дараа дахиад булаацалдаад эхэлдэг. Тэгээд төр чинь сүүлдээ таны гэрт ороод бараг хоолыг чинь хийж өгөх, хувцсыг чинь угаах юм бараг хийх нь байна шүү дээ. Одоо бүр сүүлдээ. Хувийн хэвшилд бүр орон зай байхгүй болчихсон.

Тэгэхээр энэ асуудлыг хуулиар нь бид хийж өгнө.

Мөн таны хэлсэн энэ 130 гаруй мянган га газрыг улсын тусгай хамгаалалтад авсны дараа Архангай аймаг, Өвөрхангай аймгийн сумууд энд хамаарагдаж байна шүү дээ. Орхоны хөндийд. Түүний дараа шилжилтийн үеийн зохицуулалт дээр тэр зөвлөл байгуулагдана. Зөвлөл буюу одоогийн энэ нутгийн өөрөө удирдах байгууллага. Энэ зөвлөл байгуулагдсаны дараа зөвлөлд тэр хоёр аймгийн Засаг дарга хоёулаа орно. Үүний дараа Хот, тосгоны эрх зүйн байдлын хуультайгаа нийцүүлээд зөвлөлийг иргэд өөрөө сонгоно.

Тэгэхээр хоёр аймгийн иргэд улсын зэрэглэлтэй бие даасан хуультай хот болсноороо илүү анхаарал, илүү төрийн бодлого наашаа чиглэх юм байна л гэдэг бодолтой байхаас биш энд нэг тийм өөрчлөлт ороод, бид нарын үйл ажиллагаа, эрхэнд халдах гээд байна гэж ерөөсөө ойлгож болохгүй. Харин ч илүү анхаарал, төрийн бодлого.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 19 дүгээр микрофон нэмж хариулъя.

Н.Нацагдорж: Дэд бүтцийн ажлууд хийгдэж байгаа. Цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ, мөн эрчим хүчний ТЭЗҮ-гийн ажил тендер шалгараад аж ахуйн нэгж нь аваад хийж байгаа. Эндээс шийдлүүд гарч ирнэ.

Ирэх жилийн төсвөөр юу хийх вэ гэвэл дандаа энэ хотын ажлын зургууд хийх юм. Дэд бүтцийн ажлын зураг, хонгилын систем, эхний ээлжийн зам, эхний ээлжийн тэр ус зайлуулах системийн ажлын зургууд хийгдэнэ.

Тэгэхээр энэ шууд бүтээн байгуулалт руу орох бэлтгэл хангагдаж байна гэсэн үг. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ТЭЗҮ боловсруулагдсан. Олон улсын хэмжээнд зарлаад хийгдсэн. Ерөнхий төлөвлөгөөг энэ хуулиар хэн батлахыг нь тодорхойлж өгч байгаа. Өмнөх хууль дээр хэн батлах нь байхгүй юм.

Тийм учраас энэ хуулиар Засгийн газар батлахаар тодорхойлоод өгсөн байгаа. Үүний зэрэгцээ ирэх жилийн төсвөөр хийгдэх ажлын зургуудын төсөв тавигдсан. Бүх ажлын зургуудын даалгавар боловсруулагдаад эхэлчихсэн байгаа.

Тэгэхээр бүтээн байгуулалт эхлэхэд саадгүй. Тэгээд хотыг байгуулахад үндсэн 5 судалгаа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Г.Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Н.Нацагдорж дарга 2024 оны төсөвт бид зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах мөнгө гээд тавьсан.

Тэр бас тендер нь шалгарчихсан байх гэж ойлгож байна. 2025 онд мөн төсөв дээр зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах мөнгө тавигдсан. Тийм ээ. Тэрийг мэдэж байгаа. Тэр мөнгөнүүд дээр ТЭЗҮ хийнэ гэдгийг ойлгож байгаа.

Гэхдээ одоо та сая цэвэрлэх байгууламж хийгдэж эхэлсэн гэж байна. Энэ ер нь яг ямар эх үүсвэр, хаанахын санхүүжилтээр вэ? Ер нь үүн дээр нэмээд хэлэхэд цаашдаа бид гадаадын зээл, тусламжийн ашиглалт, энэ үр дүнг бас нэг ярилцаж үзэхгүй бол гадаадын зээлээр хэрэгжиж байгаа жишээ нь 10 аймгийн дулааны станцаас авхуулаад олон жил сунжирдаг, бас үр дүн муутай ийм зүйлүүд байгаа.

Тийм учраас ер нь энэ үндэсний бахархал болсон маш чухал энэ ажлууд дээрээ гадаадын зээл тусламж, энэ хөрөнгө оруулалт юман дээрээ бид бас нэг бодлоготой байхгүй бол нэг ажил цэвэрлэх байгууламж хийгээд зогсдог ч юм уу, нэг дулааны шугам татчихаад дутуу хаяад байвал бас их төвөгтэй.

Тэгэхээр энэ цэвэрлэх байгууламжийн төсөв хаанаас вэ? Ер нь гадаадын зээл.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 19 номер ажлын хэсэг.

Н.Нацагдорж: Энэ 2024 оны тавигдсан дэд бүтцийн ТЭЗҮ боловсруулах ажилд эрчим хүчний эх үүсвэрийг сонгох ТЭЗҮ, цэвэрлэх байгууламжийн технологийг сонгох ТЭЗҮ гэсэн энэ хоёр ажил хийгдэж байгаа. Үүний үр дүн 2025 онд гарч ирээд эндээсээ ямар технологийг сонгох вэ Хархорин орчимд, ямар үнэ өртөгтэй байх вэ гэдэг ерөнхийд нь гарч ирнэ. Тэгээд үүний дараа хөрөнгө оруулалтынх нь үндсэн том тооцоо гарч ирнэ. Тэрний дараа хөрөнгө оруулагчаа сонгоод дотоодын хөрөнгө оруулалтаар хийх үү, гаднын зээл, тусламж хөрөнгө оруулалтаар хийх үү гэдэг асуудал нь дараагийн ээлжид яригдах юм.

2025 оны төсөвт тавигдсан мөнгөөр энэ хотын үндсэн инженерийн шугам сүлжээний ажлын зургууд хийгдэнэ. Ажлын зургууд хийгдэх юм. Ажлын зургууд хийгдэнэ гэдэг маань төсөв үнэ тодорхой болно гэсэн үг. Хөрөнгө оруулагч орж ирэхэд хэчнээн төгрөгөөр ямар инженерийн шугам сүлжээ хийх боломжтой вэ гэдэг нь нээлттэй болно л гэсэн үг.

Б.Пүрэвдорж: Нэмэлтээр Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Баярлалаа. Хариулах юу байх вэ. Энэ Хархорум хотын ажлын албаныханд хандаж хоёр үг хэлэх гэсэн юм.

Ноднин 2023 оноос хойш л танай дээр нэлээн мөнгө тавигдаж байгаа шүү. Тэгээд ажлаа сайн хийгээрэй л гэж захимаар байна. Мөнгө тавигдаад байдаг, тавигдаад байдаг, гардаггүй.

Сая тодотгол хийж байхад та нар ч бүр болохоо байлаа гээд л бөөн юм болж болж болж нэмэлт 15 тэрбум төгрөг тавиулсан. Энэ жил 30 тэрбум төгрөгөөсөө хийсэн ажил юу ч байхгүй.

Одоо эхний 15 тэрбум төгрөгийнхөө дөнгөж гэрээг нь хийсэн сурагтай байна лээ. Ажлын үр дүн нь байхгүй. Одоо ингээд тэр тодотголоор тавигдсан 15 тэрбум төгрөг чинь одоо ингээд төсөвт татагдана. Гэрээ байхгүй, юу ч байхгүй.

30 тэрбум төгрөгөөрөө бүтэн яг дүн нь өөрөө, санхүүжих дүн нь 30 тэрбум гэж тавиулчихаад тэгээд гэрээгээ хийхдээ таслаад 15-аар тусдаа 2 ажил болгоод хийчихсэн байгаа юм байна.

Тэгэхээр чинь наад ажил чинь яаж явах юм бэ? Хоёр тусдаа тендер зарлах болчихож байгаа байхгүй юу.

Б.Пүрэвдорж: Нэмээд 1 минут. Тэгээд сүүлийн ажил нь байхгүй. Одоо 2025 онд дахиад 30 тэрбум төгрөг бүтнээрээ бас үргэлжлэх ажлууд нь тавигдсан байгаа. Одоо тэр дээр би маш их эргэлзээтэй байна. Ингэж их мөнгө тавиулаад ажил нь хийгдэхгүй бол ямар ч үр дүн байхгүй. Тэгээд энэ талаар та нар бас нэг мэдээлэл өгөөрэй. Олон нийтэд та нар энэ татвар төлөгчдийн мөнгөөр ингэж мөнгө төгрөг, санхүүжилтүүд тавьчихаад тэгээд ажил нь явдаггүй.

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүний оронд Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн хариулна асууна.

Уучлаарай. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Ганзориг: Хархорум түүхэн хотоо сэргээж энэ бүтээн байгуулалт хийгдэх гэж байгааг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Тэгэхдээ Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбоотой хэд хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, хуулийн зорилго нь жоохон ойлгомжгүй байгаад байна. Яагаад вэ гэхээр хуулийнх нь нэр нь бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай гээд нэрлэчихсэн. Хуулийн дотоод агуулга, зохицуулалтыг харахаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн заалтууд, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн заалтууд, Хот байгуулалтын тухай хуулийн заалтууд гээд их олон зүйлүүд агуулгаараа холилдоод орчихсон.

Тэгээд эндээс түрүүн ч бас гишүүд асууж байна. Нэлээн хуулийн давхардлууд үүсэж байна. Энэ хуулиудын. Мөн үүнтэйгээ холбоотойгоор зөрчлүүд үүсэх гээд байна.

Тэгэхээр үүнийг хэр нийцүүлж яаж харж байгаа вэ гэдгийг тодруулмаар байна. Тэгээд хуулийн маань яг үндсэн зорилго нь юу юм бэ? Шилжилтийн үеийн зохицуулалтууд орсон гээд байгаа. Тэгвэл үүнийгээ тусад нь салгаад зохицуулаад явж болохгүй юу?

Хоёрдугаарт, үүнтэй холбоотой Шинэ Зуунмодын хотын эрх зүйн байдлын тухай хууль гээд өнгөрсөн хавар батлагдсан. Яг энэ хотын асуудлыг тусдаа эрх зүйн байдлыг нь хуулиар зохицуулаад байгаа.

Тэгэхээр Шинэ Хархорум хотын хувьд яг энэ хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтынхаа асуудлуудыг тусгасан хэсгээ тусад нь дэмжиж, том бүтээн байгуулалтаа дэмжиж батлаад, тусад нь Хархорум хотынхоо эрх зүйн байдлын тухай хуулийг тусад нь батлаад салгаад явж болохгүй юу гэдэг ийм зүйлийг хоёрт тодруулж асуумаар байна.

Гуравт, хот бүтээн байгуулах гэдэг асар том хөрөнгө оруулалт, маш нарийн тооцоо судалгаа, олон асуудлуудыг тусгаж байж явах ёстой. Тухайлбал, яг энэ хуульд энэ бүтээн байгуулалтад, энэ хот маань яг ямар концепцтой явах гээд байгаа юм бэ? Аялал жуулчлал гээд байна.

Яг эдийн засгийн ямар бүтэцтэй хот байх юм? Тэрийгээ ямар ямар бизнесүүдээр, ямар салбаруудаас дэмжиж эдийн засгаа бүрдүүлэх юм бэ? Тэнд иргэд нь яг юу хийж амьдрах юм, хэр ажлын байр бий болох юм? Түүнийгээ дагаад. Амьдралын хэв маяг нь ямар байх юм гээд. Үүнийгээ яг энэ хуульдаа яг энэ бүтээн байгуулалт, хөгжлийнхөө хуульд яаж тусгаж уялдуулж байгаа вэ гэдгийг гуравт асуумаар байна.

Дөрөвт нь, бид нарын энэ том бүтээн байгуулалт хийх гэж байгаа саяхны сургамж гэх юм бол Улаанбаатар хотын хот төлөвлөлтийн том алдаанууд байна. Утаа, түгжрэл гээд гамшиг болчихсон. Шинэ суурьшлын бүс гээд Яармагт бид шинээр бас бүтээн байгуулалтууд хийсэн. Эргээд л Улаанбаатараа давтаж байгаа. Хөшигийн хөндий бас ялгаа байхгүй болж байна.

Тэгэхээр Улаанбаатарыг дахин давтахгүйн тулд яг энэ хууль эрх зүйн орчин болоод бусад хариуцлагын асуудлуудыг яаж тусгаж тооцоолж явж байгаа вэ? Энэ Шинэ Хархорум хотын төслийн ажлыг хариуцаж байгаа Н.Нацагдорж дарга олон жил олон удаа нийслэлийн ерөнхий архитектур ажиллаж байсан хүн байна.

Тэгэхээр Улаанбаатар хотын төлөвлөлт, энэ зүйл дээр гарсан алдаануудаа дахиж давтахгүй гэсэн баталгаа нь хуульдаа яаж хангагдаж байгаа вэ гэдэг ийм 4 зүйлийг асуумаар байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хариултыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулна.

Н.Учрал: Ер нь анх хотыг төлөвлөхдөө анхнаас нь хууль эрх зүйн орчин тодорхой, тэр эрх зүйн орчин дотроо Төр, хувийн хэвшлийн түншлэл, тэр шинжлэх ухааны байгууллагуудын оролцоо, тэр эко систем гэдэг зүйлийг их тийм зөв анхнаас нь тогтоож өгөхгүй болохоор юу болдог вэ гэдэг нь өнөөдөр Улаанбаатар хотын байгаа байдлаас харагдана л даа.

Тийм учраас бид их хожуу хойно нийслэлийн эрх зүйн байдлын хуулиудыг шинэчилж найруулж өнгөрсөн парламентад баталж өгсөн. Ингээд өнөөдөр хот өөрөө бие дааж бонд босгоод, хөрөнгө санхүүгээ босгоод, бие дааж хөгжих бололцоо нь их хожуу хойно бүрдлээ л дээ.

Түүнээс биш хуучнаар засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгждээ боомилгодоод өнөөдөр 2 мянга хүрэхгүй хүнтэй сум, 300, 400 мянган хүнтэй болчихсон. Дүүргийн статустай яг ижилхэн түвшинд яваад байхаар 20, 30 хүнтэй хороо 30 мянган хүнд хүрч үйлчилнэ гэвэл байхгүй.

Тийм учраас Хархорум хотыг ирээдүйд бид хэдэн хүнтэй, ямар том хэмжээний хот болох вэ гэдгийг бодож төлөвлөж байж өнөөдөр анхнаас нь их зөв хийе гэдэг утгаараа Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийг боловсруулсан.

Тэгэхээр хөгжил гэдэг бол их өргөн агуулга. Хөгжил өсөлт хоёр өөр. Тэгэхээр хөгжлийг бий болгохын тулд дотор нь статус нь тодорхой болж байж хөгжилд хот өөрөө ямар үүрэг оролцоотой байх вэ гэдэг нь тодорхой болж байж хөгжил өргөн агуулгаараа цаашаа явна.

Түүнээс биш зөвхөн эрх зүйн байдлын статусыг ойлгомжтой болголоо гээд хот чинь өөрөө амьд организм учраас хотын зүрх нь, уушги нь, эд эрхтэн нь яг хүний биетэй адилхан амьд организм учраас түүн дээр хэн хэрхэн хөдлөх вэ гэдгийг нь дагуулж хийж өгч байж энэ хотын бүтээн байгуулалт, хөгжил бодит утгаараа дэмжигдэнэ гэдэг утгаар нь бид зохицуулахыг хичээсэн.

Тийм учраас хөгжил бол зөвхөн бүтээн байгуулалтаар хэмжигдэхгүй. Хүний хөгжил ч гэсэн энэ дотор яригдана. Хүн амьдарч байгаа учраас.

Тийм учраас бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжихдээ хэн ямар үүрэг оролцоотой байх вэ гэдгийг нь хамтад нь шийдье гэдэг утгаар нь бид үүнийг хийж өгсөн. Тэр ч утгаараа энэ нэршлийн хувьд, энэ хуулийн концепцын хувьд бас их зөв болсон байх гэж бодож байгаа.

Эхлээд энэ өөрөө Хархорум хотын эрх зүйн байдлын хууль гээд л бичигдэж байсан. Тэгээд сүүлд бид хот амьд организм учраас үүнд хот нь өөрөө хэрхэн оролцох вэ гэдэг үүрэг оролцоог нь хүртэл хамтад нь шийдье гэдэг утгаар нь цогцоор нь шийдсэн.

Тийм учраас Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль ч бай, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуультай ч бай энэ нийцэж байгаа.

Тийм учраас цаашдаа энэ хууль батлагдсанаараа статус ч ойлгомжтой болно, төр хувийн хэвшлийн оролцоо ч ойлгомжтой болно, хотын тэргүүлэх чиглэл.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Тодруулъя. П.Ганзориг гишүүн тодруулъя.

П.Ганзориг: 4 асуулт асуусан. Эхнийхэд нь л хариулж байх шиг байна.

Тэгээд хоёр, гурав дахь нь гол нь ингээд байгаа юм. Дэмжиж байгаа. Зарчмын хувьд хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлээд явах ёстой.

Тэгэхдээ хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын асуудал нь тусдаа, эрх зүйн байдал нь тусдаа явахгүй нэг хууль руу бүх зохицуулалтаа багтаагаад шилжилтийн үеийн зохицуулалт болон цаашдаа зайлшгүй байж байх ёстой зүйлүүд орчихоор хуулийн зорилго жоохон саармагжих маягтай харагдаад байна.

Тэгэхээр үүнийг хоёр салгаад тусад нь явах бололцоо байгаа юу, үгүй юу гэдгийг тодруулж байгаа юм.

Тэгээд энэ захиргаанаас нь би хоёр, гурван асуулт асуусан. Улаанбаатар хот дээр бас давтагдсан алдаануудыг хууль эрх зүйн орчинг яаж хамгаалж байгаа юм. Энэ хотын эдийн засгийн бүтэц, тэрийг бүрдүүлэх гол эх үүсвэрүүд нь юу байх юм, иргэд нь яг ямар ажил төрөл хийж, ямар салбарт ажиллаж, ямар амьдралын хэв маягтай орлогын эх үүсвэртэй байх юм бэ гээд. Эд нарыгаа энэ хуульдаа бас яаж уялдуулж байгаа вэ?

Б.Пүрэвдорж: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Бид 7 дугаар бүлэг дээр тэр Хархорум хотын бүтээн байгуулалтад үзүүлэх дэмжлэг, хөрөнгө оруулалтыг бүхлээр нь зохицуулсан.

Улсын төсөв, хотын төсөв, дотоод гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж, сангийн хөрөнгө, ямар ямар эх үүсвэрүүд байх вэ. Татварын болон татварын бус дэмжлэгүүдийг зохицуулсан. Дагуулаад Гаалийн тарифын хуулиуд дээр өөрчлөлт оруулсан.

Ямар ямар татварыг хойшлуулж болох вэ гэдгийг хувийн хэвшлээ хэрхэн дэмжих вэ, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих вэ гэдгийг оруулсан.

8 дугаар бүлэг дээр бусад этгээдтэй харилцах буюу аймаг, орон нутагтай харилцах зохицуулалт, 5 дугаар бүлэг дээр нь төр, хувийн хэвшлийн түншлэл, 4 дүгээр бүлэг дээр нь нөгөө хотын зохион байгуулалт, удирдлага, зөвлөлүүдийг нь тодорхой болгож өгсөн.

Дээрээс нь бид тэр газрын асуудлыг өмнөх алдааг давтахгүйн тулд газрын асуудлыг нэлээд тодорхой зохицуулж өгье гэдэг утгаараа газар ашиглах буюу шууд эзэмшүүлж ашиглуулахгүй заавал сонгон шалгаруулалт зохицуулалтыг тусгаж өгсөн учраас.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 19 дүгээр микрофон. Ажлын хэсэг нэмж хариулъя.

Н.Нацагдорж: Улаанбаатар хотын алдааг давтахгүй байх тал дээр хууль эрх зүйн орчинд яаж бүрдэж байна вэ гэдэг энэ асуултад хариулъя. Товчхон хариулъя.

Ер нь Улаанбаатар хотын энэ бүтээн байгуулалт маань өөрөө маш олон салбарууд нэг доор бий болчихсон. Дээрээс нь төлөвлөлтийн хувьд хоёр нийгмийн байгууллын үр дүн байгаа юм. Социализмын үеийн төлөвлөлт. Дараа нь, чөлөөт зах зээлийн үеийн бүтээн байгуулалт хоёр холилдсон байдаг.

Дээрээс нь, Улаанбаатар хотын яг өөрийн захиалга гэж бол байхгүй. Энэ хот ямар байх юм бэ, ямар хүрээнд байх юм, хэчнээн хүнтэй байх юм, ямар салбарууд тэргүүлэх чиглэлтэй байх юм, экологийн хувьд ямар байх юм гэдэг үндсэн захиалга нь байхгүй учраас төлөвлөхөд маш төвөгтэй.

Гарсан 20, 20 гэдэг төлөвлөлт бол иж бүрэн төлөвлөлт бол байж чадаагүй. Яг үүнийг хэрэгжүүлэх гэхээр зөвхөн бүсийн өнгөөр ангилсан байдаг болохоос биш тухайн газар дээрээ юу байхыг тодруулсан төлөвлөлт байж чадаагүй юм. Одоо ч 20, 40-ийг хийхэд энэ асуудал маш хүнд тавигдаж байгаа. Иж бүрэн төлөвлөх бололцоо байхгүй.

Энэ юунаас болоод.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууна.

Д.Жаргалсайхан: Манай хангайн бүсэд хот байгуулах гээд Та бүхэн маань бас ажил хийгээд явж байгаад бас баяртай байна.

Гэхдээ хэд хэдэн зүйлийг бид ярихгүй бол бас болохгүй байна гэж үзэж байгаа. Ер нь ямар ч ажил хийхэд ТЭЗҮ хийгддэг. Техник, эдийн засгийн үндэслэл дээр энд хот байгуулснаараа ямар үр дүн гарах вэ, ямар ашиг гарах вэ, ямар судалгаа гарсан юм бэ гэдгийг нэгд асууя.

Мөн Хархорум гэдэг газар маш том түүхийн газар. Тэгээд энэ нийслэл болох юм уу? Ер нь ойлгомжтой. Томоохон дэд бүтцүүд хийгдэнэ. Хийгдсэнээрээ нэлээн л хөрөнгө оруулалтууд орно л гэсэн үг. Энэ ажлууд хийгдсэнээрээ бас үр ашигтай байх ёстой. Тэгээд тэр үр ашигтай байхын тулд хүн ам төвлөрөх ёстой. Эдийн засгийн нэг хөшүүрэг байх ёстой.

Тэгэхээр энэ хот маань яг цаашдаа яг ямар хөшүүргээр ажиллаж, тэр хүн амаа бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжтэй байдаг хот байх юм бэ гэдэг ийм асуулт байна. Одоо жишээ нь манай Дархан, Эрдэнэт гээд хотууд байгаа. Бүгд дэд бүтэц сайтай. Төмөр замтай, аж үйлдвэрүүдтэй, хүн амын төвлөрлөө, асуудлаа шийдээд явах бүрэн бололцоотой хотууд байгаа.

Хархорумын тухайд яг Улаанбаатар хот шиг ийм байдлаар яг яаж хөгжих юм бэ гэсэн ийм нэг асуудал байна.

Сая дэд бүтэц гээд ярилаа. Төмөр зам ийшээ баригдах уу? Хархорум руу төмөр зам тавигдах ТЭЗҮ зураг төсөв нь тусгагдсан уу? Мөн Лүн, мөн цаашлаад Эрдэнэсант, Хархорум чиглэлийн хатуу хучилттай замыг өргөтгөх үү? Манай ажлын хэсэг анхаарч байгаа байх. С.Эрдэнэболд оо. Тийм ээ. Ийм асуултууд асууж байна. Энэ дээрээ Та бүхэн анхааралтай хэлээд өгөөч ээ.

Мөн бидний хувьд Хархорум хотод. Одоо яг сая манай Г.Хосбаяр гишүүн ярьж байна. Тэндхийн бас Хархорин сум гээд байж байгаа. Энэ сумын иргэд дагуул баг шиг болчих вий дээ. Энэ дээр яг яаж уялдаж байгаа юм бэ? Үүнийгээ нэг тодорхойлж өгөөч ээ.

Дараагийн асуудал. Сая манай гишүүд ярьж байна. Баяр наадам ч тэнд хийж магадгүй бололтой юм ярьж байна шүү дээ.

Тэгэхээр ер нь төр захиргааны байгууллагууд тийшээ шилжих үү? Төр захиргааны байгууллагууд. Энэ тал дээр ямар төлөвлөлт байгаа вэ? Ийм асуулт асууя.

Минут дуусаагүй байх шиг байна. Дахиад нэг асуулт асуучихъя.

Ер нь манайхан энд маш томоохон дэд бүтцийн буюу жишээ нь төрийн ордон барина гээд л баахан юмнууд явж байна л даа. Ер нь энэ төрийн

бодлоготой уялдаж төрийн үйл ажиллагаануудыг хуваах зарчим дээр ямар төлөвлөлт хийгдсэн бэ? Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөтэй яаж уялдаж байгаа юм бэ? Ийм асуулт асууя.

Б.Пүрэвдорж: 19 номер. Ажлын хэсэг.

Н.Нацагдорж: Д.Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя.

Энэ хотыг барихад ТЭЗҮ буюу урьдчилсан төлөвлөлт, үзэл баримтлал, концепцын төсөл хийгдсэн. 37 янзын төсөл хийгдсэн.

Энэ 37 янзын төсөл бол дэлхийн архитектурын багууд Монгол Улсаас нэг ч төгрөгийн санхүүжилт аваагүйгээр өөрсдөө хийгээд Монгол Улсад 7 сарын 28-нд үзэсгэлэн гаргасан байгаа. Энэ олон улсын үзэсгэлэн гаргасан байгаа. Одоо 37 янзын төсөлтэй гэсэн үг.

Тэгэхээр энэ төслийг цааш нь үргэлжлүүлээд хууль батлагдах юм бол хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд сайн шинжүүдийг нь тусгаад ингээд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдана.

Тэгэхээр ТЭЗҮ-ийн хувьд маш хангалттай олон хувилбараар хийгдсэн.

Эдийн засгийн өгөөж гэж байгаа. Ерөнхийдөө Орхоны хөндий Улаанбаатар хотын дараа орох хүн амын өндөр нягтралтай газар. Монгол Улсын мал аж ахуйн 30 хувь байдаг ийм газар.

Тэгэхээр энэ бол эдийн засгийн өгөөж маш өндөр. Хотоо байгуулахад тэнд 213 мянган ажлын байр шууд бий болгохоор урьдчилсан тооцоонууд гарсан байгаа. Олон улсын жишгүүд дээр гарсан байгаа.

Энэ нь цаашаа аялал жуулчлал. Тэргүүлэх чиглэлүүд нь аялал жуулчлалын салбар, өндөр технологи, үйлдвэрлэлийн салбар, эрүүл мэнд, боловсролын салбар, мөн гадаад харилцааны салбар гэсэн ийм салбаруудаас бүрдэхээр төлөвлөж байгаа.

Тэгээд энэ дотроо дандаа технологид түшиглэсэн үйлдвэрлэлүүд явагдана гэсэн байгаа.

Улаанбаатарын хооронд төмөр зам тавих, хурдны галт тэрэгний зам тавих, хурдны зам тавих урьдчилсан судалгаанууд, байршлын судалгаануудаа хийгдсэн байгаа. Зарим төмөр замын ажил дээр Солонгосын талаас оролцохоор ийм хүсэлтээ илэрхийлсэн байгаа.

Мөн онгоцны буудлын ТЭЗҮ боловсруулах ажил Зам, тээврийн яаман дээр тодорхой төсөв суугдаад ТЭЗҮ-ийн ажил хийгдээд явж байгаа.

Хархориноос гадна энд олон улсын онгоцны боодлыг дагасан хот, Өгий нуурыг дагасан аялал жуулчлалын хот. Мөн тээвэр, ложистикийн төв хот. Мөн Хархорум гэсэн 4 төлөвлөлт энэ бүс дотор хийгдэж явж байгаа.

Б.Пүрэвдорж: Нэмэлт хариултыг Н.Учрал сайд хариулна.

Н.Учрал: Хархорум хот бол. Түрүүн гишүүд асуугаад байна. Нийслэл болно энэ тэр гээд. Энэ бол Үндсэн хуулийн зөрчил л дөө.

Тэгэхээр бид Хархорум хотыг шинэ нийслэл болгоно гэхээсээ илүү энэ чинь Хархорум хотоо сэргээн байгуулах, шинээр бүтээн байгуулах, түүхэн аялал жуулчлалын хотыг шинээр бүтээх ийм л зорилгоор Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих хуулийг хийж байна. Боловсруулсан.

Тэр улсын баяр наадмын хувьд бас боломжтой. Ер нь улсын баяр наадмыг нийслэл хотод, эсвэл Засгийн газраас тогтоосон газарт зохион байгуулж болно оо л гэж байгаа юм. Бид ийм санаачилга хэрэгтэй.

Тэгэхээр би Д.Жаргалсайхан гишүүний санаачилгыг бас дэмжээд байгаа юм. Ер нь Улсын баяр наадмыг зохион байгуулах комиссын даргад, Шадар сайдад, Ерөнхий сайдад ч гэсэн бид энэ асуудлыг уламжлаад, хэрвээ Засгийн газар шийдэх юм бол бид бас улсын баяр наадмыг Хархорум хотынхоо энэ Орхоны хөндийд зохион байгуулах бүрэн бололцоотой.

Б.Пүрэвдорж: Одоо Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе.

Ер нь ингээд юу ч байхгүй хоосон тал газар очоод хот бариад байдаг явдал бол дэлхийн жишгээр цөөхөн л дөө. Амжилттай хэрэгжсэн төслүүд ч гэсэн маш цөөхөн.

50 гаруй улс нийслэлээ нүүлгэнэ гээд хийсэн. Амжилттай хэрэгжсэн нь хоёр, гуравхан байдаг. Солонгосын Сажун хүртэл эдийн засгийн хувьд үр ашиггүй байна гэсэн мэргэжлийн байгууллага, дэлхийн олон улсын байгууллагуудын дүгнэлт нь гарчихсан.

Тэгэхээр яаж хэрэгжүүлэх вэ, яаж төлөвлөх вэ гэдэг дээрээ маш сайн анхаарах ёстой.

Хоёр, гурван асуулт байна.

Эхнийх нь, бүсчилсэн хөгжил дээрээ үүнийгээ бүсийн төв болгож өгөхгүй бол эдийн засаг тэнд төвлөрөхгүй, аж ахуйн нэг ч очихгүй, хот үүсгэх боломжгүй болно: Шууд энэ зорилго дээрээ бүсийн төв болно гээд зааж өгч болоогүй юм уу?

Хоёр дахь асуулт нь. Манайх 10 гаруй жилийн өмнөөс хойш баахан хот цаасан дээр барьсан. Их сургуулиудын хотхоныг Налайхад нэг төлөвлөж үзлээ. Багануурт төлөвлөж үзлээ. Майдар сити гэж бас нэг Богд уулын урд талд нэг төлөвлөж үзлээ. Өчнөөн тэрбум төгрөг зарсан. Тэндээс юу үлдсэн юм. Цаас л үлдсэн. Энэ алдааг яаж харж байгаа юм. Энэ алдаагаа давтахгүй гэдгийг яаж хэрэгжүүлэх вэ гэдэг хоёр дахь асуулт.

Гурав дахь асуулт. Н.Учрал сайд сая хэлж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хот байгуулна гээд. Энэ маш зөв л дөө. Төр бол хот барина гэж байдаггүй. Хувийн хэвшил л хотыг барьдаг, бий болгодог. Улаанбаатар хотыг өнөөдөр өдий зэрэгтэй авч явж байгаа нь энэ томоохон компаниуд, үйлдвэрүүд, хөдөлмөрчид, ажилчид бүгд оршин суугч нар өөрсдөө байгуулсан. Төр энэ дээр нэг их оролцоод байсан юм байхгүй. Тэр нь ч бас эсрэгээрээ алдаатай зүйлүүд бас байсан.

Яах вэ, хэлэлцэх эсэх дээр ийм нарийн зүйлүүд яримааргүй байгаа ч гэсэн энэ бүр ярихгүй бол болохгүй байгаад байгаа заалтууд байна.

Хувийн хэвшлийгээ дэмжинэ гэж орж ирж байгаа юм бол ямар их заалтыг хотын захирагч нь эрх мэдэл эдлээд тэнд одоо бараг хаан суух гэж байгаа юм шиг заалтууд байна шүү дээ. Газар эзэмших, ашиглахыг нь хотын захирагч олгоно. Барилга, байгууламжийн загвар зургийг захирагч батална. Архитектур төлөвлөгөөний даалгаврыг бас захирагч батална. Чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн аж ахуйн үйл ажиллагааны орлогынх нь 5 хувийг нь хот нь өөрөө аваад явчихна гэж байна шүү дээ. Үүнийг хувийн хэвшил зөвшөөрөх юм уу? Гадаад байтугай дотоодууд үүнийг зөвшөөрөх юм уу?

Хөрөнгө оруулалтын тогтворжилтын гэрчилгээ олгоно гэж байна. Энэ бас захирагч нь. Тэнд үйл ажиллагаа эрхлэх хувийн хэвшлийн оюуны өмчийн өмчлөх эрхийг нь хүртэл хотын захирагч нь олгоно гээд ороод ирж байна шүү дээ.

Ийм олон эрх мэдлийг төвлөрүүлэх хэрэг байна уу?

Б.Пүрэвдорж: Асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал сайд хариулна.

Н.Учрал: Ер нь Г.Лувсанжамц гишүүн мэргэжлийн хүний хувьд зөв зүйл хэлж байна.

Тэгээд олон цаастай болсон нь үнэн. Гэхдээ ер нь хотыг инженерүүд өөрсдөө л төлөвлөж, байгуулж, хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр л босгодог.

Улаанбаатар хотыг хувийн хэвшил л босгосон. Гэхдээ төрд байсан ганцхан үүрэг нь юу байсан юм бэ гэхээр зохицуулж өгөх ёстой байсан. Тэгээд

зохицуулж өгөөгүй. Ерөнхий төлөвлөлтөө бариагүй. Ерөнхий төлөвлөлт нь байсан хэдий ч түүнийгээ зөрчөөд анхан шатны тэр даамлууд, нөхдүүд ер нь бол тэгээд найран дундаа орсон. Тэгээд найран дундаа орсон учраас Монголд онигоо гарсан. Тэр нь юу вэ гэхээр ерөөсөө Монголд бүтээе гэвэл юу ч бүтнэ, бүтэхгүй бол юу ч бүтэхгүй ийм л болсон.

Тийм учраас өнөөдөр ийм зах замбараагүй төлөвлөлт, битүү ширэнгэн л боллоо шүү дээ. Цементийн ширэнгэн л боллоо шүү дээ.

Тэгэхээр Хархорин хот дээр энэ алдааг давтахгүйн тулд төр бас оролцох зүйлдээ оролцоно. Ялангуяа газар олголт дээр оролцох ёстой учраас газрыг шууд эзэмшүүлж ашиглуулахгүй байх ёстой. Аргаа бараад Засгийн газар дээр нэгдээд энэ газар олголтыг шийддэг болгож байна шүү дээ. Тэгэхгүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага нь шийдье гэхээр бас замбарааг нь алдуулчихдаг.

Тэр Хөшигийн хөндийг хар л даа. Хэдэн 100 га-гаар нь нэг гэр бүл бүгдээрээ эзэмшээд л сууж байгаа шүү дээ. Одоо тэгээд хувьд хэн нэгэн даамлын өгчихсөн газрыг одоо тэнд Шинэ Зуунмод хот байгуулах гэж гуйж гувшаад сууж байгаа шүү дээ. Одоо буцаагаад газраа.

Одоо энэ Хархорум хотын сургаар тэнд газар олголт бужигнаж эхэлж байна. Одоо хурдан хуулиа гаргаад тэр 130 хэдэн мянган га-г улсын тусгай хамгаалалтад авахгүй бол нөгөө сумын Засаг дарга нар чинь бүгдийг нь газрыг нь олгоод пижигнүүлээд эхэлнэ. Яг нөгөө Хөшигийн хөндий дээр нисэх буудал баригдахад сумын Засаг дарга газруудыг олгоод пижигнүүлдэг шиг одоо тэнд бас нэг тийм бужигнаан болно.

Тийм учраас хурдан хуулийг нь гаргаад цэгцтэй явуулахгүй бол болохгүй.

Хархорум хотын хувьд тэр бусад нэг тийм шинээр байгуулах гээд байгаа хотуудаас том ялгаа байгаа. Энэ бол дэлхийн брэнд. Энэ их эзэн Чингис хаан бид нарт насаараа хэрэглэх, ашиглах, хоолоо олж идэх ийм хэдэн нэр, брэндийг үлдээсэн байхгүй юу.

Хархорум гэдэг бол дэлхийн брэнд. Энэ бусадтай харьцуулшгүй юм билээ.

Дээрээс нь Хархорум хотын энэ Орхоны хөндий бол 4 зүг, 8 зовхист төлөвлөгдөж болох орц, гарцтай ийм бүс нутаг. Улаанбаатар шиг ийм хоёрхон орцтой, гарцтай биш юм билээ.

Тийм учраас Г.Лувсанжамц гишүүнийг энэ ажлын хэсэгт ороод хамт ажиллахыг урьж байна.

Б.Пүрэвдорж: Ганзоригийн Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Ажлын хэсэгт урьж байгаад баярлалаа. Ороод ажиллая гэсэн. Ажлын албатай хоёр, гурван удаа уулзсан. Саналуудаа хэлсэн.

Энэ хуулийг өргөн барихаас өмнө би хэлсэн. Саяын саналуудыг. Хоёр, гуравхан зүйл засагдсан байсан. Бусад нь засагдаагүй.

Яагаад төр нь ийм их эрх мэдэл авах гээд. Ер нь төр яагаад зөвшөөрөх гээд байгаа юм. Энэ социалист тогтолцооноосоо салах ёстой. Яагаад хотын дарга хүмүүсийг байшин барихыг нь зөвшөөрнө. Зураад ирсэн зургийнх нь өнгийг нь хүртэл зөвшөөрнө. Төсөл бариад ирэхээр төслийг нь зөв бурууг нь хотын дарга нь шийднэ. Энэ бүх зүйлээсээ салахгүй бол хотыг барих боломжгүй гэж хэлсэн.

Сая би тэгээд маш тодорхой гурван асуулт асуусан. Бүсийн төв болж болоогүй юм уу? Өмнөх алдаанаасаа юу сурчхаад тэрийгээ дахиж давтахгүй гэж байгаа юм.

Гурав дахь нь яагаад энэ хотын захирагч ийм олон эрх мэдэлтэй байгаа юм? Энэ гурван.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмэлтээр Н.Учрал сайд хариулна.

Н.Учрал: Бүсийн төв болгож болно. Үүнийг бүсээс сонгогдсон Их Хурлын гишүүд байр сууриа илэрхийлээд явбал бид ажлын хэсгийнхээ хэлэлцүүлгийн явцад Хархорум хотыг Архангайн бүсийн төв болгож болно.

Ингээд сая тэр татварын болон бусад дэмжлэгүүдээр дэмжээд явахад нэлээн чөлөөтэй. Ямар ч байсан эхлэлийг тавьсан.

Эрх мэдлийн хувьд энэ Хархорин хотын бүтээн байгуулалтын хөгжлийг дэмжих хуулиар ер нь Улаанбаатарт ч бай тэр Хот, тосгоны хуулиар ч бай, тэр Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хуулиар ч бай ер нь төр болон Хархорум хотын захирагч эрх мэдэл бараг огт аваагүй хууль шүү дээ. Бусад хуультай харьцуулбал.

Түүнээс биш бас нэг төлөвлөлт дээрээ оролцох, тэгээд тэр гол гол зөвшөөрлүүдийг өгөхөд нь бас оролцолгүй л яах вэ дээ. Тэгээд тэнд чинь замбараагүй байдал үүснэ шүү дээ.

Б.Пүрэвдорж: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Би энэ Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаас, Г.Занданшатар даргаас асуулт асууя.

Уг нь би энэ хуулийг Ерөнхийлөгчийн зүгээс санаачилж оруулж ирэх юм болов уу гэж бодож байсан. Яагаад энэ Засгийн газар оруулаад ирчихсэн юм бэ?

Уг нь 2 жилийн өмнө Ерөнхийлөгч анх энэ хот байгуулах санаачилгыг гаргаж, тэгээд холбогдох шийдвэрийг гаргуулж, мөн ашиглалтын өмнөх захиргаа юм байгуулж, ТЭЗҮ юм боловсруулах төсөв юм батлуулж, мэргэжлийн баг бүрдүүлж өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа байх.

Тэгээд яагаад Засгийн газар оруулж ирсэн юм болоо гээд би гайхаад байна. Ерөнхийлөгчөөс яагаад энэ хуулийн төслийг оруулж ирж болоогүй юм бол оо гэж. Энэ дээр Г.Занданшатар дарга хариулж өгөөч ээ.

Хоёрт, энэ хуулийн нэрнээсээ авхуулаад хууль маань Хархорум хотын шинэ бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль гэж орж ирж байна. Гэтэл хуулиа харахаар хотын эрх зүйн асуудлуудыг хүртэл дотор нь байгаа байхгүй юу.

Тэгээд энэ хотын маань Үндсэн хуулийн тэр 57 дугаар зүйлд зааснаар засаг захиргааны нэгж дэх хот гэж байх ёстой. Гэтэл энэ хот маань яг аль нэгжид хамаарч байгаа хот юм бэ? Архангай аймагтай юм уу, Өвөрхангай аймагтай юм уу? Уг нь ноднин бид тэр Шинэ Зуунмод хотыг бол Улаанбаатар хотын нэгж дэх Шинэ Зуунмод хот гээд хуульчилсан шүү дээ.

Нөгөө талаар бас Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиар бид энэ шинэ анхдагч хууль болоод хуулийн шинэчилсэн найруулга дээр хууль зүйн үндэслэл, дүгнэлт гаргана гээд тусгачихсан. Ингээд Их Хурлын Тамгын газраас хууль зүйн дүгнэлт гаргасан байна лээ. Энэ 10 орчим хуудас.

Өчигдөр Байнгын хорооны хурал дээр танилцуулагдсан. Уржигдар. Үүнийг энэ ажлын хэсэг яг юу гэж үзэж байгаа вэ? Нэлээн олон хууль хоорондын хийдэл гэдэг юм уу, асуудлууд байхаар ингэж хууль зүйн дүгнэлт гарсан байна. Гэтэл суурь хуулиуд, нэгжийн хууль, Татварын хууль, Хот байгуулалтын хууль, Газрын хууль гээд суурь тусдаа хуулиуд чинь бүгд байгаа шүү дээ.

Гэтэл энэ хуулиудыг бүгдийг нь энэ хуульдаа нэгтгээд оруулчихсан байгаа нь эрх зүйн хувьд Үндсэн хуультай болоод бусад хуулиудтай зөрчилдөх асуудал үүсэх юм биш үү. Үүний хууль зүйн дүгнэлтийг хууль санаачлагч болоод ажлын хэсгийнхэн юу гэж үзэж байгаа вэ гэдэг ийм хоёр, гурван асуултад хариулт өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулт өгье. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр 430 тоот тогтоол баталж, энэ тогтоолоор Хархорум хотыг сэргээн байгуулах тухай ийм чиглэл шийдвэрийг гаргаж Засгийн газарт чиглэл өгсөн.

Энэ тогтоолд Хархорум хот байгуулах болон Хархорум хотын эрх зүйн үндсийг тусгай хуулиар тогтоохоор ийм чиглэл өгсөн. Энэ зарлиг чиглэлийн дагуу Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр 07 тоот тогтоолыг Улсын Их Хурал баталсан. Энэ Улсын Их Хурлын тогтоол бол Хархорум хотыг сэргээн байгуулах тухай тогтоол.

Энэ тогтоолоор газрыг тусгай хэрэгцээнд авах, энэ эрх зүйн үндсийг тогтоох энэ чиглэлүүдийг баталсан.

Ерөнхийлөгч бол энэ дээр ажлын хэсэг байгуулж, газар дээр нь Улсын Их Хурлын даргаар ажиллуулсан ажлын хэсэг 2022 онд ажиллаж газар орон нутагтай танилцаж, ер нь энэ бол түүх дурсгалын өлгий нутаг, аялал жуулчлалын өлгий нутаг, соёл боловсролын өлгий нутаг, шинэ нийслэл болох ийм бололцоотой газар гэж үзсэн. Зарим улсуудад хоёр, гурван нийслэл, соёлын нийслэл, аялал жуулчлал, эдийн засгийн зориулалттай нийслэл гэх мэт хоёр, гурван нийслэлтэй ийм Үндсэн хуультай улсууд ч бий.

Тэгэхдээ энэ Үндсэн хуулийн асуудал. Зарчмын дагуу Шинэ хотыг байгуулах асуудал өөрөө шинэ эрх зүйн орчныг шаардаж байгаа юм. Нэгдүгээрт Улаанбаатар хотын өнөөгийн нөхцөл байдал 500 мянган хүн хүнээр төлөвлөгдсөн гэж ярьдаг энэ хот сая гаруй хүн сүүлийн 30 гаруй жилд нүүж ирж Улаанбаатар хот ачааллаа дийлэхээ больсон. Агаар орчны бохирдол, хөрсний бохирдол, түгжрэл ямар байгааг бид мэдэж байгаа.

Энэ стратегийн шийдэл бол шинэ хот байгуулахаас өөр замгүй юм гэж Улсын Их Хурал, Засгийн газраас үзсэн.

Хоёрдугаарт нь, сүүлийн 20 жилд гэхэд 594 мянган хүн албан ёсоор нүүж ирсэн. Албан бус статистикаар Улаанбаатар хотын хүн амын суурьшил бол улам л нэмэгдээд байх нь.

Тэгэхээр үндэсний аюулгүй байдлын хувьд ч гэсэн улс маань Улаанбаатар улс болох юм уу, хөдөө орон нутаг эзгүйрээд хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөн улам нэмэгдсээр байгаад хөдөө орон нутагт шинэ төвлөрөл бий болох зайлшгүй шаардлага төвийн бүсэд бий болох шаардлагатай байна гэж үзэж үе үеийн Улсын Их Хурал 2002 оноос хойш бүсчилсэн хөгжлийн үзэл

баримтлал баталснаас хойш Хархорум хотыг шинээр байгуулах тийм шийдлийг гаргаж ирсэн юм билээ.

Энэ яагаад хэрэгжихгүй байсан бэ гэхээр энэ бид хот байгуулах туршлага байхгүй, эрх зүйн орчин байхгүй. Зарим гишүүдийн асуугаад байгаа шиг эзгүй хоосон газар биш ээ. Энд эртний Хүннүгийн нийслэл Луут хотоосоос авхуулаад Жужаны Мумо нийслэл, Уйгарын Хар балгас гэх мэтчилэн. Сүүлд нь Хархорум, эртний Түрэгийн нийслэл хотын тууриуд гээд маш олон нийслэлүүд энд байгуулагдаж байсан нь бас санамсаргүй хэргүүд биш бөгөөд энэ бол Монгол Улсын шинэ суурьшлын төв бий болгож төвлөрлийг сааруулах ийм түүхэн шийдэл гэж үзсэн.

Ийм ч учраас Улсын Их Хурал дээр, Улсын Их Хурлын даргын захирамжаар Г.Тэмүүлэн гишүүнээр ахалсан ажлын хэсэг ахалсан. Энэ хуулийн төсөл дээр бас хуралдаж ажилласан, хамтран боловсруулсан байгаа юм.

Ингээд энэ утаа, түгжрэлдээ дийлдэхээ больчихсон Улаанбаатар хотыг шинэ суурьшлын бүс байгуулах юм бол 168 мянган хүн эхний ээлжид шилжиж болно. Цаашдаа 500 мянган хүнтэй шинэ суурьшлын бүс бий болгож болно гэсэн ийм тооцоог Статистикийн газраас гаргасан байна.

Ц.Сандаг-Очир гишүүний асуусан хоёр дахь асуулт бол энэ бол бүсийн түүхээсээ илүү улсын зэрэглэлтэй хот гээд Улсын Их Хурлын шийдвэр гарчихсан.

Үндсэн хуулийн 58.2-т заасны дагуу Засгийн газар өргөн мэдүүлж байгаа. 57.2-т заасны дагуу. Үндсэн хуулийн 57.2-т засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үндсийг хуулиар тогтооно. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх буюу аймаг доторх хотуудын статусыг зохион байгуулж байгаа бөгөөд энэ зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ, хилийн цэсийг Улсын Их Хурал тогтооно гэсэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэж заасан учраас Засгийн газраас хэлэлцэн шийдвэрлэж байгаа.

Энэ шинэ хот байгуулахад бусад хуультай зөрчилдөнө. Тусгай эрх зүйн орчин бүрдүүлж байж л энэ стандарт бус болчихсон энэ хотын төвлөрлийг сааруулахаас өөр аргагүй байдалд очиж байна. Яагаад гэхээр жишээлбэл тусгай эрх зүйн орчин гэдэг маань чөлөөт бүсийн тухай хууль батлагдахад тухайн эдэлбэр газар дээр бусад хууль бүр үйлчлэхгүй. Далайн орны эрх зүй ч юм уу, өөр эрх зүйн систем үйлчилдэг ч юм байна.

Тэгэхээр бусад хуультай зөрчилдөх асуудал бас байхгүй. Энэ эрх зүйн дүгнэлт дээр бас яаруу сандруу гарсан. Ойлгож байна. Хот тосгоны тухай хуулийн 4.1-д ингэж байгаа юм. Хот нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг бүхий удирдлага, зохион байгуулалт, дэд бүтэц бүхий нийтийн эрх зүйн этгээд мөн гээд.

Тэгэхээр хуулиар “хотод тусгай эрх өгч болно” гээд заачихсан байхгүй юу. Тэгэхээр Хархорум гэдэг энэ тусгай бүсэд эдэлбэр газар дээр нь ийм тусгай чиг үүрэг өгч байгаа юм.

Тэр зөвлөлийн гишүүд бол сонгогдох иргэд нь байхгүй байгаа учраас Хот, тосгоны тухай хууль бол үүнийг шинээр байгуулах нэг удаагийн хууль.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье. Г.Занданшатар даргын микрофон ассан байна. Гүйцээж хариулах уу?

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчихъя. Баярлалаа дарга аа.

Тэгэхээр энэ бол Монгол Улсын хувьд түүхэн үйл хэрэг мөн. Эртний нийслэлээ сэргээн босгож байна. 1220 оны луу жил зарлиг гарч тухайн үеийн Хархорум хотыг байгуулж байсан эртний нийслэлээ сэргээж байна.

Үндэсний аюулгүй байдлын хувьд ч тэр, эдийн засгийн өнөөдрийн шаардлагын хувьд ч гэсэн шинэ төвлөрөл бий болсноороо энэ амжилтад хүрнэ.

Зарим улсууд амжилтад хүрээгүй юм биш. Бидэнтэй адилхан гараанаас эхэлсэн Казахстан Улс Астана хотыг шинээр байгуулж шилжүүлээд эдийн засаг нь тэлж хурдацтай хөгжихөд ихээхэн хувь нэмэр оруулсан. Ингээд хөдөө аж ахуй, эдийн засаг, аялал жуулчлал, соёл, боловсролын томоохон төв болж хөгжихөд ийм бололцоотой шинэ хот учраас энэ түүхэн шийдвэр гаргаж, эдийн засгийн томоохон асуудлуудыг НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 3 улстай байгуулах гэрээгээ шийдлээ.

Өнөөдөр эртний нийслэл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Н.Учрал сайд нэмэлт хариулт өгье.

Н.Учрал: Улсын хил заагийг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж Хот, тосгоны хуулиар заасны дагуу 2022 оны Ерөнхийлөгчийн зарлиг гарсантай холбогдуулаад Ерөнхийлөгчийн институцээр боловсруулагдаж байсан хуулийг Засгийн газар бас дахиж хамтарч ажилласны үндсэн дээр Засгийн газрын зүгээс Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн.

Ингээд Их Хурлын Тамгын газраас гаргасан дүгнэлтийг бид зөрчил гэхээсээ илүүтэйгээр хуулийн төслөө сайжруулаарай гэсэн нөхөрсөг дүгнэлт байсан гэж ойлгож байгаа.

Тийм учраас Их Хурлын Тамгын газрын дүгнэлт дээр хэлэлцүүлгийн шатанд нэмэх боломжтой хэд хэдэн хуулиудыг нэмээрэй гэж нөхөрсгөөр зөвлөсөн байна. Үүнийг ажлын хэсэг дээр хүлээж авч байна.

Зөвхөн бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих асуудал зөвхөн нэг тийм бүтээн байгуулалт дээр хязгаарлагдах.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нөхөрсөг зөвлөгөө биш, мэргэжлийн зөвлөгөө гэдэг талаас нь Н.Учрал сайдад тайлбарлаж хэлье.

Улсын Их Хурал, Засгийн газар хоёрын ажил нөхөрсөг байдлаар биш мэргэжлийн байдлаар хамтарч ажиллаж явж байгаа.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хууль, тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ.

2 гишүүний нэр ирсэн байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэр.

А.Ундраа: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Хархорум хотыг бид мэдээж шинээр байгуулж байгаа биш. Энэ бол Монгол Улсын маань түүхэн дэх эртний нийслэл. Тэгээд Хархорум хотын Орхоны хөндий Их Монгол Улсын эртний нийслэл төдийгүй бас түүнээс өмнөх олон мянган жилийн туршид хэд хэдэн эзэнт гүрний нийслэл байж ирсэн ийм түүхтэй хөндий гэдэг утгаараа энд шинэ нийслэлээ нүүлгэн байгуулах нь бас Монголд стратегийн чухал ач холбогдолтой, улсын хөгжлийн бас нэгэн түлхүүр гэж үзэж байна.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал дээр удахгүй хэлэлцэгдэхээр Засгийн газраас өргөн барих гэж байгаа хэд хэдэн чухал хуулиуд байгаа. Түүний нэг нь Барилгын тухай хууль, мөн Хот байгуулалтын тухай хууль, Орон сууцжуулалтын хууль гээд эдгээр чухал хуулиуд өргөн баригдахаар бэлтгэл ажил хангагдаж байна гэж ойлгож байгаа.

Тэгэхээр өнөөдрийн хэлэлцэх асуудлын хүрээнд өмнө нь батлагдчихсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, ирээдүйд хэлэлцэгдэх хууль хоорондоо хэрхэн нийцэх вэ, энэ хуулийн зөрчил юм уу хийдэл, давхцал яаж гарах вэ гэдэг нь тодорхойгүй байгаа учраас бас энэ дээр эргэлзээтэй асуудлууд байна.

Тэгээд бид хэд өнөөдөр ярилцаж байгаа асуудлынхаа хүрээнд авч үзэхэд мэдээж ирээдүй цаг дээр юмыг ярих зохисгүй. Гэсэн хэдий боловч зарим

зарчмын асуудлуудыг өнөөдөр авч үзэж шийдвэрлэж өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчиндоо авч үзэх юм бол тухайн шинээр байгуулах хотын захирагчийн эрх мэдлийн цар хүрээ, хэм хэмжээ, тухайн хотын дүрэм, оршин суугчид болон тухайн хотод үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд, хувийн секторын дагаж мөрдөх дүрэм нь Улаанбаатар хотоос ялгаатай байх шаардлагатай гэдгийг өнөөдрийн Улаанбаатарт тулгамдчихсан байгаа олон асуудал бидэнд харуулж байна.

Тэгэхээр өнөөдрийн асуудлыг зарчмын хувьд дэмжиж байгаа боловч яг хэлэлцэх эсэх дэмжигдээд явах юм бол Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй олон санал гарах болов уу гэдэг байр суурьтай байна. Тэгээд дэмжиж байгаагаа илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн. 2 дугаар индрээс үг хэлье.

С.Эрдэнэболд: Олон мянган жилийн түүхийг өртөөлсөн нүүдэлчин Монголчуудын хувьд Монгол Улс бол тусгаар тогтносон цорын ганц улс нь.

Тэгэхээр дэлхий даяар 10 гаруй сая монгол туургатан байна. Хойно Тува, Буриад, урд Өвөр Монгол, Хөх нуурын монгол, Шинжааны монгол, Афганистанд монгол гээд олон газар монголчууд байгаа.

Тэгэхээр Монголчуудын үндэсний эв нэгдэл, оюун санааны дархлааг хатамжлан баталгаажуулах энэ үйл хэрэг бол энэ Хархорум төсөлтэй холбоотой юм.

Тийм учраас энэ бол зөвхөн хот балгад байгуулах тухай асуудал гэхээсээ илүүтэйгээр XXI зууны хоёр дахь хагас, XXII зуунд монголчууд хэр зэрэг дэлхийд өрсөлдөх чадвартай, оюун сэтгэлгээний цартай, дархлаатай ард түмэн байх вэ. Энэ шалгуурт энэ хотын үйл хэрэг зориулагдах ёстой гэж үзэж байгаа.

Хот гэдэг утгаараа мэдээж шинжлэх ухаан, суурь судалгаа, томоохон стратегийн зорилтууд, хүнийг татдаг, хөрөнгө оруулалтыг татдаг, хөгжлийг татдаг татах хүчний тэр соронзон орон байх утгыг техник, эдийн засгийн үндэслэл зүйл дээр гаргах байх гэж бодож байгаа.

3 санал байгаа. Нэгдүгээрт, яах арга байхгүй одоо мөрдөгдөж байгаа хуулийн хэмжээнд хязгаарлалтууд байгаа учраас энэ Хархорум гэдэг энэ үйл хэргийг босгохын тулд бие даасан зохицуулалт бүхий эрх зүйн гаргалгаатай хуулийг яаралтай санаачилж оруулах ёстой.

Хоёрдугаарт, түрүүн Н.Учрал сайдын хэлж байгаачлан референдум буюу ард түмний өргөн санал асуулгыг явуулж энд мэдлэгийн угсаатны зүй, гүн ухаан, монголчуудын өвөрмөц онцлог, түүх соёл, өнөө цагийн дэлхийн технологи гээд

олон талыг нэгэн зэрэг агуулсан тэр мэдлэгийн иж бүрэн зүйлээр энэ хотыг эхнээс нь үндсийг нь, шанг нь татах тэр стратегийг тодорхойлох ёстой гэж үзэж байгаа.

Гуравдугаарт нь, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилтууд. 17 зорилт. Энэ зорилт 2030 онд шинэчлэгдээд явна.

Үүний зүй тогтолыг ажиглаад 2030 оноос өмнөх болон 2030 оноос цааших хүн төрөлхтний өмнө тулгамдах асуудлууд дээр энэ хот маань бас бэлтгэлтэй байх ёстой.

Нэгдүгээрт, 2050 он гэхэд дэлхийн хүн ам 10 тэрбум 200 саяд хүрнэ гэсэн тооцоолол байгаа. Гурван том асуудал.

- ▶ Нэгдүгээрт, эрчим хүч;
- ▶ Хоёрдугаарт, ундны ус;
- ▶ Гуравдугаарт, хүнс тэжээлийн дутагдалд орно гэсэн ийм зүй тогтол байгаа.

Нөгөө талаасаа дэлхий нийтийн энэ ороо бусгаа байдал, цагийн нөхцөл байдалтай уялдаад энэ хот маань өөрөө энэ бүх зүйлд үндэстний сөрөн тэсвэрлэх чадварыг шингээсэн, дасан зохицох чадвартай ийм ногоон эко сэргээгдэх эрчим хүчинд суурилсан хот байх ёстой гэж үзэж байгаа юм.

Тийм учраас Монголчуудын хувьд XXI зууны хоёр дахь хагастын хагасын оюун санааны сэргэн мандалтын гол цохилох зүрх нь энэ төсөл рүү бас яваасай гэж бодож байгаа юм.

Тийм учраас бид энэ дээр улс төрийн нам, ямар нэгэн байдлаар хувь хүний итгэл үнэмшил гэхээсээ илүүтэйгээр үндэстний эрмэлзлэл, үндэстний тэр гэгээн тэмүүллийг шингээсэн төсөл байгаасай гэж үзэж дэмжиж байгаа.

Ингээд энэ төслийг хэрэгжүүлэх санаачилж байгаа хүмүүст амжилт хүсье. Олны хүчийг оролцуулж, хүмүүсийн оюун бодлыг олон талаар тусгаж энэ төслийг чамбай, хийгүй долоо хэмжиж нэг огтолж яваасай гэж хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ 126 гишүүнтэй парламентад 5 нам, эвсэл байгаагийн 4 нь Улсын Их Хурлын сонгуулийнхаа мөрийн хөтөлбөрт тусгасан, ХҮН нам, Монгол Ардын нам, Ардчилсан нам, Үндэстний эвсэл гэж 3 нам, 1 эвсэл мөрийнхөө хөтөлбөрт тусгасан Шинэ Хархорум хотыг байгуулах энэ ажил ингээд хууль нь өргөн баригдаж хэлэлцэх эсэх асуудал өнөөдөр шийдэгдсэнээр гараандаа гарч байна.

Мэдээж Улсын Их Хурлын түвшинд сая Г.Занданшатар даргын хэлсэнчлэн анхдагч хууль болгож орчин цагийн нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн гадаад, дотоод орчинтой бүрэн ажиллах боломж нөхцөлийг нээж өгч чадсан хууль батлах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэр утгаараа Улсын Их Хурал дээр энэ хуулийн төсөл дээр томоохон бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж өгч эрчимтэй ажиллах нөхцөлөөр хангаж өгнө. Ингээд бид амжвал намрын чуулганаар батална. Хэрвээ ажлын хэсэг ажиллах зайлшгүй шаардлагууд гарсан тохиолдолд магадгүй хаврын чуулган руу шилжих нөхцөлтэй.

Гэхдээ энэ өргөн барьсан төсөл дээр богино хугацаанд ажиллаж амжуулж чадвал намрын чуулган цаг хугацааны хувьд илүү хэмнэлттэй юм гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгийг хэлье.

Ингээд санал хураалтыг өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудлуудын төгсгөлд нэгтгэж явуулна.

Тийм учраас дараагийн асуудал руу оръё. Дараагийн асуудалд оръё.

**Дөрөв. “Монгол Улсын Засгийн газар,
Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд
Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнанасан төмөр замын бүтээн
байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах
үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/**

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнанасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ринчиндоржийн Батболд танилцуулна.

Индэрт урьж байна.

Р.Батболд: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын

Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж, чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас санал хураалгахгүйгээр гүйцээн боловсруулах чиглэл өгч Байнгын хороонд шилжүүлсэн зарчмын зөрүүтэй 7 саналын томьёололыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зарчмын зөрүүтэй 3 саналын томьёололыг дэмжлээ.

Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг тогтоолын төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс даралтыг жигдлэх хууль зүйн техникийн засваруудыг хийж, тогтоолын төслийн эцсийн хувилбар болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхэнд бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Сэрээтэрийн Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Баярын Хулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга, Бямбаа-Юугийн Артур Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Хүчитбаатарын Итгэлт Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн Бодлого зохицуулалтын газрын дарга, Батзаяагийн Батмагнай Гадаад

харилцааны яамны Хөрш орнуудын газрын дэд захирал, Даваадоржийн Бат-Өлзий Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал, Түргэнбаярын Баяржаргал Гадаад харилцааны яамны хэлтсийн дарга, Хүүгийн Мөнхжаргал “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эрдэнийн Түвшинжаргал “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал, Осоржамаагийн Цэрэндондог “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Нийт 9 гишүүн асуулт асууна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Өнөөдөр бид их хариуцлагатай асуудал ярьж байгаа.

Энэ дээр манай гишүүд саналуудаа нэлээн сайн хэлсэн. Тэгээд тогтоолын төсөл дээр хэд хэдэн зүйлийг бас анхаармаар байна. Өмнө бид яг энэ хил холболтын төмөр замтай холбоотой гэрээг байгуулж байсан. 1955 онд байгуулж байсан.

Тэгэхээр ажлын хэсгийнхнээс энэ гэрээг ер нь үзэж байсан уу? Тийм.

Өнөөдөр энэ гэрээний тогтоол дээр ийм заалт байгаа юм л даа. “Чайна Энержи” компаниас ирсэн захидал дээр гурван.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Д.Жаргалсайхан гишүүн эцсийн хэлэлцүүлэг явагдаж байгаа. Зөвхөн Байнгын хорооны танилцуулгатай холбоотой асуудлаар асуулт асууна. Хувилаад тараачихсан. Таны ширээн дээр байгаа.

Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Би одоо энэ протоколд бүр тэмдэглүүлчихмээр байгаа юм. Ц.Туваан сайд, Б.Дэлгэрсайхан сайд.

20 сая тонноос дээшээ бид нүүрс гаргаад 2030 оноос хойш 20 сая тонноос дээшээ гаргаж болно гэсэн заалт байна шүү дээ. Тэгэхээр энэ 20 саяас тонноос дээшээ гарах юм бол биржийн үнээр Хятадуудад олгоно гэдгээ та хоёр өнөөдөр хэлчихмээр байна. Тэгэхгүй бол одоо 20 сая тонноос дээшээ бүгдээрээ энэ хөнгөлөлттэй үнээр явчих юм биш үү гэдэг эргэлзээ энэ ард түмэн дотор байгаад байна шүү дээ.

Тэгэхээр та хэд минь эргэлзээг тайлж өгч одоо энэ боомтоор гарч байгаа 20 сая тонн нүүрснээс дээших нь биржийн болоод зах зээлийн үнээр явна гэдгээр нэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энэ танилцуулгатай холбогдуулсан асуудлыг ярина. Гишүүд маань өөрсдөө дэгээ сайн барина шүү. Энэ танилцуулга ширээн дээр чинь тараагдчихсан байгаа.

Энэ Р.Сэддорж дарга яагаад танилцуулгаа бүрэн тараахгүй байна.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя. Б.Дэлгэрсайхан гишүүн Жуковын Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Өнөөдөр эцсийн хэлэлцүүлэг хийж энэ төмөр замын холболтын хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээг дэмжиж өгч байгаа гишүүддээ бүгдэд нь талархаж байна.

Тэгээд Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Ямар ч гэсэн бид энэ гэрээнд заасан эхний 5 жилд 27 сая тонн, тэгээд дараагийн 2030 оноос хойш 20 сая тонн олборлолт хийж ачилт хийнэ гэсэн ийм байгаа. Төмөр зам ашиглалтад орсноос хойш.

Тэгэхээр гэрээний нүүрс бол 20 саяас илүү гарвал үлдсэн нүүрс нь бүгд таны хэлсний дагуу биржийн болон худалдааны арилжаагаар нүүрс ачигдана. Ямар нэгэн илүү дутуу нүүрс ачигдахгүй. Гэхдээ бид мэдээж аль болохоор энэ барьсан төмөр замаараа, ашиглалтад орсон төмөр замаараа илүү их нүүрсийг экспортлох ийм зорилготой байгаа гэдгийг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асууна.

Д.Энхтүвшин: Тогтоолын төсөл дээр хэл найруулгатай холбоотой асуудлууд нэлээн хэд байсан. Тэрийг өөрчлөх гээд чадсангүй. Тэгээд ер нь цаашдаа чухал ач холбогдолтой зүйлүүдийг цагийг нь тулгаж орж ирэхээр найруулгын хувьд, утга агуулгын хувьд ч гэсэн алдаатай юмнууд гарах магадлалууд байна.

Тэгэхээр саяын юун дээр зарим нэг өөрчлөлтүүд нь нэг агуулгатай юмыг хоёр, гурван газар яг өөр өөрөөр хэлчихсэн ийм зүйлүүд байна. Тэгээд үүнийг өөрчилж чадсангүй. Тэгээд та бүхэн цаашид ийм чухал асуудлуудыг цагийг нь тулгалгүй оруулж ирэхийг бас хэлмээр байна.

Дээр нь агуулгын хувьд ч гэсэн одоо энэ эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор нүүрс худалдан авах гэрээ хийнэ гэж байх. тэ? Энэ дээр болохоор яг үүнийг тайлбарласан тайлбар. Одоо жишээлбэл 16 хүртэлх жилээр хугацаа

тогтоо гэдэг тооцоо судалгаан дээр үндэслэж хэдэн жилээр хийх гэдэг юмаа гаргаж ирэхгүйгээр асуултуудын явцад бол яг тодорхой хариулт авсан авч чадсангүй. Жишээлбэл, түрүүн Б.Дэлгэрсайхан сайд энэ хөрөнгө оруулалттай холбоотой төмөр замын хөрөнгө оруулалтыг 5 орчим жилийн хугацаанд нөхөх бололцоотой гэж байна.

Тэгэхээр 16 жилийн хугацаанд нүүрсний гэрээ хийх үндэслэл нь жишээлбэл яг энэ дээр шууд гарч ирэхгүй байх жишээтэй. Гэх мэтчилнээр ийм тодорхойгүй байдлууд үлдсэн учраас цаашид энэ гэрээ хийх явцдаа. Энэ яах вэ чиглэл өгч байгаа учраас гэрээ хийгээд явцдаа бас эдийн засгийн хувьд эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор энэ нүүрсний гэрээ хийж байгаа. Тэгээд үүнтэй холбоотой давуу талууд бас нөгөө талд нэмэгдэж байгаа учраас, бий болж байгаа учраас саяын тооцооллуудаас харахаар.

Тэгэхээр үүнийг хэлэлцээрийнхээ бас давуу тал болгож ашиглаарай гэж хэлмээр байна. Үг гэх юм уу даа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Энэ нэр томьёо жигдлэх асуудал дээр ер нь Улсын Их Хурлын Тамгын газар Засгийн газраас өргөн баригдаж байгаа хуулийн төсөл, тогтоолын төслүүд дээр онцгой анхаарал хяналт тавьж байх зайлшгүй шаардлагатай.

Сая төсвийн хэлэлцүүлгийн үед бид бас л энэ нэр томьёотой асуудал дээр болж буруу зөрүү ойлголцох асуудлууд үүсэж байсан. Өнөөдөр бас энэ давтагдан ярьж байгаа.

Байнгын хорооны дарга нар ч гэсэн Байнгын хороон дээр энэ хэлэлцэх эсэхтэй холбоотой Улсын Их Хурлын гишүүдээс гарч байгаа зарчмын зөрүүтэй саналуудтай холбоотой, ялангуяа энэ нэр томьёог жигдлэхтэй холбоотой асуудал дээр анхаарч саналыг нь бүрэн сонсож ажиллаж байх нь зүйтэй гэдэг ийм байр суурийг илэрхийлье.

Ренчинбямбаагийн Сэддорж гишүүн асуулт асууна. Алга байна. Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууна. Алга байна. Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууна. Алга байна. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Яах вэ, хоолой моолой жоохон хяхтнаад хэцүү байх шиг байна. Гадаа ч агаар ч хүнд байна. Үхлийн хөндийд амьдарч байгаа улсууд яах вэ дээ тэгээд. Уучлаарай.

Энэ тогтоолын төсөл ямар гайхамшигтай болох тухай бид бүгдээрээ л ярьж байна л даа. Төгс төгөлдөр талаас нь.

Гэхдээ энэ дээр нэгэнт тогтоолын төсөл батлагдаж байгаа. Үүнээс өөр хувилбар байхгүй гээд л ярьж байгаа юм л даа. Яаж ч ярьсан эцсийн үлдсэн

ганц найдвар нь энэ гэж байгаа юм. Тэгж би ойлгож байгаа юм. Тийм үү, үгүй юу. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэр намын дарга, Ерөнхий сайд маань ганцхан л нам байгаа юм шиг байгаа шүү дээ. Хэлсэн байгаа л даа. Тусгай байгууллагууд бол ажлаа хийж байна. Энэ төмөр замын нөхцөл байдал дээр, хил холболтын юман дээр. Ийм учраас ингэж олон жил гацсан байна гэж хэлсэн. Үүнтэй би ёстой бүрэн санал нийлж байна. Үнэхээр тусгай байгууллагууд ажлаа 100 хувь хийжээ. Гадных л даа. Гэхдээ манайх биш. Хийсэн байна.

Яагаад вэ гэхээр би Улаанбаатараас гараад Өмнөговьор, Тавантолгой, Оюутолгойгоор нь ороод цаашаа тэр Ганцмодоор нь дамжаад 20-иод гишүүн явсан. Тийм.

Тэгээд энэ танилцуулга энэ тэрээ хоёр, гуравхан минутын өмнө өгч байна л даа. Маш их яаралтай горим энэ тэр гэж. Бас ингэж болохгүй л дээ. Энэ чинь Монголын ард түмний хувь заяа байгаа байхгүй юу.

Шинэ жилийн өмнө бас ард түмэндээ бэлэг барих гэж байгааг ойлгож байна. Урантай холбоотой гэрээ бол үнэхээр бэлэг болж чадна. Энэ дээр асуудал алга.

Энэ боомт холбож байгаа энэ зүйл чинь бол үнэхээр гарцгүй болоод, эцсийн эцэст энэ юман дээрээ тулаад бид хийж байна. Олон хувилбар дотроос хамгийн муу хувилбар дээр очоод бид хийж байна гэж би ойлгож байна. Энэ ийм байгаа юу, үгүй юу? Энэ сайд нар юу гэж бодож байгаа вэ? Энэ Засгийн газар.

Үүнээс өөр цаашаа хувилбар байхгүй юу? Тэгсэн мөртлөө бас ийм юм яриад байгаа. Үндсэндээ бид өөр өөрсдөдөө зориулаад л цагаан хэрэм барьчихаж байгаа юм л даа. Өөрсдийнхөө мөнгөөр.

Нөгөө Монгол Улс том эдийн засагтай холбох, өмнө нь байнга худалдаа наймаа хийх Монгол Улсын хөгжлийн гарц бол ахиад хаагдаж байгаа. Бага зэрэг л нээгдэж байгаа. Хуучин байснаасаа арай дээрдэнэ л гэсэн үг. Өөр юм байхгүй. Бидний хийж чадах ажил энэ л юм шиг байгаа юм.

Тэгээд Хятадын нутаг дэвсгэр дээр Хятад компани өөрөө хөрөнгө оруулаад ажлаа хийчихсэн байхад тэндээс тэр компанийн захиаг барьж ирээд гүйгээд яваад байна л даа. Энэ компани ингэж бичсэн шүү гэж.

Энэ тогтоолыг батлахдаа үндэслэл нь тэр компанийн асуудал энэ захиа болчхов уу. Би хэлээд байгаа. Засгийн газар Засгийн газрынхаа хэмжээнд ажиллана шүү. Тэгж байж наад юм чинь арай дээр болох байх гэсэн зүйлийг хэлээд байгаа. Тэгж чадаж байгаа юу, үгүй юу?

Тэгээд Хятадын компани маань 14 тэрбум юанийн хохирол буюу 2 тэрбум долларыг хохирол учирсан гэж ярьж байгаа юм. Бид нарт. Тэрийг та нар байнга дурдаад байгаа байхгүй юу.

Тэр өөрийнхөө нутаг дэвсгэр дээр юу хийсэн нь бид нарт падгүй шүү дээ. Монгол Улсын компаниуд Монгол Улсын хувийн хэвшлүүд ямар ажил хийсэн юм, яасан энэ тэр гэдгийг нь ерөөсөө дэмждэггүй. Би үг хэлэх болохоор тэрийг тусдаа ярья.

Нэг ийм байна. Тэгээд энэ “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компани чинь өнөөдөр яг ямар компани юм бэ? Хувьцаат компани мөн юм уу, хурлаа хийдэг юм уу, хийдэггүй юм уу? 44 их наяд төгрөг хаашаа мэдэхгүй алга болсон гэж байгаа, идэж уусан гэж байгаа. Бие биеэ 100 саяар шагнаж байгаа эд нар.

Д.Амарбаясгалан: Д.Ганбат гишүүн хэлэлцэх эсэх асуудал хэлэлцэж байхад байгаагүй учраас бас тэр үеийн асуултууд нэлээн асуучихлаа. Гэхдээ Д.Ганбат гишүүний асуултад Б.Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Д.Ганбат гишүүн зөв зүйтэй асуудал асуулаа.

Өөрөө бас хамт явсан. Бид хэд. Газар дээр нь хамгийн сүүлд очиж үзсэн. Тэгээд ер нь урд хөрш ямар юм хийснийг бид бүгдээрээ харсан. Бид юу хийж чадаагүй гэдгээ бас бүгдээрээ харсан.

Тийм учраас үүнийг хэн хийсэн, юунаас болсон гэдгийг та мэдэхийн дээдээр мэдэж байгаа.

Тэгээд бид ганцхан Хятадаас ирсэн компанийн захиагаар хийж байгаа юм биш шүү. Энэ захианы агуулга бол 60 гаруй удаа уулзсан уулзалтын үр дүн байсан гэдгийг энд хэлье. Өнөөдөр энд сууж байгаа Ц.Туваан сайд бид хоёр уулзаагүй.

Өмнө нь ажлын хэсэг маш олон удаа уулзаж ярилцсан. Тэр ярилцсан, уулзсан цаг үе болгонд энэ гэрээний доторх агуулга, яриа хөөрөө, буулт хийх, харилцан буулт хийх, харилцан холбох энэ бүх асуудал бүх хүмүүст урагшлуулж байсан учраас тэр үеийн ажиллаж байсан бүх хүмүүст талархаж байгаагаа илэрхийлье.

Тэгээд ямар ч гэсэн Монгол Улс анх удаа түүхэндээ 1955 оноос хойш үндсэндээ хоёр дахь төмөр замын холболтоо хийх гэж байна. Тэгээд ийм түүхэн шийдвэрийг гаргаж өгч байгаа Их Хурлын гишүүддээ талархаж байна. Та ч гэсэн энэ түүхийг бүтээлцэж байгаад би танд талархаж байна.

Яагаад гэвэл хожим хоёр дахь төмөр зам. Энэ бол олон улсын төмөр зам болно. Хоёр тал руугаа орж гарч байгаа. Нэг талаасаа өргөн цариг. Нөгөө

талаасаа нарийн цариг бас яг энэ Замын-Үүд, Эрээн шиг холбогдож байгаа учраас эргэлзэх юм байхгүй ээ гэдэгт би танд хэлье.

Бид овоо байгаагүй шаазгай хаанаас суух вэ гэж урд айлд төмөр зам барь гэж өөрөө өөрсдөө захиалга өгч гэрээ хийчхээд тэгээд тэрний асуудлыг ярилаа гэж бас болохгүй байх. Энэ бол та зохих хүмүүсээс нь асуувал зүгээр байх гэж бодож байна.

Харин Монгол тал бол өмнөөс нь өнгөрсөн 2018, 2019 онуудад үнэхээр төмөр зам наанаас нь барьж очсон учраас өнөөдөр бид бас ийм зам холбох тухай ярих сэдэвтэй болсон.

Тэгээд хоёр улс харилцан бие биеийнхээ царигийг зөвшөөрөлцөж ингээд холбож байгаа нь өнөөдрийн гарч байгаа шийдвэр улс орны хувьд Монгол Улсын хувьд их ач холбогдолтой шийдвэр болж байгаа шүү гэдгийг хэлье. Баярлалаа Танд.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууна. Алга байна.

Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүний микрофоныг өгье. Асуулт асууна.

Д.Жаргалсайхан: Энэ төслийг дэмжиж байгаа. Энэ бидний хувьд энэ ажлаа бол урагшлуулах ёстой. Олон төмөр зам барьсан. Энэ төмөр замуудыг бид бүхэн ашиглалтыг нь сайжруулах ёстой.

Тэгээд энэ дээр цаашид хэлэлцээрийг байгуулах баримтлах үндсэн чиглэл батлах тухай тогтоол дээр 1.2 дээр анхаармаар нэг зүйл байна л даа.

Тэгэхээр энэ юу вэ гэхээр нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гээд л гурван цогц асуудлыг харилцан уялдаатайгаар заагаад өгчхөж байгаа юм.

Тэгэхээр үүнийг ингээд шууд бид чиглэл болгоод өгчихөөр манай “Эрдэнэс Тавантолгой” маань нөгөө олборлох гээд л тендерүүд нь яг үнэхээр зарлагдах уу? Шууд ингэж зааж өгч болж байна уу, үгүй юу гэдэг дээр нэг асуулт байна.

Хоёр дахь нь, 1.3 дээр байгаа. Тогтоолын төслийн. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй байх гээд байж байгаа. Энд ингэж заавал оруулах ямар шаардлага байгаа юм бэ? Энэ чинь юу гэж бусдад олгох юм бэ? Энэ чинь яаж ч бодсон. Тийм биз дээ.

Тэгэхээр энэ тогтоолын төсөл дээр оруулах шаардлагагүй шүү дээ. Энэ чинь тусдаа хууль эрх зүйтэй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр ямар байдлаар оруулсан юм бэ гэдгийг асууж байгаа юм. Ийм хоёр зүйлийг энэ тогтоолын төсөл дээр асууя гэж бодож асуулт авсан байгаа.

Д.Амарбаясгалан: Энэ хэлэлцүүлгийн хэлэлцэх эсэхтэй холбоотой асуудал дээр яригдсан. Байнгын хороон дээр бас зарчмын зөрүүтэй саналууд гараад түрүүчийн хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй санал нь санал хураагдаад ер нь эцэслэн шийдэгдчихсэн байгаа.

Гэхдээ яах вэ Д.Жаргалсайхан гишүүний асуусан асуултад тодруулаад хариулт өгчихье.

Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Д.Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя.

Энэ дээр тийм. Одоо хоёр улсын хооронд маш удаан хугацаанд яригдаж байгаа. Сая Б.Дэлгэрсайхан сайд хэллээ. Ажлын хэсэг 60 гаруй удаа хэлэлцэгдсэн. Маш олон ажлын хэсгийн дарга нар томилогдож ингэж энэ ажлыг ахиулж ирсэн.

Энэ гурвыг цогцоор гэдэг асуудал буюу энэ гурван зүйлийг. Өөрөөр хэлбэл

- ▶ төмөр замын хил холболт,
- ▶ нүүрс худалдах, худалдан авах гэрээ,
- ▶ уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг энэ 3 асуудлыг цогцоор нь зурахаар 2014 он онд тохироод байгуулъя гээд явсан зүйл байдаг.

Тэгэхээр энэ дээр бид эхний

- ▶ төмөр замын гэрээ хэлцэл бараг 100 хувьтай,
- ▶ худалдах, худалдан авах гэрээ 90 гаруй хувьтай,
- ▶ уурхайн хүчин чадал нэмэгдүүлэх асуудал эхлэлийн шатандаа яригдаад явж байгаа.

Тэгээд энэ чиглэлээ аваад бид цаашаа Засгийн газар хоорондын хэлэлцээр, түүний ар дээр дахиад аж ахуйн нэгжүүдийн хоорондын гэрээнүүд орно. Энэ ингээд өнөөдөр үүгээр дуусаж байгаа биш. Нарийвчилсан нарийн заалтууд нь гэрээ, хэлэлцээрүүддээ бас ороод явах боломжтой гэдгийг хэлье.

Тэр “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувь лиценз гээд энэ асуудлыг яагаад оруулсан бэ гэхээр өмнө нь манай энэ асуудал маань маш удаан хугацаанд гацаж ирсэн, маргаан, улс төржилт дагуулж ирсэн ийм сэдэв.

Тэгээд энэ сэдэв дотор “Эрдэнэс Тавантолгой” эзэмшдэг 8 лицензээс өгөх, “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаанд хувь эзэмших энэ тэр гээд иймэрхүү асуудлууд яригдаж байсан учраас үүнийг хааж, одоо дахиж ийм асуудал байхгүй гэдэг байдлаар оруулж өгсөн юм.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 3 санал байна.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 гишүүн үг хэлж болно.

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Гишүүд зарчмын зөрүүтэй саналтай холбоотойгоор үг хэлэх байгаа шүү дээ. Урьдчилан ирүүлсэн нэрс байхгүй. Үг хэлэхгүй шүү дээ.

Зарчмын зөрүүтэй санал дээр “дэмжсэн” болон “эсрэг байр суурьтай” тус бүр 2 гишүүн үг хэлэх дэгтэй.

Одоо шууд санал хураалт явагдах ёстой. Зарчмын зөрүүтэй саналыг “дэмжсэн”, “эсрэг байр суурьтай” тус бүр 2 гишүүн үг хэлэх боломжтой. Дэгээрээ. Эцсийн хэлэлцүүлэг явагдаж байгаа. Тийм.

Хууль зүйн байнгын хороо хуралдаж байгаа. Хурлаа түр завсарлуулаад орж ирж санал хураалтад оролцохыг хүсэж байна. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал хураалтыг эхлүүлъя.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “харилцан ашигтай” гэсний дараа “хувилбарт шийдэл бүхий нөхцөлөөр” гэж нэмэх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

52.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Байтаг-Улиастайн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, Булган-Такашикен боомтод улсын хилийн 126, 127 дугаар дугаар тэмдгийн хооронд автозамаар улсын хилийн шугамыг дайран өнгөрөх цэгийг тохирч, хилийн гарц шинээр нэмэх, нүүрс ачиж буулгах талбай, ачаа тээврийн терминал болон улсын хил дамнасан авто замын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэх талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохиролцох.” гэсэн 11 дэх дэд заалт нэмэх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

56.7 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төсөл дэх нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх хүрээнд төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “эдийн засгийн үр ашгийг” гэснийг “эдийн засгийн өгөөжийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. /алх цохив/

66.3 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Одоо Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт эхлээгүй байгаа шүү. Байж байгаарай. Цуцалчихъя. Би нэг зүйл тодруулаадахъя. Тамгын газраас.

Энэ чинь юу билээ? Ердийн олонхоор уу? Тэгвэл Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

65.4 хувиар тогтоол батлагдлаа. Тогтоолын төсөл батлагдлаа. /алга ташив/

Улсын Их Хурлын гишүүд, Ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Дараагийн санал хураалт руу оръё.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ /үргэлжлэл/

Өмнөх асуудлын санал хураалтыг хойшлуулсан байгаа.

Байнгын хорооны саналаар Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувиар санал дэмжигдлээ.

2.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

67.3 хувиар санал дэмжигдлээ.

Л.Гантөмөр, Б.Бейсен, Гомбын Ганбаатар, Б.Жаргалан, Б.Пунсалмаа, Ц.Туваан, Энхбатын Болормаа, Д.Энхтүвшин, Б.Заяабал гэсэн гишүүдийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Нэмж.

3.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

75.0 хувиар санал дэмжигдлээ.

4.“Хархорум хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

72.1 хувиар санал дэмжигдлээ.

5. “Хархорум хотын эдэлбэр газрын хил заагийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

70.2 хувиар санал дэмжигдлээ.

Хархорум хотын бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ.

Дараагийн асуудалд оръё.

**Европын сэргээн босголт, хөгжлийн банк
үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг
хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.12.23-ны өдөр өргөн мэдүүлсэн,
зөвшилцөх, хэлэлцүүлэх/ /үргэлжлэл/**

Үдээс өмнө хэлэлцсэн Байнгын хорооны саналаар Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад нийт гишүүдийн олонх буюу 64 гишүүнээр соёрхон батлах төсөл дэмжигдэх ёстой.

Ингээд соёрхон баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

76.2 хувиар санал дэмжигдлээ. 80 гишүүн. Дараагийн асуудалд оръё.

**Тав. Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил”
ажиллагааны хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын
мэдээллийг сонсоно**

Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар мэдээлэл хийнэ.

Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улс шинэ Үндсэн хуулиа баталж ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш 1992 оноос 2024 он хүртэл нутаг дэвсгэрийг төлөөлсөн 76 гишүүнтэй парламенттайгаар үйл ажиллагаа явуулж ирсэн бол 2024 оноос буюу энэ жилээс сонгуулийн холимог тогтолцоогоор бүрдсэн 126 гишүүнтэй парламент, түүнээс бүрдсэн хамтарсан Засгийн газар өөрийн түүхийг ийнхүү бичиж эхэлж байна.

Улсын Их Хурлын болон Орон нутгийн сонгуулийн 2024 он өндөрлөх дөхөж, улс төр, нийгэм, эдийн засгийн бүтцийг цоо шинээр харах нийгмийн захиалга бүхий түүхэн хариуцлагатай 2025 он эхлэх гэж байна.

Өнгөрснөө зөвөөр дүгнэхгүйгээр ирээдүйг зөв тодорхойлох боломжгүй гэдэгчлэн өнөөдрийн энэхүү мэдээллийг ондоо багтаж өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Өчигдөр Та бид хамтдаа 16-аас 20 жилийн хугацаанд гацсан хөгжлийн томоохон төслүүдийг хөдөлгөх түүхэн шийдвэрийг хамтдаа гаргалаа.

Ерөнхий сайдын хувьд улс орны хөгжлийн томоохон асуудлыг том зургаар нь харж дэмжсэн парламентын гишүүд Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Төслүүд гацсан үндсэн суурь шалтгаан эрх ашгийн сонирхол байсан гэдгийг ч өчигдөр бид олон талаас нь дүгнэн ярилцлаа.

Шүүхийн шатад, мөн цэцийн шатад том төслүүд хэрхэн гацсан шалтгаанууд, улс төрийн нөлөөлөл, авлигын хэргүүдийн шүүхийн шатад эргэж буцсан олон шийдлүүдийн зангилааг ч үе солигдсон шинэ парламент нөлөөтэй аливаа толины тусгалгүйгээр олж харж тогтолцооны хувьд засаж залруулж чадна гэдэгт Ерөнхий сайдын хувьд гүнээ итгэж байна.

Ирээдүйн хөгжлийн боломжоо дахин алдахгүйн тулд бид өнөөдөр өвчнөө зөв оношилж, мөн зөв эмчлэх ёстой. Хуримтлагдсан асуудлуудыг хамгийн зөв оношлох аргачлал бол хүний оролцоогүй цахим шилжилт билээ.

Аливаа асуудалтай тэмцэхийн тулд эхлээд асуудлыг бүрдүүлж буй хөрстэй нь тэмцэх ёстой гэдэгтэй мөн санал нэг байна. Энэ агуулгаар төрийн байгууллагуудын салангид мэдээлэл, өгөгдлийг цэгцэлж нэгдсэн дүгнэлт хийхийн тулд e-mongolia платформыг Эстони Улсын туршлагад тулгуурлан нээж өнөөдөр 2 сая орчим хэрэглэгчтэй 1263 үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлж байна.

E-mongolia өнгөрсөн хугацаанд 4 удаа шинэчлэгдсэн бөгөөд цаашид төрийн байгууллагууд нэгдсэн цахим шуудангаар хоорондоо мэдээлэл солилцдог болох, төр иргэн хоорондоо мэдээлэл солилцдог болох, шаардлагатай мэдээллийг иргэн өөрийн цахим хаягаас татаж авдаг байх, банкны салангид төлбөрийн системүүд хоорондоо солилцдог болох чиглэлд хөгжүүлэлт хийгдэж байгаа бөгөөд Үндэсний баялгийн сангийн хуримтлалын сантай сүүлд уялдуулсан нь ч хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх давхар зорилготой байсан.

E-mongolia төслөөс гадна “shilen.gov.mn” цахим хуудсыг нээж төрийн байгууллагуудын худалдан авалт, сангуудын зарцуулалтыг ил тод болгох, яам, агентлаг, аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит төрийн оролцоотой мэдээлэл хариуцагч байгууллагын 970 мянга 335 мэдээллийг ил болгож, зарим мэдээлэл нь жагсаалын түвшинд, зарим мэдээлэл нь Улсын Их Хуралд нээлттэй сонсголын хэлбэрээр зохион байгуулагдах түвшинд очсон нь тухайн үед хэдийгээр нийгмийг бухимдуулсан ч иргэдийн мэдэх эрхийг хангаж, цаашдын алдааг засах, мөн 2023 онд Засгийн газраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өргөн барих хөрсийг бүрдүүлсэн гэж мөн үзэж болно.

Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш буюу 2 жил 7 сарын хугацаанд уг хуульд нээлттэй байхаар заасан 5 чиглэлийн 68 төрлийн мэдээллийг ил тод байдалд шилэн индексийн үнэлгээ хийж мэдээлэл хариуцагч 564 байгууллагын дундаж үзүүлэлт 67 хувьтай гарсан байна.

Энэхүү мэдээлэлд тулгуурлан Монгол Улсын Засгийн газраас төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах тухай хуулийн төслийг боловсруулж дууссан бөгөөд энэ намрын чуулган завсарлахаас өмнө Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгэл ажлаа бүрэн хангасныг мөн дурдахад таатай байна.

Энэхүү хууль батлагдвал олон улсын байгууллагуудын олон жил Монгол Улсад зөвлөсөн зөвлөмж бодит ажил болж, төрийн өмчит компани 40 орчим хувиар багасаж, ашиг орлоготой компаниуд нэгдсэн корпорацийн зарчмаар ажиллах боломж эрх зүйн хувьд бүрдэх болно.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад бүртгэгдсэн төсвийн байгууллагын 1511 мэдээлэл нээлттэй байршсан бол төрийн өмчит 119 компанийн ашиг алдагдлын мэдээлэл олон нийтэд мөн ил болоод байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас ирэх хаврын чуулганаар цахим өгөгдөлд тулгуурлаж татварын багц хууль, нийгмийн даатгалын багц хуулийг Хөрөнгө оруулалтын хуультай хамтад нь өргөн барихаар бэлтгэл ажлаа хангаж байна.

Хөрөнгө оруулагчид, хувийн хэвшил, төрийн байгууллага, олон улсын байгууллагуудын өргөн төлөөлөлтэйгөөр олон жил яригдсан энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд хамтарсан Засгийн газар мега төслүүдээ амжилттай хэрэгжүүлэх нь суурь тоонуудыг бодит байдлаар дүгнэхэд туйлын чухал байгаа учраас энэ намрын чуулганд мега төслүүдийг хөдөлгөх нь туйлын чухал гэдгийг дахин онцлон тэмдэглэе.

Татвар, нийгмийн даатгал, хөрөнгө оруулалтын эдгээр гурван эрх зүйн реформыг бид хаврын чуулганд багтан цогцоор нь шийдвэрлэж чадвал 2025 оны улсын төсөв их өгөгдөлд тулгуурласан төсөв байх боломж бүрдэх бөгөөд зөөлөн дэд бүтцийн хөгжил рүү илүүтэй чиглүүлэхээр тооцож байна.

2028 онд дотоодын нийт бүтээгдэхүүнийг 132.3 их наяд төгрөгт, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг одоогийн ханшаар 10 мянган ам.долларт хүргэх Засгийн газрын зорилтыг хэрэгжүүлэхийн тулд шинэ эдийн засгийн бүтцийг бий болгох гурван шилжилтийг мөн цахим хөгжлийн бодлоготой уялдуулж зайлшгүй хийх шаардлагатай гэж үзэж байна.

Бид асар хурдтай хувьсан өөрчлөгдөж буй хөгжлийн шинэ эрин үед амьдарч байна.

Би өмнө нь дурдаж байсан. Хүн төрөлхтөн уурын хөдөлгүүр үүсэж механикжсан технологи нэвтэрсэн аж үйлдвэрийн нэгдүгээр хувьсгалаас дотоод шаталтын хөдөлгүүр нэвтэрч, автомашин, нисэх онгоц, эрчим хүчний хэрэглээнд нэвтэрч, масс үйлдвэрлэл хөгжсөн аж үйлдвэрийн хоёрдугаар хувьсгал хүртэл дунджаар 100-аас 120 жилийг зарцуулсан бол компьютер, тоон технологи нэвтэрсэн аж үйлдвэрийн гуравдугаар хувьсгалаас интернэтийн сүлжээ, ухаалаг технологид шилжсэн дөрөвдүгээр хувьсгал хүртэл ердөө 30 орчим жилийг зарцуулсан байна.

Тиймээс ч “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан шинжлэх ухаан, өндөр технологийн хурдтай хөгжил, AI[Artificial Intelligence] хиймэл оюун ухаанд суурилсан аж үйлдвэрийн тав, цаашлаад зургадугаар хувьсгалтай хөл нийлүүлэн алхаж шинэ эдийн засгийн бүтэцтэй болоход Монгол Улс дараах 3 шилжилтэд бэлэн байх зайлшгүй шаардлага үүсэж байна. Үүнд:

▶ **Нэгдүгээрт, Хиймэл оюун ухаан, өндөр технологийн шилжилт.**

Үүнд “их өгөгдөл”-д суурилсан

- ▶ төлөвлөлт, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг бүрдүүлэх;
- ▶ эдийн засгийг тэргүүлэх чиглэлүүдийн бүтээмжийг нэмэгдүүлэх;
- ▶ төрийн бүтээмж, гүйцэтгэл үнэлгээний уялдаа холбоог цахимжуулах;

▸ төрийн үйлчилгээний оновчтой болон хүртээмжтэй байдлыг их өгөгдөлд тулгуурлан цахимжуулах.

- ▶ **Хоёрдугаарт, Ногоон хөгжлийн шилжилт, цэвэр эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчний шилжилт, цахилгаан автомашины хэрэглээний шилжилт.**

Ногоон байгууламжийн стандарт орчны бохирдлыг бууруулах, Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, бэлчээр усны нөөцийн асуудал болон бусад асуудлыг мөн цахим ногоон хөгжлийн шилжилтээр хийх шаардлага үүсэж байна.

- ▶ **Гуравдугаарт, Хүний нөөцийн шилжилт.**

Боловсролын салбар, хөдөлмөрийн зах зээлтэй хэрхэн уялдаж байгаа, нийгмийн даатгал, татварын орчин, орон сууц, үндэсний баялгийн сан зэрэг сангуудын хоорондын уялдаа холбоо, хөдөлмөрийн үнэлэмж, өрсөлдөх байгууллагын чадварыг нэмэгдүүлэх зэрэг болно.

Цахим шилжилт бол зөвхөн төрийн байгууллагуудын мэдээллийг нэгтгэх, эсвэл аль нэг салбарын асуудал биш харин бүх салбарыг хамарсан шинэ эдийн засгийн суурийг бүрдүүлэх зөөлөн дэд бүтэц юм.

Их өгөгдөл байхгүй бол дүн шинжилгээ хийх боломжгүй. Дүн шинжилгээ хийхгүй бол оновчтой зөв шийдвэр гаргах боломжгүй нь тодорхой.

Өнөөдрийн мэдээллийн үндсэн зорилго бол Засгийн газраас эдгээр 3 шилжилт болон үүн дотор цахим шилжилтийг эрчимжүүлэхэд эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Улсын Их Хурал анхаарлаа хандуулахыг Засгийн газрын зүгээс хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Одоо мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Батбаярын Жаргалан, Улсын Их Хурлын гишүүн, ХҮН намын төлөөлөл Пүрэвжавын Ганзориг, Улсын Их Хурлын гишүүн, Үндэсний эвслийн төлөөлөл Агваанлуvsангийн Ундраа, Улсын Их Хурлын гишүүн, Иргэний Зориг ногоон намын төлөөлөл Батын Батбаатар нар төв индэр дээрээс үг хэлнэ. Тус бүр 6 минут.

6 минутаар хугацаа дуусгавар болж микрофон хаагдана гэдгийг гишүүдэд урьдчилан сануулж хэлье.

Ингээд Батбаярын Жаргалан гишүүнийг индэрт урьж байна.

Б.Жаргалан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 41.1 заасанчлан Ерөнхий сайд нь төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцдаг билээ.

Шил ажиллагаа гэх улс төрийн сурталчилгааны зорилготой нэр томъёог хууль зүйн хүрээнд авч үзвэл нээлттэй, мэдээллийн ил тод байдалтай холбоотой буюу Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Авлигын эсрэг эсрэг хууль болон бусад хуулийн биелэлтийн талаарх мэдээлэл гэж ойлголоо.

Нээлттэй, ил тод байдал нь авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх үр дүнтэй арга хэлбэр гэдгийг хүлээн зөвшөөрч ажиллаж байгаад талархалтай хандаж байна.

Гэвч Ерөнхий сайдаас өгсөн мэдээллийг нягтлахад нээлттэй ил тод байдлыг тогтоосон хуулийн биелэлтийг хангалттай хариуцан ажиллаж чадахгүй байна гэсэн дүгнэлт гарч байна. Учир нь Засгийн газар хууль хэрэгжүүлэх гэхээс илүүтэйгээр улс төрийн ашиг хонжоо олох зорилготой ямар нэг ажиллагааг зарлан тунхаглаж зөвхөн тэр хүрээндээ баригдан ажиллаж байгаа нь хууль хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгт нийцэхгүй байна.

Ямар нэг ажиллагааг цэрэг цагдаагийн байгууллагаас өөрсдийн үйл ажиллагааны онцлогтойгоор холбогдуулан зохион байгуулдаг. Харин эх орондоо иргэний ардчилсан нийгэм цогцлоохыг эрхэм зорилгоо болгосон ардчилсан үндсэн хуулийн дагуу байгуулагдсан Засгийн газар нь хуулийн биелэлтийг хангаж ажиллах үндсэн чиг үүрэгтэй төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага юм.

Тодруулбал, Засгийн газар нь ямар нэгэн ажиллагаа явуулах бус Улсын Их Хурлаас баталсан заавал биелэх хүчин чадалтай хуулийг хэрэгжүүлэх гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэй гэдгийг танд онцгойлон сануулж байна.

Өнөөдөр нээлттэй, ил тод байдлын харилцааг зохицуулж байгаа хуулиудаас тодорхой үр дүнгээ өгч байгаа гол анхдагч хууль нь Ардчилсан нам Улсын Их Хуралд олонх байх үед буюу 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Шилэн дансны тухай хууль гэдэгтэй хэн ч маргахгүй.

Шилэн дансны тухай хуулийн зорилт нь төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх явдал юм.

Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, компанийн төрийн өмчит үйлдвэрийн газар, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ,

ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч, мөн төрийн санхүүжилт авч байгаа нам, эвсэл бүгд хамаардаг.

Өнөөдөр Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ энэ хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хуралд ажлаа хариуцаж тайлагнах ёстой атал хуулийн хэрэгжилт бус ямар нэг хийсвэр ажиллагааны талаар мэдээлж байгаа нь харамсалтай.

Түүгээр зогсохгүй “Шил” ажиллагаа гэх Ерөнхий сайдын танилцуулсан “shilen.gov.mn” систем болон түүнд байршсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нийтийн мэдээллийг бүхэлд нь хамарч чадахгүй байна.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг энэхүү санал, дүгнэлтээр Ерөнхий сайдаас гагцхүү бодит байдал буюу хуулийн биелэлтийг шаардаж байгаа юм. Шилэн дансны хуулийн 6.10 дахь заалтад шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг нийтэд мэдээлэх үүрэгтэй гэж заасан байдаг.

2022 оны Үндэсний аудитын газрын шалгалтаар Засгийн газрын 13 яамны 12 нь Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрддөггүй, шилэн дансанд байршуулах ёстой мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, ил тод мэдээлдэггүй гэсэн зөрчил дутагдлыг илрүүлж байв.

Түүнчлэн 2016 он хүртэл Монгол Улс төрийн нууц мэдээллийг хуулиар тогтоон хамгаалж ирсэн.

Гэтэл 2016 онд Монгол Ардын нам Улсын Их Хуралд олонх болсон даруйдаа буюу 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хүч түрэн баталж, төрийн нууцаас гадна албаны буюу төрийн байгууллагын нууц гэсэн шинэ ойлголтыг бий болгосон.

Ингэснээр маш олон гэрээ болон бусад мэдээллийг нууцад хамруулж, олон нийт мэдэх эрхгүй болж, мэдвэл шоронд орох нөхцөл бүрдсэн. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагын аль ч шатын дурын нэг дарга өөрийнхөө үйл ажиллагааг нууцад хамруулан олон нийтээс далдлах боломжийг бүрдүүлсэн нь манай улсад авлига цэцэглэн хөгжих таатай хөрс болсон бөгөөд үүнийг залруулах, өөрчлөх тал дээр Ардчилсан намын бүлэг тууштай ажиллах болно гэдгийг мэдэгдэж байна.

Үүнээс гадна улс төрийн нам нь шилэн ажиллагаанд хамрагдахгүй байна. Шил ажиллагааг хэрэгжүүлж буй Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нь өөрийн удирддаг намаа “Шил” гэх ажиллагааныхаа гадна үлдээснийг гайхан анзаарч байна.

Эрх баригч намын санхүүжилт “Шилэн бус ширэн байгаа”-г танд дахин сануулъя.

Манай улс авлигын индексээр 2016 онд 180 орчим орноос 87-д жагссан бол 2024 онд энэ үзүүлэлт 121 болж, 8 жилийн дотор 34 нэгжээр ухарсан. Авлигын аюул занал нь ардчиллын үнэт зүйлс, ардчилсан тогтолцоог сулруулж, шударга ёсыг үгүй хийж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулдаг бөгөөд төрийн тогтвортой байдал, сайн засаглал, эдийн засгийн хөгжилд заналхийлсээр ирлээ.

Тиймээс “Ширэн биш шилэн төр”-ийг хүсэж байгаа бол, “Авлигагүй нийгэм”-ийг бүтээхийг зорьж байгаа бол Засгийн газар өөрөөсөө олонхыг бүрдүүлсэн Монгол Ардын нам, мөн өөрөөсөө эхлэн үйл ажиллагаагаа шилэн болгож нийтийн манлайлал үзүүлэхийг хүсье.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотойгоор Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг уншиж танилцууллаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одоо Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг гишүүн.

Индэрт урьж байна. Улс төрийн намын тухай хууль 18 жилийн дараа батлагдаад улс төрийн намууд татварт тайлангаа ил тод өгдөг болох хуулийн зохицуулалт өнгөрсөн жил батлагдсан.

Энэ бас “Шил” ажиллагааны их том үр дүнгийн нэг дээ. П.Ганзориг гишүүнийг урьж байна.

П.Ганзориг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлд дурдагдсан авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Шил” ажиллагааны талаар Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөл дараах байр суурийг илэрхийлж байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шил” ажиллагааны үр дүнд төрийн үйл ажиллагааны ил тод байдлын зарчим цахимжуулах ажлуудад тодорхой дэвшил гарч байгаа хэдий ч цаашдаа Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийн хүрээнд сайжруулах анхаарах шаардлагатай дараах асуудлууд байна.

1.Шилэн дансны сайтуудад тодорхой мэдээллүүд олон нийтэд ил тод байдлаар байршиж байгаа хэдий ч холбогдох мэдээллүүд нь бүрэн бус, цаг хугацааны хоцрогдолтой ордог. Тргэд олон нийтэд ойлгомжтой бус байдалтай байна.

Уг асуудал дээр Засгийн газрын зүгээс төрийн мэдээллийн нэгдсэн стандарт форматад оруулж иргэд, олон нийт дүгнэлт, анализ хийх боломжтой

зэргээр олон төрлөөр ашиглахуйц байдлаар байршуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

2.Төсвийн ил тод байдлын асуудлаар Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Сангийн яамны танилцуулсан мэдээлэл төсөвтэй холбоотой цахим мэдээллүүд нь олон нийтэд харьцангуй нээлттэйгээр нийтлэгдсэн боловч төсвийн ил тод байдлыг хангахын тулд улсын төсөв, түүний зарцуулалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар хэрэглэж болохуйц хялбар шийдлээр байршуулах талаар тодорхой саналууд гаргаж байсан.

Тухайлбал, энэ удаагийн Улсын Их Хурлын намрын чуулганаар 2024 оны Улсын төсвийн тодотгол, Монгол Улсын 2025 оны Улсын төсвийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдэд Сангийн яамнаас төсвийн мэдээллийг хайлт хийх боломжтой цахим файл хэлбэрээр олгоогүй нь Улсын Их Хурлын гишүүд улсын төсөвт дүн шинжилгээ хийхэд хүндрэл учирч байсныг цаашид анхаарч засах шаардлагатай байна.

3.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээ сайжруулах, шилэн ажиллагааг үргэлжлүүлэн төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ хэлцэл, мэдээллийн санг олон нийт нээлттэй, ил тод болгоно гэж заасан.

Тус заалт нь хамтарсан Засгийн газарт орсон намууд болон тэр дундаа ХҮН намын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт бөгөөд энэ нь төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэхтэй холбоотой хууль, тогтоомжийг шинэчлэн сайжруулах зорилготой юм.

Цаашид Төрийн болон албаны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжуудад зохих сайжруулалтуудыг хийж, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг улам нэмэгдүүлэх, дээр дурдсан нөхцөл байдлыг засаж сайжруулах чиглэлээр Засгийн газраас хууль тогтоомжийн шинэчлэлийн төслийг өргөн барих хэрэгцээ шаардлага байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй 5Ш ажиллагаа нь, тэр дундаа шил ажиллагаа ардчиллын суурь зарчим болох иргэдийн мэдэх эрхийг хангаж, төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мөн аливаа албан тушаалтны авлига ашиг сонирхлоос ангид байх, урьдчилан сэргийлэх, цаашлаад бизнес, гадаад, дотоод хөрөнгө оруулалтын тооцоо орчныг бүрдүүлэх зэрэг чухал үүрэгтэй бөгөөд Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөл төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, аливаа санал санаачилгыг дэмжин хамтран ажиллах болно. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Одоо Үндэсний эвслийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Агваанлуvsангийн Ундрааг индэрт урьж байна.

А.Ундраа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас авлигалтай тэмцэх талаар авч хэрэгжүүлж буй шил ажиллагааны талаар мэдээлэл сонслоо.

“Shilen.gov.mn” сайт ажиллуулсан. Түүний хандалт 15 сая гаруй удаагийн хандалттай байгаа нь Монгол Улсын иргэд ил тод, авлигагүй нийгмийг бий болгох хүсэлтэй нээлттэй мэдээллийг авах хүсэл эрмэлзэлтэй байгааг илэрхийлж байна.

Иргэд маань авлигагүй улс орныг хүсэж, ил тод байдлын чухлыг маш сайн ойлгож байна.

“Shilen.gov.mn” сайтад нийт хэдэн төрийн байгууллагууд мэдээлэл оруулах ёстойгоос хэд нь оруулж, хэд нь оруулаагүйг харуулбал илүү бодитой дүгнэлт гарахаар байлаа.

Харамсалтай нь мэдээлэл оруулсан байгууллагуудын гүйцэтгэлийг харуулж, төрийн байгууллагуудын хамрагдалтыг тооцоогүй нь бодит байдлыг дүгнэхэд учир дутагдалтай байгааг харуулж байна.

Нэг жишээ дурдахад Богдхаан уулын дархан цаазтай газарт газар олгогдсон байдлын талаарх мэдээлэл одоог хүртэл бүрэн ил тод бус хэвээрээ байна. 2015 оноос хойш Монгол Улс авлигалын индексээр нийт хэдэн байраар ухарсан талаар хуваалцъя.

2015 онд 72 дугаар байранд байсан бол 2016 онд 38 оноо авч 87 дугаар байраар ухарсан нь авлигатай тэмцэх үйл хэрэг нь тухайн үедээ оновчтой байгаагүйг шууд хэлж байна.

Цаашлаад Монгол Улс бүсийн дунджаас доогуур буюу нийтдээ 100 онооноос 33 оноогоор 180 орноос 121 дүгээр байранд орж байгаа нь 2023 оны байдлаар өмнөх оноос нийтдээ 50 гаруй байраар ухарсан нь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд ахиц гарахгүй байгааг нотолж байгаа бас нэгэн баримт юм.

Цаашид сонгуулийг мөнгөнөөс хамааралтай байдаг байдлыг халах, үүнийг хууль тогтоомжийн хүрээнд зохицуулах, улс төрийн намуудын дотоод сонгуулийн журмыг ил тод болгох зэрэг төрийн байгууллагуудын ил тод байдлын үйл ажиллагааг нэвтрүүлж, гүйцэтгэл дээр анхаарал тавих нь авлигатай тэмцэх бодит үйлдэл болно гэж үзэж байна.

Бидэнд гоё ая тавьсан боевик киноны трейлерээс илүүтэй бодит гүйцэтгэл, үр дүн чухал байна. Жишээлбэл, ийм бодит үр дүн хэрэгтэй байна.

Румын Улсын Авлигатай тэмцэх газрын дарга Лаура Кодруца /Laura Codruța/ гэдэг эмэгтэй эх орондоо амьд домог болж байна.

Тэрээр 2013-2018 оны хооронд Үндэсний Авлигатай тэмцэх газрын Ерөнхий прокурорын албыг хаших хугацаандаа нийтдээ улсдаа олон 100 сая еврогийн хохирол учруулсан авлигалын 1100 гаруй хэргийг илрүүлж, 2 мянга гаруй төрийн өндөр албан хаагчдыг авлигалын хэргээр шоронд суулгасан байна.

Лаура Кадруцагийн барьсан авлигачдын дунд парламентын гишүүд, үеийн Засгийн газрын сайд нар, агентлагийн дарга нар, муж, хотын дарга нар, төрийн өмчийн компанийн захирлууд оржээ.

Тэрээр сарын тухайн үедээ 3200 еврогийн цалинтай, ипотекийн зээлээр авсан 2 өрөө байранд амьдардаг байсан ажээ.

Лаура Кодруца 2019 оноос Европын Холбооны Ерөнхий прокуророор томилогдон ажиллаж байна.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотойгоор Улсын Их Хурал дахь Үндэсний эвслийн байр суурийг илэрхийлэхэд ийм байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одоо Батын Батбаатар Улсын Их Хурлын гишүүн, Иргэний зориг, Ногоон номын төлөөлөл.

Б.Батбаатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, иргэд сонгогчид оо,

Авлига бол Монголоос зайлах ёстой зүйл. Авлига бол Монголд амьдрах ёсгүй зүйл. Авлигын эсрэг олон үйл ажиллагаа зэрэгцэн явж байж сая Монгол Улс хөгжих боломж гарч ирнэ. Түүний нэг шилэн тухай, шилэн төртэй байх тухай асуудал өнөөдөр Ерөнхий сайдын мэдээллийн цагаар олон нийтэд танилцуулагдаж байна.

Улсын Их Хурлын гишүүдэд биш эндээс олон нийтэд танилцуулагдаж байна. Иргэд сонгогчдод танилцуулагдаж байна гэж Иргэний Зориг Ногоон намынхан дүгнэж байгаа.

Иргэний Зориг Ногоон Нам энэ 118-ын бүлэг буюу Засаг барьж байгаа Их Хурлын 118 гишүүний энэ дүр үзүүлсэн үйлдлийг болио гэж зөвлөж хэлж байна.

Аргагүй Их Хурлын дэгийн тухай хуулийнхаа дагуу аргагүйн эрхэнд засаг барьж байгаа нөхдүүд цөөнхийн гэдэг үгээр үг хийж байна.

Бүлгийн төлөөллийг гаргасан үг уншиж сонсголоо гэдэг үгээр үгээ дуусгаж байна.

Улсын Их Хурал бол ард түмний бүрэн төлөөлөл. Улсын Их Хуралд ард түмэн бүгдээрээ сууж байгаа гэж ойлгох хэрэгтэй.

Энэ ард түмний 118 хүн нь хамтдаа бүлэг үүсгэж, нэг засагтай болсон. Үлдсэн цөөнх нь уг нь тэр цөөнхийн эрхийг эдлэх хэрэгтэй юм байгаа юм. Засгийг хамгаалах байдлаар 118-ын бүлгээс энэ Ерөнхий сайдын мэдээллийн цаг дээр ийм дүгнэлт уншдаг дүр үзүүлсэн ардчилал хэрэггүй. Бидэнд.

Шилэн байх тухай ойлголт бол иргэдийн мэдэх эрхийн тухай асуудал. Тэр мэдэх эрхийг цөөнх иргэдэд олгодог. Эрх мэдэл өөрөө өөрийгөө хянадаггүй. Эрх мэдэл бусдыг хянахын төлөө зориулагддаг гэдгийг онол, практикаар бид хангалттай мэднэ.

Өнөөдөр Улсын Их Хурал дахь хяналт шалгалт, хөндлөнгийн дүгнэлт гаргах боломжит Төсвийн зарлагын хяналтын дэд хороо буюу бусад Хүний эрхийн дэд хороо энэ чиглэлийн байгууллагууд өнөөдөр энэ 118-ын бүлгээс томилогдож байгаа.

Та бүхэн шилэн байя гэж бодвол энэ зүйлийгээ цөөнхдөө чөлөөлж өгөх үүрэгтэй.

Улсын Их Хуралд болж байгаа бүтцийн болон бусад үйл ажиллагааны энэ бүх зохицуулалтыг 118-ын бүлэг бүх асуудал дээр эрх мэдлийг өөртөө хадгалж авч үлдэж байгаа.

Цөөнх юу хийх ёстой вэ. Өнөөдөр Монголын ард түмэнд ус агаар мэт хэрэгтэй байгаа цөөнхийн үүрэг гэж байгаа. Иргэдийн мэдэх эрхийг нь хангаж өгөх бол цөөнхийн хийх хамгийн гол чухал ажил. Хариуцлага үүрээд засгаа барьж байгаа олонх хийх ажлаа бас хийдэг байх хэрэгтэй.

Та бүхний зөв зүйтэй их санаачилж хийсэн ажил дээр дэмжинэ. Буруу зөрүү бусдаас нууж, хааж, араар нь хөшигний цаана хийж байгаа зүйлийг буруушаана, шүүмжилнэ. Хөшиг болгоныг, цонх болгоныг нээлттэй байхын төлөө Иргэний Зориг Ногоон Намынхан ажиллах болно.

Бид иргэнээ боддог. Бид иргэдийнхээ зориг гэдгийг зүрх сэтгэлтэй, мөрөөдөлтэй, ирээдүйдээ итгэх итгэлийг нь зориг гэж ойлгодог. Байгаль орчин, орчны эрүүл мэнд, хүрээлэн буй орчны соёл иргэншил, энэ ногоон соёл иргэншил Монголын ард иргэдэд ирээдүйн үр хойчид үлдэх ёстойг бид ногоон соёл иргэншил гэж ойлгодог.

Монгол Улсын 3 сая 500 мянган иргэд, эхийнхээ хэвлийд байгаа хүүхэд хүртэл ээжийнхээ тэр авч хэрэглэж байгаа төмрийн бэлдмэл гээд татвар төлж авч хэрэглэж байгаа тэр зүйлийг эхийнхээ хэвлийд байгаа хүүхэд хүртэл татварыг төлж байна.

Татвар төлөгчдийн мөнгийг хэрхэн хянах ёстой, яаж захиран зарцуулахад нь анхаарал тавих ёстой вэ гэдгийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо шийдэх ёстой. Анхаарч олон нийтэд гаргаж тавьдаг байх ёстой. Эрх баригчдад хяналт тавьж, зогсох зүйл дээрээ зогсоодог байх ёстой. Энэ асуудал өнөөдөр шийдэгдэхгүй л байна.

Монголд хүний эрхийн зөрчил асар олон болсон гэдгийг бүгдээрээ хэлж байгаа. Улсын Их Хурал дээр бол тодорхой хэмжээнд энэ чиглэл рүү ажил хийх гэж эрмэлзэж байгаа.

Гэсэн хэдий боловч, гэсэн хэдий боловч өнөөдөр хүний эрхийн зөрчлүүд газар сайгүй болж байгаа. Үүнийг энд байгаа эрх мэдэлтэй хүмүүс, эрхээ зөрчүүлээгүй хүмүүс мэдэхгүй ээ. Иргэд илүү их мэдэрч байгаа. Гудамжинд, зам талбай, цаг тутам байгууллага, засаг захиргаа тэр болгон дээр очиж иргэд энэ зүйлийг мэдэрч байгаа.

Тийм болохоор иргэдийн мэдэх эрхийг хангахын төлөө хийж байгаа энэ ажилдаа цөөнхийг буюу эрх баригчдаас салангид байгаа иргэдийгээ оролцуулдаг тэр мэдэх эрхийг нь дэмждэг байх чиглэл рүү улам илүү ажиллах шаардлага тулгарч байна.

Та бүхнийг тэгээд цааш цаашдаа олон зүйл дээр тунгалаг, ойлгомжтой, тодорхой байгаасай гэж бас хүсэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цэндийн Баатархүү Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Б.Бат-Өлзий Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Г.Энхтулга Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын салбар дундын зохицуулалт хариуцсан шинжээч, П.Батбаатар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга, М.Баттулга Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал, Б.Мягмарнаран “И-Монголиа академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал.

Одоо мэдээлэлтэй холбогдуулан Ерөнхий сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

4 гишүүнээр тасаллаа. Дарааллын дагуу Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууна.

Ж.Баярмаа: Сайн байна уу? Ерөнхий сайд аа. Ерөөсөө ойрд нөгөө төсвийн үеэр энэ тэр тааралдана гэж бодсон чинь ерөөсөө тааралдахгүй байж байгаад тэгээд яг энэ их, тэрнээс дутахгүй чухал асуудлын үеэр мэдээллийг нь сонслоо.

Тэгээд “5Ш” ажиллагаа мэдээж бас тодорхой зорилготой. Одоо нөгөө эцсийн үр дүнд хүрэхийг ийм зорьсон л ажил байх гэж бол найдаж байгаа.

Тэгээд авлигын талаарх мэдээллийг бүгд мэдэж байгаа. Зүгээр яах вэ нэмээд нэг юм хэлэхэд авлигаас ухарч байгаа хамгийн ноцтой ухарч байгаа 6 орны нэг болчихсон яваад байгаа.

Тэр 33 гэдэг тоо бол, оноо бол ардчилсан бус орнуудын авдаг оноо байгаа. Манай улсын ард болохоор нөгөө дайн дажинтай, зөрчил мөргөлдөөнтэй Сьерра Леон, Шри-Ланк гээд улс манай өмнө жагсаж яваа. Беларусь Улс бас бараг тоталитар дэглэмтэй улс манай өмнө явж байгаа.

Тэгэхээр манайх авлигын индексээр ямар аймаар ухарсан гэдэг нь эндээс тодорхой харагдах юм.

Тэгээд ер нь авлигатай тэмцэх жил ноднин юм уу, энэ жил байна уу бараг ингээд зарласан. Тэгээд яах вэ, үйл ажиллагаанууд маш шиг тийм уран сэтгэмж бүхий сүржин явагддаг. Тэгэхдээ үр дүн нь жаахан даржин юм уу даа гэж харагдаж байгаа.

Тэгээд энэ “Шилэн ажиллагаа”, “Шүүр ажиллагаа” бол дандаа нэг ийм үзэгдэлтэй, тохиолдлуудтай тэмцээд байгаа юм шиг санагддаг.

Гэтэл цаанаа энэ чинь шалтгаан гэж нэг юм байгаа юм. Яагаад авлига тасрахгүй байгаа юм бэ. Авлигыг бий болгоод байгаа тэр үндсэн шалтгаан, хүчин зүйлсүүд нь юу юм бэ гэдэг дээр ямар ажил хийдэг юм болоо гэдэг нь бол бас сайн тодорхойгүй байна.

Тэгээд ер нь авлигыг үүсгэж байгаа гол шалтгаануудын бүр суурь шалтгаан гэвэл төрийн алба, төрийн өмчит болон төрийн оролцоотой компаниуд тэр олон, төрийн үйлдвэрийн газрууд, энэ бүхэн чинь авлигыг үүсгэж байгаа.

Дээрээс нь маш том данхайсан төр маань өөрөө бас дахиад энэ авлигыг бий болгох энэ нөхцөлийг үүсгэж байгаа.

Дахиад хэчнээн байна вэ дээ. Энэ зөвшөөрлүүд. Элдэв янзын дарамт шахалт үзүүлэхүйц хэмжээний маш олон тооны зөвшөөрлүүд маань өөрөө бас дахиад авлигын хүчин зүйлс болдог.

Америкийн Нэгдсэн Улсын жишээ, Аргентины жишээг бид бүгд ярьдаг, мэддэг.

Хөндлөнгийн байгууллага. Яам гэж хэлэхэд хэцүү. Тэгэхдээ Efficiency DOGE [Department of Government Efficiency (DOGE)] /Төрийн удирдлагын үр ашгийн хэлтэс/ гээд яамны статусгүй хэрнээ ийм байгууллагыг байгуулаад ажиллуулах гэж байгаа. Бид бүхэн мэдэж байгаа.

Төрийн албыг бараг 75 хувиар багасгахад гэмгүй гэж тэр Вивек Рамасвами /Vivek Ramaswamy/ гээд хүн хэлсэн байгаа. Тэгээд гуравны нэгийг бол 6 триллион. Засгийн газрын зардлын гуравны нэгийг нь багасгахад, алга болгоход асуудал байхгүй явах юм байна лээ гэж ингэдэг байгаа.

Тэгэхээр танаас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэлчихлээ. Сайн байна уу гээд тэгсэн шүү дээ. Нэмэлт минут байхгүй. Байхгүй. Энэ тусгай дэг.

Энэ дэгийн тухай хуулийн 112.6. Гишүүн асуултаа асууж үг хэлэх хугацаа 3 минутаас хэтрэхгүй. Хариулт өгөх хугацаа 5 минутаас хэтрэхгүй гэж байгаа юм.

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя. Асуулт асууж, үг хэлж болно.

О.Цогтгэрэл: Ил тод байдлын талаар өнгөрсөн хугацаанд Засгийн газраас хийж байгаа, хийж ирсэн ажлын үр дүнгийн тухай тайлан явж байна л даа.

Ил тод байдлыг бид олон ач холбогдолтой гэдэг дээр бүгдээрээ л санал нэгддэг. Мэдээж хамгийн чухал нь авлигалтай тэмцэх, авлигалын асуудал ахиц дэвшил гарах, үзүүлэлтүүд, индексүүд сайжрах байх.

Хоёрдугаарт нь, авлигалаасаа гадна үүний цаад хүрээнд үр ашиг гэдэг зүйл, бүтээмж гэдэг зүйл гарч таарна. Тэр тусмаа сүүлийн үед Засгийн газраас бас нэлээн сайшаалтай нь “Төрийн бүтээмж” гэдэг үгийг их ашигладаг болоод байгаа.

Тэгэхээр эндээс би тодорхой асуулт асуух гээд байгаа нь ер нь “бүтээмж” гэдэг зүйл өөрөө тоогоор илэрхийлэгддэг зүйлийг ярьдаг. Чанарын асуудал арай өөр. Бүтээмж ярьж байгаа, төрийн бүтээмж ярьж байгаа учраас төрийн бүтээмжийнхээ тоо хэмжээг ямар байгааг ямар болгох гэж байгаа. Энэ ил тод, нээлттэй байдал, эдгээр нь энд яаж нөлөөлөх гэж байгаа талаараа бас нэг хариулт, байр суурь, бодлого, стратегиа бас хэлж өгөөч.

Би бас үүнтэй холбогдуулж нэг зүйл тодруулах гээд байгаа нь, харьцуулах гээд байгаа нь яг өнөөдөр Монгол Улсын сүүлийн арваад жилд Монгол улсын төрийн албан хаагчийн тоо 140-өөс 230 мянга орчим болоод нэмэгдчихсэн. Бид энд цахимжиж байна гээд мөнгө тавиад байдаг. И-Монголиа

амжилттай байна гээд байдаг. Яагаад төрийн алба 10 жилийн хугацаанд бараг 60, 70, 80 хувиар нэмэгдчихэж байгаа вэ? Үнэхээр цахимжилт явж байгаа бол, технологижиж байгаа бол, бүтээмж нэмэгдэж байгаа бол энэ хүний тоо чинь буурах ёстой шүү дээ. Энэ хүний тоо чинь тэр бусад баялаг бүтээдэг салбар луу, одоо тэр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хууль гээд нөгөө талдаа бизнесийн салбар нь ажиллах хүчингүй болчихсон байдаг. Төрийн алба, төрийн өмчит компаниуд нь бараг 10 жилд нэг дахин нэмэгдчихээд байдаг.

Тэгээд бид нэг талаараа, нэг гараараа техник, технологийн дэвшил, бүтээмж яриад байдаг. Тэгээд эдгээрийн хооронд нэг ийм огтлолцол гарахгүй болчихоод байгаа байхгүй юу.

Үнэхээр л тэнд бүтээмж нэмэгдээд байгаа бол хүний тоо хасагддаггүй юмаа гэхэд ядаж хэвдээ баймаар нэг ийм л нөхцөл байдлууд байгаа юм.

Тэгээд энэ бүтээмжтэй холбоотой зүйлийг аль болох тоогоор нэг зорилго зорилтдоо хүрч байгаа үр дүнгүүдээсээ бас хэлж өгөөч. Тоогоор гэдэг нь би жишээ нь сая нэг материал эргүүлж харсан. Монгол Улсын дундаж бүтээмж 2023 оны дүнгээр 22 сая орчим төгрөг байгаа юм байна. Хамгийн өндөр нь уул уурхай жилдээ 52 сая төгрөг, хөдөө аж ахуй 10 сая төгрөг, уул уурхай, хөдөө аж ахуй хоёрын хооронд 5 дахин зөрүүтэй. Дундаж нь 22 сая.

Тэгэхээр гэх мэтээр ингээд тоонууд байна л даа. Энэ Монгол Улсад өнөөдөр төрийн бүтээмж ярихад мөнгөн дүнгээр илэрхийлбэл яаж гарах вэ, гарч байгаа вэ гэдэг дээр хариулт авмаар байна.

Д.Амарбаясгалан: Төрийн бүтээмжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Төрийн албан хаагчдын тоо 220 мянга гараад байгаа.

Тэгээд яг үнэндээ эндээс төрийн жинхэнэ албан хаагч чинь ерөөсөө л 20 мянга л байгаа байхгүй юу. Нэг ёсондоо төрийн захиргааны албан хаагч нар. Тэгээд энэ тоо ер нь яагаад жил ирэх тусам өсөх болсон бэ гэхээр энэ сургууль баригдахаар, цэцэрлэг баригдахаар, эмнэлэг баригдахаар ингээд л төрийн албан хаагчдын тоо нэмж байгаа харагдаад байдаг. Сургууль баригдахаар.

Тэгэхээр энэ 220 мянгын чинь бараг 200 мянга нь төрийн үйлчилгээний, бусад улс төрийн албан хаагч нар хамаараад байгаа байхгүй юу.

Тэгэхээр төрийнхөө жинхэнэ албан хаагч нар дээрээ хэт их ачаалал байгаад байна вэ гэдэг бүтээмж, тэр нөгөө input, output гээд байгаа байгаа нөөцийг зөв хуваарилаад гарцаа бий болгож чадахгүй байгаатай л холбоотой.

Тийм учраас ирэх онд Засгийн газраас төрийн албаны шинэчлэл, эрх зүйн реформыг хийнэ гэж төлөвлөснийхөө дагуу Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлагад бид үндэслээд төрийн албаны ерөнхий хуулийг өргөн барина.

Энэ хүрээндээ төрийн улс төрийн алба тусдаа. Төрийн захиргааны алба тусдаа.

Ингээд яг гаднын жишгийн дагуу нөгөө public service, CV service гэдэг хоёроо ангилаад “Нийтийн үйлчилгээний алба” гэж салгаж өгөөд Хөдөлмөрийн хуулиар зохицуулдаг болгохгүй бол багш, эмч нарыгаа өөр ямар ч арга зам байхгүй ээ гэж хэлмээр байна.

О.Цогтгэрэл даргын хэлж байгаа яг үнэн. Үнэхээр энэ цахимжилтыг нэмүүлэхийн хэрээр яагаад энэ ачаалал буурахгүй байсан юм бэ, чагаад цомхотгол хийгдэхгүй байсан юм бэ гэхээр нэгд дүрэм, журмын түгжрэл байсан.

Тийм учраас бид 109 хуульд өнгөрсөн парламент өөрчлөлт оруулсан. Дахиад энэний араас 70 хуулийн асуудал яригдаж байгаа. Нөгөө цааснаас салъя гэхээр цаасаар заавал шаардана гээд хуультай. Олон тийм асуудлууд байгаа.

“И-бизнес” гэдэг бизнесийн платформ хийгээд бараг 100 зөвшөөрлийг цахимаар олгоод байхад заавал үнэт цаас хэвлээд та нарт зөвшөөрөл өгнө шүү гээд хуультай. Органик хуульд нь. Түүнийг зохицуулахын тулд дахиад бид үүн дээр 30 хуулийн өөрчлөлтийг хийж байж нөгөө төрийн албан хаагч нар чинь асуудалгүйгээр ажиллах гээд байгаа юм.

Дээрээс нь мэргэжлийн холбоон дээр 360 зөвшөөрөл Зөвшөөрлийн хуулиар зохицуулснаас 100 зөвшөөрлийг мэргэжлийн холбоонд шилжүүлэх бололцоо байгаа.

Ингэж чадах юм бол төрийн албаны албан хаагчдын энэ нийтийн үйлчилгээ эрхэлж байгаа хүмүүс зүгээр мэргэжлийн холбоонд шилжих ёстой. Хуульчдын холбоо шиг, Өмгөөлөгчдийн холбоо шиг олон холбоо тусгай зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлдэг, сургалтаа явуулдаг, судалгаагаа хийдэг, төрийн зарим чиг үүргийг шилжүүлдэг болно.

Үүнийг Мэргэжлийн холбооны хуулиар зохицуулсан. Одоо Улсын Дээд шүүх бүртгэж эхэлж байгаа.

Тэгэхээр ер нь зарим чиг үүргээ мэргэжлийн холбоонд шилжүүлэх нэг ийм алхам байна гэдгийг бас хийж өгнө.

Ирэх оноос Засгийн газар энэ “их өгөгдөл”-д суурилсан шийдвэр гаргахтай холбогдуулаад real time-аар бүх мэдээллүүдийг хянадаг болсон. Ингээд сая улсын хэмжээнд нэгдсэн ERP систем хэрэглэж эхлээд аймаг анх

удаа Засгийн газар луу шууд бичгээ цахимаар шийдэхэд доор доор нь хариу илгээдэг болгосон.

Тэгэхээр энэ дээрээс цаасгүй засаг арга хэмжээний хүрээнд жилд 20 тэрбум төгрөг хэмнэнэ.

Тэгэхээр ер нь бүтээмжийг нэмэгдүүлнэ гэдэг бол салбар болгоны асуудал. Ер нь орц, гарцын асуудал. Байгаа нөөцөө хэрхэн зөв хуваарилах вэ. Үүнд ямар хууль саад тотгор учруулж байна вэ гэдэг саадуудыг арилгах ийм цогц арга хэмжээг төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд авч хэрэгжүүлнэ.

Эдгээр 6 чиглэлийн ажлуудыг хийх юм бол төрийн бүтээмжийг 26 хувиар өсгөнө гэдэг ийм зөвлөгөөг сая OECD-гийн зөвлөмж дээрээс ингэж өгсөн.

Тэгэхээр бид 6 ийм чиглэлийн арга хэмжээг ирэх онд авч хэрэгжүүлнэ. Энэ бол бас ажлаа эхэлсэн. Ямар ч байсан одоо цаас бичиг нэхээд байдаггүй болохоос авхуулаад явахад л ядаж 20 тэрбум төгрөг хэмнэж байна. Ядаж бид одоо нэг тайлан мэдээллийг, үнэлгээнүүдийг авахын тулд түүнийг зүгээр статистик гэдэг энэ real time-аар аваад хараад Засгийн газрын гишүүд e-cabinet-аараа хараад хянаад шийдвэр гаргалт нь өөрөө ухаалаг болж байна.

Ингээд ирэх онд сая Ерөнхий сайдын Та бүхэнд мэдээлэл дээр гарсан энэ төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийнхаа засаглал, ил тод байдлыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр бид энэ хуулийг 01 дүгээр сарын 10-ны дотор Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Ингээд татан буулгах, нэгтгэх, нийлүүлэх, хөрөнгө босгох чиглэлээр листэд болгох ажлуудыг шат дараалалтай хийнэ. Ингээд албан газар, төрийн өмчийн компани гэдэг хоёр л статус бий болно. Ингэснээрээ төрийн өмчит болон орон нутгийн өмчийн компани 40 хувь буурна.

Ингэж чадах юм бол тэр хэрээрээ бүтээмж нэмэгдэнэ. Мэдээж энэ хуулиар бид төр ямар бизнест оролцохгүй вэ, оролцох вэ гэдгээ 10 жилээр зарлана. Их Хурал өөрөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: “5Ш” ажиллагааны хүрээнд “Шил” гэдэг мэдээллийг өнөөдөр хийж байна.

Тэгэхээр түрүүн 118-ын бүлгийн гишүүн Ерөнхий сайдтай сайн байна уу гээд хэлчих шиг болсон. Бодвол сайн байна гэдэг хариултыг нь өгвөл бас шилэн талдаа орох байх.

“Эрх мэдэл өөрийгөө хянадаггүй бусдыг хянадаг” гэж би түрүүн индэр дээрээс хэлсэн.

Та бүхний эрх мэдэл бол бүх эрх мэдэл 100 хувь 118-ын бүлэгт 3 намд хадгалагдаж байгаа. Тэр битгий хэл 118-ын бүдүүн бүлэг маань цөөнхийн эрх мэдлийг хуваалцдаг болчихсон. Цөөнх гээд энэ индэр дээрээс үг хэлэх хэрэг байдаг юм уу.

Яг үнэндээ хараад байхаар тэгээд байгаа шүү дээ. Бие биеэсээ асуулт асуугаад, одоо энэ засаг бүрдүүлж байгаа 3 намын сайд нарын нэгнээс нь асуухад өөр намын сайд өмнөөс нь хариулж өгөөд байгаа шүү дээ. Хэн асуухаас хамаараад.

Энэ чинь олонх юм уу, цөөнх юм уу. Энд Улсын Их Хурал дээр байгаа дэгийн тухай дэгтэй холбоотойгоор байгаа энэ нөхцөл байдал нь Засгийн газарт хэрэгтэй байгаад байгаа юм уу, хэрэггүй байгаад байгаа юм уу? Аргагүйн эрхэнд дэгийн хууль нь ийм учраас өнөөдөр бид яах ч аргагүй л байдалд явж байна.

Үүнийгээ өөрчилъе. Засгийн газар кабинетын зарчмаар ажилладаг гээд үүнийгээ Их Хурлаа, Засгийн газраа хоорондын харилцааг нь шилэн байлгах, бусад шийдвэрүүд нь шилэн байхад нь дэм болгох үүднээс энэ дээрээ маш олон л хуулийн төсөл Засгийн газар санаачилж оруулж ирдэг. Оруулж ирвэл амар биш үү.

Ил тод байдлаа яаж хангах гээд байгаа юм бэ? Ямар арга хэрэгсэл, ямар хэлбэрээр, юу хийж байж ил тод байдлыг хангах юм. Ил тод байдлыг хангана гэдэг чинь ерөнхийдөө бид шилэн гээд яриад ирэхээрээ дандаа засаг талын, эрх баригч талын нээлттэй ил тод байдал гэдэг талаасаа хандаад эхэлдэг.

Нөгөө талдаа буюу иргэдийн мэдэх эрх гэдэг талаасаа хэр хандаж чадах юм бэ? Ил тод байдал чинь түүндээ хүрч үйлчилж чадах юм уу?

Ямар нэг хэмжээгээр шүүмжлэл хэлсэн, ямар нэг хэмжээгээр юмор хэлсэн, шоглоод ганц үг хэлсэн хүмүүс ч гэсэн их бага хэмжээгээр шийтгэл аваад л байгаа шүү дээ.

Хүн намын нараа П.Наранбаяр сайд руу өндөг шийдлээ гээд Зөрчлийн хууль дээрээ тийм л юм байж байгаа. Тэгээд долоо хоног баривчлагдаж л байна. Шүүх бол тэр чинь арга байхгүй шүү дээ. Хуульд дээр нь тийм л бичээтэй байгаа юм чинь. Тэрийгээ л хэрэглэнэ. Өнөөдөр бид энд дэгийн хуулийн дагуу аргагүйн эрхэд ийм нэг юм хэлээд байж байна.

Ерөнхий сайдаа шүүмжилж асуулт асуунгуутаа өөрийнхөө намын хүнээс хариулт авдаг ийм зүйл байж болох юм уу? Үүнийгээ өөрчлөхгүй юм уу?

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Түрүүн Б.Жаргалан гишүүний асуултад гарсан. Үгэнд гарсан. Сая Б.Батбаатар гишүүний асуултад гарч байна.

Ил тод байдлын тухай. Ил тод байдал чухал. Түрүүний тэр Төрийн болон албаны нууцын тухай хуулийн талаар бас Б.Жаргалан гишүүн ярьж байна.

Энэ албаны нууц гэдэг ангилалд оруулаад хаалттай худалдан авалт хийдэг. Эндээсээ хөрөнгө мөнгө завшдаг ийм зүй бус явдлууд зөндөө гарсан. Хүний эрхийн багц хуулиудыг Засгийн газраас өргөн барьж байгаа. Энэ хуулиуд дотор Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулъя. Албаны нууцад өөрсдийнхөө хууль бус үйлдлийг далдлах зорилгоор албаны нууцад хамаарахгүй байх гэсэн энэ харилцааг оруулж байгаа.

Дээрээс нь ил тод байдал бол энэ авлигатай салшгүй холбоотой яригддаг зүйл. Үнэхээр сүүлийн жилүүдэд Монгол Улсын авлигын нөхцөл байдал дордож байгаа.

Тэгэхдээ хамтарсан Засгийн газраас авлигын эсрэг багц хуулийн төслүүдийг өргөн мэдүүлэх гэж байгаа. Эхний танилцуулга нь Засгийн газарт хийгдчихсэн. Засгийн газар дээр. Энэ хүрээнд Авлигын багц хуулиуд, тэр дундаа нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах, нөхөн төлүүлэх тухай хууль гэсэн ийм хууль бас орж ирж байгаа.

Ер нь энэ хамтарчихлаа, та нар авлигын эсрэг тэмцэл чинь юу болох вэ, яаж хийх вэ гэж байгаа юм. Хамтрах ерөөсөө авлигын эсрэг тэмцэлд хамаагүй. Тэр хамтарна уу, ямар нам байна вэ, энэ танхим дотор сууж байгаа хүн байна уу, урьд нь төрийн өндөр албан тушаалд байсан уу энэ авлигын эсрэг тэмцэлд ерөөсөө хамаагүй. Ил далдаар бас янз янзын мессеж өгч байгаа. Зарим нэг хууль хяналтын байгууллагын дарга нараар дамжуулж дэмий юм биш үү дээ. Хүн хилсдүүлэх гэж байгаа юм биш үү. Ийм хууль гаргаад хэрэггүй дээ гээд тийм нөхөрсөг байдлаар гэдэг нэрийн доор зөндөө сануулгууд өгч байгаа, ирж байгаа.

Тэгэхдээ Монгол Улсын Засгийн газар энэ авлигын эсрэг тэмцлээсээ ухрахгүй. Үүнийгээ бид хийж хэрэгжүүлэх ёстой. Ингэж байж урагшаа явна.

Ардчилсан намын гишүүн байж байж хөрөнгө хураах тухай ярилаа гээд бас яриад байгаа. Тэр Ардчилсан намын гишүүн байх, аль намын гишүүн байх энд ерөөсөө хамаагүй. Хулгай бол хулгай байдаг. Хулгайч бол хулгайч байдаг. Авлигал бол авлигал байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3-д заачихсан байгаа. Монгол Улсын иргэн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах эрхтэй. Шударгаар. Хэн ч хулгай хийхгүй, хэн ч авлига авахгүй.

Тэгэхээр энэ чиглэлийн багц хуулийн төсөл орж ирнэ. Тэгээд энэ хуулийн төслүүд батлагдаад сая бас Засгийн газраас өргөн мэдүүлж байгаа хүний эрхийн багц хуулиуд батлагдах юм бол хүний эрхийн нөхцөл байдал гэдэг өөрөө ил тод байдалтай бас холбоотой. Авлигын индексэд нөлөөлдөг зүйл. Өмнөх өмнөх сайдууд, нэн ялангуяа өмнө нь Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байсан Х.Нямбаатар сайдын үеэс санаачилга гаргаад энэ авлигын индексийг бууруулах талаар явж байсан зөндөө ажлууд байна.

Үүнийг сүүлийн 6 сарын хугацаанд маш идэвхжүүлж байгаа. Ерөнхий сайдын өгсөн үүргийн дагуу Transparency International байгууллагын удирдлагууд, олон улсын байгууллагууд бид энэ хүний эрх, авлигын чиглэлийн асуудлуудаа танилцуулж байгаа.

Тийм учраас цаашдаа авлигын индекс буурна гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү сайд нэмж хариулт өгье. 2 минут.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Цахим шилжилт тодорхой хэмжээнд амжилттай явж байгааг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргадаг цахим засаглалын хөгжлийн индекс бол тодорхойлж байдаг.

Монгол Улс бол 193 улсаас 28 байр ахиж 46 дугаар байранд орсон. Ази тивдээ бол 13 дугаар байранд орж байна гэсэн үг. Бусад олон индекс үзүүлэлт 90-ээс 100 гаруй, 103-ын хооронд байдаг. Цахим засаглалын хөгжлийн индекс харьцангуй сайн явж байна.

Гэсэн хэдий ч иргэн очоод төрийн байгууллага дээр үйлчилгээ аваад дараагийн төрийн байгууллага дээр үйлчилгээ авах гэхээр цаасаар ямар нэгэн лавлагаа тодорхойлолт нэхдэг байдал бас хэвээрээ байна. Үүнийг нэг мөсөн шийдэх гэж олон ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хяналт үнэлгээний үндэсний хороо, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Бүтээмжийн хороо, Ч.Анар гишүүн гишүүнээр ахлуулсан Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гараад цахим шилжилт үнэхээр амжилттай байгаа бол төрөөс үзүүлж байгаа энэ олон лавлагаа, үйлчилгээ, зөвшөөрлүүдийн давхцалыг арилгаж, процессыг нь яг хэдэн хувиар цөөлөх юм бэ, хэдэн ажлын байрыг хэмнэх юм бэ гэдэг бодит хэмнэлтийн дүнг энэ 2025 оны 01 дүгээр сар гэхэд бид Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болгохоор ажиллаж байгаа.

Үүний үр дүнд тэр цахим шийдэл гэдэг технологийн шийдлийн цаана нь байгаа төрийн үйл ажиллагааны процесс, тэр давхцал цэгцэрч, иргэдэд илүү ил тод болно.

Хоёрдугаарт, ил тод байдлын тухай Улсын Их Хурлын гишүүд асууж байна.

“Shilenhyanal.gov.mn”, “shilen.gov.mn” гэдэг сайтуудын энэ хяналтыг мэргэжлийн холбоо, олон нийтийн байгууллага, төрийн бус байгууллагуудад хяналтыг нь бид шилжүүлэхээр ажиллаж байна.

Ингэснээр иргэд, төрийн бус байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд бидний төрийн үйл ажиллагаа, мэдээллээ цаг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Баярлалаа.

Би өнөөдрийн үг дээр зориуд үе солигдсон шинэ парламент нөлөөтэй толины тусгалгүйгээр авлигын суурь асуудлуудыг олж тогтолцооны хувьд засаж чадна гэдэгт итгэж байна гэдэг ийм үгийг илэрхийлсэн байгаа. Тэгээд шинэ парламент авлигын тухай анх удаа ярьж байна. Өмнө нь авлигалтай холбоотой олон асуудлууд болсон.

Авлигалтай холбоотой асуудлуудыг анхаарлын төвд оруулахын тулд зориуд “5Ш” ажиллагаа гэж нэрлэсэн. Энэ нэршлээрээ олон нийт анхаарч нийгмийн дэмжлэг бас энэ авлигалын асуудлууд дээр анхаарлаа илүүтэй төвлөрүүлээсэй гэдэг ийм агуулгаар хандсан. Өнгөрсөн хугацаанд хэд хэдэн зүйл хийгдсэн.

Нэгдүгээрт, сангууд болон төрийн байгууллагуудын мэдээллүүд далд байсныг бүгдийг нь ил болгосон. Энэ асуудлуудаар олон олон сангууд дээр асуудал үүссэн. Нам харгалзахгүй л асуудлууд үүссэн. Өнгөрсөн бүх л цаг хугацааг дүгнэх шаардлагатай гэж л үзсэн.

Өмнөх парламент дээр нэлээдгүй ч эмоцтой ийм асуудлууд болж байсан. Хөгжлийн банкны чанаргүй зээлүүдийг нээлттэй болгох үед талбай дээр жагсаал ч болж байсан. Нүүрсний худалдан авалтыг нээлттэй болох үед бас жагсаал болж байсан. Та бүхэн санаж л байгаа байх. Олон олон парламентын гишүүд холбогдож хуулийн байгууллагаар татагдаж байсан. Та бүхэн энэ үйл явдлыг бас харж л байсан байх.

Тийм учраас энэ бүх үйл явдлуудыг гаргаж, ингээд парламентын төлөөллийг нэмэх нь зүйтэй. Олон ургалч үзэлтэй ийм парламент байх нь өөрөө зөвхөн тойрогт барьцаалагдахгүй, асуудлыг илүү том зургаар нь харахад бол чухал. Мөн бүсчилж асуудлыг томсгох нь ч чухал гэдэг агуулга бас л тэр үеийн дүгнэлтээс гарч байсан гэдгийг хэлье.

Тэгээд би парламентаас одоо яг энэ авлигын асуудлууд дээр гаднаас харах нэг өөр. Дотор орж ирээд харах бол бас нэг өөр байдаг. Зориуд би одоо бас ингээд О.Алтангэрэл сайд, намын хамт олондоо ч гэсэн хэлж байсан.

Хууль зүйн сайд, Ерөнхий сайд хоёр бол өөр намаас байх нь чухал гэдэг зүйлийг хэлж байсан. Яагаад гэвэл урьд нь шүүх дээр ч юм уу ийм асуудлууд дээр хэрэг гацаад байна, ийм асуудлууд болоод байна гэхээр яг нэг намын өнцгөөс хараад, тэр нь бас нэг тийм олигтой яг ийм бодитой дүгнэлт рүү нийгмийн хувьд очиж чаддаггүй юм билээ.

Одоо би бас О.Алтангэрэл сайдад хэлж байгаа. Одоо ямар ч нөлөөтэй толины тусгалгүйгээр нам гэдэг эрх ашгийг хойш нь тавиад яг бодитой байдалдаа дүн шинжилгээ хийгээд үзээрэй. Хэдэн хэргүүд хаанаа гацаж байгаа юм. Шүүх дээр хэдэн хэрэг очоод буцсан юм, яагаад ингээд байгаа юм гээд.

Тийм учраас 126 гишүүнтэй энэ парламент авлигын асуудлыг одоо зөвхөн нэг, хоёр кэйс биш яг бодит асуудал яг хаанаа байна гэдгийг илүү тийм углуургаар нь хандаасай гэж хүсэж байгаа юм.

Тийм учраас энэ асуудлууд дээр өнөөдөр бас энэ хөрс суурь бүрдүүлж байгаа асуудал. Мөн цахим засаглалтай холбоотой хэсгийг нь хөндөж ярьж байна. Цаашлаад төрийн өмчит компаниудын ил тод засаглалын талаар асуудлыг нэлээдгүй ярьсан. Тэгээд бид 01 сарын 10-даар өргөн барьчихна.

Ингээд хэдүүлээ олон жил ярьсан энэ төрийн өмчит компаниудыг цэгцэлье. Тэгээд бусад татвар, нийгмийн даатгалтай холбоотой ч бас ийм багц зөвлөмжүүд байгаа.

Үүнийгээ бас цэгцэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо. /алх цохив/

Дараагийн асуудалд орёё.

Зургаа.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль,

тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

Улаанбаатар хотын Дулааны III цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Жаргалсайханы Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Зарчмын зөрүүтэй санд унасан боловч ажлын хэсэгт Та бүхэн бас бодолцоорой гээд захиас байдлаар нэг зүйлийг хэлэх гэсэн юм.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу нийлүүлж байгаа нүүрсний нийт хэмжээ одоо энэ 11 заалттай тогтоол дээр зөвхөн Гашуунсухайтаас гадна дараагийн Шивээхүрэн боомт, Бичигт боомт гээд, сая бас Ховдынх орлоо. Ингээд өргөн хүрээг хамраад байгаа.

Тэгэхээр нийт хэмжээ нь 120 сая тонн гэнэ үү, 150 гэнэ үү, тэр нэг зорилтот тоогоо тавьж өгөөч ээ гэж. Үүнийг тавихгүй бол их хэмжээний энэ хөнгөлөлттэй үнэтэй нүүрс чинь зах зээл унасан тохиолдолд экспортын дийлэнхийг эзлээд нийтээрээ бүх портоор, бүх боомтоор явах үнэ нь унах ийм эрсдэл бол байгаа.

Тэгэхээр хоёр улс урт хугацаандаа тогтвортой ажиллана. Засгийн газрын хүрээнд харилцан ойлголцсон бол тэр зорилтот тоогоо тавьж өгөх талаар бас бодолцоорой л гэж хэлмээр байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Найруулга дээр санал хэлэх ёстой.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

2024 оны Улсын Их Хурлын отгон нэгдсэн хуралдаан хэлэлцэх асуудлаа хэлэлцээд дууслаа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүддээ талархал дэвшүүлье.

Ирж байгаа 2025 ондоо илүү их идэвх зүтгэлтэй, эрүүл энх, саруул сайхан байх болтугай гэж хүсэн ерөөе.

Ажлын өндөр амжилтыг хүсье. /алга ташив/

Өнөөдрийн нэгдсэн хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 6 цаг 10 минут үргэлжилж, 16 цаг 56 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД